



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 119


Төрийн ордон, Улаанбаатар хот

Төрийн ёслолын журам батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн ёслолын журмыг хавсралтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
ХУУЛБАР ҮНЭН
Тамгын газрын дэд дарга



ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ

Б.Нэргүй



ТӨРИЙН ЁСЛОЛЫН ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Төрийн ёслолын дэг жаягийг тогтоож, түүнд оролцогчдын үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

1.2. Төрийн ёслол нь үндэсний баяр, түүхэн ой, онц чухал үйл явдлыг тэмдэглэх, төр, засгийн удирдагчдын оролцох ёслол болон гадаад оронд хийх айлчлал, гадаадын зочин төлөөлөгчдийг хүлээн авах зэрэг ёслолын арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагаа болно.

2. Төрийн ёслолын чиг үүрэг

2.1. Монгол Улсын хэмжээнд нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийг ёслол тэмдэглэх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, бусад албан тушаалтан тангараг өргөх, тамга шилжүүлэх, төрийн дээд шагнал олгох, цол хүртээх, эмгэнэн гашуудах зэрэг төрийн үндэсний ёслолтой холбоотой арга хэмжээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төрийн ёслол хариуцсан нэгж /цаашид "Төрийн ёслолын алба" гэх/ зохион байгуулна.

2.2. Төр, засгийн удирдагчид гадаад оронд айлчлах, гадаадын дээд, өндөр хэмжээний зочид Монгол Улсад айлчлах, Итгэмжлэх жуух бичиг хүлээн авах, Дипломат төлөөлөгчийн газруудтай харилцах зэрэг Монгол Улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэх дипломат ёслолтой холбоотой арга хэмжээг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага /цаашид "Гадаад хэргийн яам" гэх/-ын төрийн дипломат ёслол хариуцсан нэгж /цаашид "Ёслолын газар" гэх/ зохион байгуулна.

3. Төрийн ёслолын зарчим

3.1. Төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэг бол төрийн ёслолын үндсэн зарчим мөн.

3.2. Үндэсний болон дипломат ёслол нь бодлогын хувьд нэгдмэл байна.

3.3. Төрийн ёслол нь шуурхай, зардал, чирэгдэл багатай бөгөөд ёс жаяг, хүндэтгэлийг дээдэлнэ.

3.4. Үндэсний ёслол нь үндэсний уламжлалт ёс заншил, сонгодог ёс, шинэ хандлагыг хослуулан хэрэглэж, байнга боловсронгуй болгож байна.

3.5. Дипломат ёслол нь олон улсын жишиг хэм хэмжээ болон үндэсний онцлог, уламжлалт ёс заншилд нийцсэн уян хатан байх зарчимд тулгуурлана.

4. Төрийн ёслолын ахлал

4.1. Төрийн ёслолын ахлалыг дараах байдлаар тогтооно:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч;
2. Улсын Их Хурлын дарга;
3. Ерөнхий сайд;
4. Үндсэн хуулийн цэцийн дарга;
5. Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч;
6. Улсын Их Хурлын дэд дарга;
7. Шадар сайд;
8. Улсын Их Хурлын гишүүн¹;
9. Засгийн газрын гишүүн /дарааллыг Засгийн газрын тухай хуулийн дагуу/²;
10. Улсын Ерөнхий прокурор;
11. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
12. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
13. Үндсэн хуулийн цэцийн гишүүн;
14. Улсын Дээд шүүхийн шүүгч;
15. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
16. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;
17. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;
18. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга;
19. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга;
20. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын албан тушаал хашиж байсан зүтгэлтнүүд /алба хашиж байсан оны дарааллаар/;
21. Ерөнхий аудитор;
22. Авлигатай тэмцэх газрын дарга;
23. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Аймгийн цагаан толгойн үсгийн дарааллаар/;
24. Аймгийн Засаг дарга /дээрхтэй адил/;
25. Төрийн албаны зөвлөлийн дарга;
26. Монгол банкны Ерөнхийлөгч³;
27. Үндэсний статистикийн хорооны дарга;
28. Сонгуулийн ерөнхий хорооны дарга;
29. Хүний эрхийн үндэсний комиссын дарга;
30. Санхүүгийн зохицуулах хорооны дарга;
31. Ерөнхий прокурорын орлогч;
32. Авлигатай тэмцэх газрын дэд дарга;
33. Дэд сайд /Яамныхаа дарааллаар/;
34. Ерөнхийлөгчийн зөвлөх;
35. Улсын Их Хурлын даргын зөвлөх;
36. Ерөнхий сайдын зөвлөх;
37. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга;

¹ УИХ дахь намын бүлгийн дарга, Байнгын хорооны дарга нар УИХ-ын гишүүдийн түрүүнд эрэмбэлэгдэнэ.

² Гадаад харилцаатай холбоотой үйл ажиллагаанд гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бусад гишүүний түрүүнд эрэмбэлэгдэнэ.

³ 26-30 дугаарт хамаарах албан тушаалтан тухайн байгууллагын байгуулагдсан он цагийн дарааллаар.

38. Улсын Их Хурлын Тамгын газрын нарийн бичгийн дарга;
39. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;
40. Яамны Төрийн нарийн бичгийн дарга /яамныхаа дарааллаар/;
41. Засгийн газрын агентлагийн дарга /Ерөнхий сайд, Шадар сайд, Сайдын эрхлэх хүрээний асуудлын дарааллаар/;
42. Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч;
43. Үндэсний статистикийн газрын дэд дарга;
44. Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга;
45. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн;
46. Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн;
47. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн;
48. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга;
49. Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч.

4.2 Төрийн ёслолын ахлалыг ёслолын үйл ажиллагаанд оролцох үед баримтална.

4.3. Төрийн ёслолын гадаад арга хэмжээний үед гадаад улсын ёслолын албатай тохиролцсоны дагуу Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын гишүүний өмнө эрэмбэлэгдэж болно.

4.4. Төр, засгийн удирдагчид гадаад улсад хийж байгаа болон гадаадын өндөр, дээд хэмжээний зочид Монгол Улсад хийх айлчлалын үеэр Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд, олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч нь ёслолын ахлалаар Гадаад хэргийн сайдын дараа орно.

Нэг. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЁСЛОЛ

5. Нийтээр тэмдэглэх баярын өдөр

1.1. *Монголын тулгар төр, Их Монгол Улс байгуулсны болон Ардын хувьсгалын ой - Үндэсний их баяр наадам*

5.1.1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ой /цаашид “Наадам” гэх/-г жил бүр тэмдэглэнэ.

5.1.2. Монголын тулгар төрийн болон Их Монгол Улс байгуулсны тэгш ойг арван жилийн давтамжтайгаар Наадамтай хамтатган тэмдэглэнэ⁴.

5.1.3. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо /цаашид “Зохион байгуулах хороо” гэх/ наадмыг уламжлалт ёс заншилд тулгуурлан улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хариуцна.

5.1.4. Наадмаар төрийн ёслолын дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

7 дугаар сарын 10-нд:

а) Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх болон Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх ёслолыг зохион байгуулна. Ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн

⁴ Засгийн газраас гарсан комисстой хамтран зохион байгуулна.

цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Засгийн газрын болон Улсын Их Хурлын гишүүд, Улсын ерөнхий прокурор, Батлан хамгаалах болон бусад яам, нийслэлийн удирдлага, Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар /хүсэлтээр нь/, Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намууд, ахмадын байгууллага, иргэдийн төлөөлөгчид оролцоно. Гадаадын зочид, төлөөлөгчдийг хүсэлтээр нь оролцуулж болно. Төрийн хүндэт харуул /цаашид “Хүндэт харуул” гэх/, Зэвсэгт хүчний жанжин штабын Үлгэр жишээ Үлээвэр найрал хөгжим /цаашид “Үлээвэр найрал хөгжим” гэх/ жагсана;

б) Хүндэтгэлийн урлагийн тоглолт болно. Урлагийн тоглолтод төрийн ёслолын ахлалд хамаарах албан тушаалтнууд, Зохион байгуулах хорооны дарга, гишүүд болон Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар гэргий/нөхөр/-н хамт, албаны бусад хүн, иргэдийн төлөөлөл, гадаадын зочин төлөөлөгчид, урилгаар оролцоно. Урлагийн тоглолт эхлэхийн өмнө Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ. Тоглолтод тухайн жилийн шилдэг бүтээлүүдээс сонгон оруулах чиглэл баримтална;

в) Төрийн Их цагаан туг /цаашид “Төрийн туг” гэх/-ийг Төрийн ордныг нар зөв тойруулан цэнгүүлж буцаан зална;

г) Засгийн газрын хүндэт өргөмжлөл гардуулах ёслол Төрийн ёслол хүндэтгэлийн Их танхимд болно;

д) Тэгш ойгоор Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан эсхүл баярын хурал зохион байгуулна. Төрийн дээд, өндөр албан тушаалтан баярын хуралд илтгэл тавина. Хурлыг нээхэд Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ.

7 дугаар сарын 11-нд:

е) Энэхүү журам болон Зохион байгуулах хорооны баталсан хөтөлбөрийн дагуу Наадмын нээлтийг төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулна;

-Төв цэнгэлдэх хүрээлэнгийн **Төв асарт** Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Засгийн газрын болон Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын ерөнхий прокурор, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар гэргий/нөхөр/-н хамт, **Зүүн асарт** Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн гэргий/нөхөр/-н хамт, дээд, өндөр хэмжээний гадаадын зочин төлөөлөгчид, **Баруун асарт** төрийн ёслолын ахлалын 12-51-д хамаарах албан тушаалтнууд урилгаар сууна;

-Төв цэнгэлдэх хүрээлэнд Төрийн далбаа мандуулна. Хүндэт харуулын цэргүүд Төв цэнгэлдэх хүрээлэнд Төрийн тугийг хүндэтгэн залах ёслолоор Наадам эхэлнэ. Төрийн тугийг залмагц Монгол Улсын Ерөнхийлөгч Төв асраас цагаан эсгий дээгүүр залран, тусгайлан зассан тавцанд гарч, Наадмын ёслолын ажиллагааг нээж үг хэлнэ. Ерөнхийлөгчийн баруун гар талд Зохион байгуулах хорооны дарга, зүүн гар талд Төрийн ёслолын албаны дарга дагалдана. Үг хэлж дуусахад Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ. Ерөнхийлөгч

Төрийн туганд ёслон, Төв асарт ирж суудалдаа заларсны дараа нээлтийн бусад үйл ажиллагаа хөтөлбөрийн дагуу болно. Үндэсний бөхийн барилдааны өмнө уртын дуучид Монгол ардын уртын дуу “Түмэн эх”-ийг дуулж, морин хуурчид хуурдана. Үндэсний бөхийн барилдааны нэгийн даваа эхэлнэ.

-Төр, засгийн удирдагчид бөхийн барилдааны нэгийн давааны дундуур үндэсний сурын болон шагайн харвааны талбайд очиж сум тавьж, шагай харваж болно. Мөн хурдан морины уралдааны барианы газарт хүрэлцэн очиж морины уралдаан үзэж болно;

ё) Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн хүндэтгэлийн дайллага хийнэ.

-Дайллагад төрийн ёслолын ахлалын 2-51-д хамаарах албан тушаалтнууд, Монгол Улс дахь Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар гэргий/нөхөр/-н хамт, гадаад улсын дээд, өндөр хэмжээний зочин төлөөлөгчид, Зохион байгуулах хорооны гишүүд, урьд жилийн наадамд түрүүлсэн, үзүүрлэсэн бөхчүүд, түрүүлсэн морины уяачид, түрүүлсэн мэргэн харваачид болон эрхэлсэн салбартаа амжилт гаргасан иргэдийн гурван үеийн төлөөллийг урилгаар оролцуулна;

-Дайллага хийх байрны үүдэнд Хүндэт харуул, дайллагын байр уруу очих зам дагуу морьтой Хүндэт харуул зогсоно;

-Дайллага хийх байранд Монгол Улсын Төрийн далбааг мандуулна;

-Ерөнхийлөгч төрийн хүндэтгэлийн дайллагыг нээж үг хэлнэ. Дараа нь Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ.

ж) Орой нь ёслолын буудлага хийнэ.

з) Бүх нийтийн цэнгүүн зохион байгуулж болно.

7 дугаар сарын 12-нд:

и) Наадам үргэлжилнэ. Төр, засгийн удирдагчид хурдан морины уралдаан үзэж, уяачдын галаар зочилж болно.

й) Төр, засгийн удирдагчид Төв цэнгэлдэх хүрээлэнд ирж хүчит бөхийн барилдаан үзнэ.

к) Бүх насны айрагдсан морьдын цолыг дуудаж, Зохион байгуулах хорооны дарга морины уяачдад шагнал гардуулна.

л) Морины салбар хорооны дарга, гишүүд морь айрагдуулсан хүүхдүүдийг төв асрын индэрт дагуулан ирнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч хүүхдүүдэд бэлэг гардуулна.

м) Монгол Улсын Ерөнхийлөгч сур, шагайн харваанд түрүүлсэн харваачдад шагнал гардуулна.

н) Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дагуу Зохион байгуулах хорооны саналыг үндэслэн харваач болон бөхийн улсын цол олгох тухай Ерөнхийлөгчийн буулгасан зарлигийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга уншиж сонордуулна. Болзол хангасан харваач, бөхчүүдийг салбар Хорооны дарга нар дагуулан төв асрын индэрт ирнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч цолны тэмдэг, үнэмлэхийг гардуулна.

о) Монгол Улсын Ерөнхийлөгч түрүүлсэн, үзүүрлэсэн болон их шөвгийн бөхчүүд, хүүхдийн барилдаанд түрүүлсэн, үзүүрлэсэн бөхөд шагнал гардуулна.

ө) Монгол Улсын Ерөнхийлөгч Наадмын ёслолыг жаргааж, төв асрын индрээс үг хэлнэ. Хүндэт харуулын цэргүүд Төрийн тугийг залж, Төв цэнгэлдэх хүрээлэнг нар зөв эргэн гарч Төрийн ордонд байрлуулна.

п) Төр, засгийн удирдагчид болон Зохион байгуулах хорооны дарга их шөвгийн бөхчүүдийг Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хүндэтгэлийн өрөөнд хүлээн авна.

5.2. Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр

5.2.1. Монгол Улсын Ерөнхий сайд Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр ард түмэндээ мэндчилгээ дэвшүүлнэ.

5.2.2. Төрийн тамганы хөшөөнд цэцэг өргөх ёслол болно. Ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Засгийн газрын болон Улсын Их Хурлын гишүүд, Улсын Ерөнхий прокурор оролцоно.

5.2.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар дипломат дээд цол олгох ёслолыг зохион байгуулна.

5.2.4. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүд тулганы галаа бадраах ёслол үйлдэж болно.

5.2.5. Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулж болно. Бөхийн барилдааны өмнө Монгол ардын уртын дуу “Эрхэм төр”-ийг дуулж, морин хуурчид хуурдана.

5.2.6. Үндэсний эрх чөлөөний хувьсгал, тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн талаар эрдэм шинжилгээний бага хурал, үзэсгэлэн зохион байгуулж болно.

5.2.7. Төрт ёсны уламжлалаа хадгалан өвлүүлэх, түүхээ үнэн зөвөөр сэргээн таниулах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор их дээд сургууль, коллежуудад үндэсний эрх чөлөөний хувьсгалын тухай нэг цагийн хичээл заана.

5.2.8. Тэгш ой тохиосон жил тусгай хөтөлбөрөөр тэмдэглэнэ.

5.3. Цагаан сар

5.3.1. Цагаан сараар төрийн ёслолын дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

Цагаан сарын өмнө:

а) Монгол Улсын Ерөнхийлөгч 95-аас дээш нас хүрсэн иргэддээ амар мэндийн айлтгал, 100-аас дээш нас хүрсэн настан буурлууддаа амар мэндийн айлтгалыг бэлэг дурсгалын зүйлсийн хамт хүргүүлнэ.

б) Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дагуу, Зохион байгуулах хорооны саналыг үндэслэн болзол хангасан уяачдад улсын цол олгож, цолны тэмдэг, үнэмлэхийг гардуулна. Ёслолыг Төрийн ёслол хүндэтгэлийн Их танхимд зохион байгуулна.

в) Монгол Улсын сайн малчин, тэргүүний тариаланчдыг шалгаруулж, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд тэмдэг, үнэмлэх, дурсгалын зүйлсийг хүргэж гардуулна.

Битүүний өдөр:

г) Төрийн ёслолын алба, Монголын Үндэсний бөхийн холбоо, Монголын бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийд /цаашид “Гандантэгчэнлин хийд” гэх/-ийн захиргаа хамтран үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулна. Барилдааныг төрийн ёслолын ахлалд хамаарах албан тушаалтнууд, Монгол Улсад суугаа гадаадын Дипломат байгууллагын тэргүүн нар урилгаар үзэж сонирхоно.

Шинийн нэгний өдөр:

д) Монгол Улсын Ерөнхийлөгч бэлэг, бэлгэдлийн дээд цэнхэр хадаг, мөнгөн аягатай сүү өргөн ард түмэндээ мэндчилгээ дэвшүүлнэ.

е) Монгол Улсын Ерөнхийлөгч Төрийн тулганы галыг бадраана.

ё) Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар Төрийн туганд мэхийн ёсолж, Төрийн хүндэтгэлийн өргөөнд золгоно. Золгох цагийг тухайн жилийн зурлагаар тусгайлан тогтооно.

ж) Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар настан буурлуудын төлөөлөл болсон есөн ахмадыг хүндэтгэн золгоно. Золголт Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн “А” танхимд болно.

з) Гандантэгчэнлин хийдийн Тэргүүн хамба Жанрайсиг, Очирдара бурханд тухайлан залбирч Монголын ард түмний буян заяаг даатган “Мандал” өргөнө. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нар оролцоно.

и) Морин хуурын хүндэтгэлийн тоглолтыг Морин цагаас Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлнэ.

5.4. Монгол бахархлын өдөр

5.4.1. Төрийн тугийг Төрийн ордныг нар зөв тойруулан цэнгүүлж буцаан зална.

5.4.2. Монгол Улсын Ерөнхийлөгч “Чингис хааны одон” гардуулна.

5.4.3. Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Засгийн газрын болон Улсын Их Хурлын гишүүд, Улсын Ерөнхий прокурор, нийслэлийн удирдлага, Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн нар /хүсэлтээр нь/, ахмадын байгууллага, иргэдийн төлөөлөгчид оролцоно.

5.4.4. Үндэсний бөхийн барилдаан болно. Бөхийн барилдааны өмнө Монгол ардын уртын дуу “Эртний сайхан”-ыг дуулж, морин хуурчид хуурдана.

5.4.5. Монголын тулгар төрийн түүх, Чингис хаан судлалын асуудлаар олон улсын хурал, семинар, үзэсгэлэн, соёл, урлагийн бусад арга хэмжээ зохион байгуулна.

5.4.6. Төрт ёсны уламжлалаа хадгалан өвлүүлэх, түүхээ үнэн зөвөөр сэргээн таниулах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор их дээд сургууль, коллежуудад эх түүхийн тухай нэг цагийн хичээл заана.

5.4.7. Тэгш ойг тусгай хөтөлбөрийн дагуу тэмдэглэнэ.

5.5. Шинэ жил

5.5.1. Монгол Улсын Ерөнхийлөгч Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр ард түмэндээ баяр хүргэж үг хэлнэ.

5.5.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Монголын хүүхдийн байгууллагаас зохион байгуулах нийслэлийн хүүхдийн сүлд модны наадамд оролцож болно.

5.5.3. Ерөнхий сайд оны шилдэг хүүхдүүдэд батламж, шагналыг Төрийн ёслол, хүндэтгэлийн Их танхимд гардуулна.

5.5.4. Монгол Улсад суугаа гадаадын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар төр, засгийн удирдагчдад шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлнэ. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн /цаашид “Гадаад хэргийн сайд” гэх/, Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын гадаад бодлогын зөвлөх, Улсын Их Хурлын Тамгын газрын гадаад харилцааны асуудал хариуцсан нэгжийн дарга нар энэхүү ёслолд оролцоно.

5.5.5. Төрийн болон төсвийн байгууллагууд төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэх, хэвлэмэл цаасан мэндчилгээ хэвлүүлэх, бэлэг дурсгалын зүйл солилцож тараахыг тэвчиж, харин цахим хэлбэрээр мэндчилгээ дэвшүүлэх чиглэл баримтална.

5.6. Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр

5.6.1. Төр, засгийн удирдагчид амжилт бүтээлээрээ бусдыгаа манлайлж, нийгэмд сайн үйл бүтээж байгаа эмэгтэйчүүдийн төлөөллийг Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн Их танхимд хүлээн авч баяр хүргэж, Монголын нийт эмэгтэйчүүдэд мэндчилгээ дэвшүүлнэ.

5.6.2. Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан уулзалт, хурал, семинар, хүндэтгэлийн тоглолт зохион байгуулж болно.

5.7. Хүүхдийн баяр

5.7.1. Төр, засгийн удирдагчид Чингисийн талбай болон бусад газарт зохиогдох баярын үйл ажиллагаанд оролцоно.

5.7.2. Хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр эх эцэг, хүүхэд, өсвөр үеийнхэндээ баяр хүргэж үг хэлнэ.

5.7.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар алдарт эхийн одонгоор шагнах ёслолыг зохион байгуулна.

5.7.4. Ерөнхий боловсролын дунд сургуулийн төгсөх ангийн сурагчдаас оны тэргүүний сурагч шалгаруулж, Ерөнхий сайдын тэтгэлэг олгоно.

5.7.5. Монгол хүүхдийн авьяас билгийг хөгжүүлэх, дэмжих уралдаан тэмцээн зохион байгуулна.

2. Нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр

6.1. Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр

6.1.1. Монгол Улсын Их Хурлын дарга Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр ард түмэндээ мэндчилгээ дэвшүүлнэ.

6.1.2. Улсын Их Хурлаас Б.Чимидийн нэрэмжит шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулна.

6.1.3. Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийг Төрийн түүхийн музейд тэгш ойгоор буюу 5 жил тутамд залж олон нийтэд сонирхуулна.

6.1.4. Үндсэн хуулиа сахиж хүндэтгэх, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, Үндсэн хуулийн мөн чанар, үзэл баримтлал, хэм хэмжээг хүүхэд, залуучуудад ойлгуулан мэдүүлэх зорилгоор энэ өдөр их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургуулийн оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад Үндсэн хуулийн тухай нэг цагийн хичээл заана.

6.1.5. Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлнэ. Хүндэтгэл илэрхийлэхэд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Засгийн газрын болон Улсын Их Хурлын гишүүд, Улсын Ерөнхий прокурор, нийслэлийн удирдлага, улс төрийн намуудын удирдлага, Үндсэн хууль тогтоогчдын холбооны төлөөлөл оролцоно.

6.1.6. Улсын Их Хурлын даргын ивээл дор шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээнийг Төрийн ордонд зохион байгуулна.

6.1.7. Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулж болно.

6.1.8. Тэгш ой тохиосон жил тусгай хөтөлбөрөөр тэмдэглэнэ.

6.2. Эх орончдын өдөр

6.2.1. Тэгш ойн жил Засгийн газрын гишүүн тэргүүлсэн Комиссын баталсан тусгай төлөвлөгөөний дагуу тэмдэглэнэ.

6.3. Монгол цэргийн өдөр

6.3.1. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн удирдлага, цэргийн дээд цолтнууд Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөнө. Төрийн дээд, өндөр албан тушаалтнууд оролцож болно.

6.3.2. Тэгш ойн жил тусгай хөтөлбөрөөр тэмдэглэнэ.

6.4. Төрийн далбааны өдөр

6.4.1. Төрийн далбааны өдрөөр Чингисийн талбайд Төрийн далбаа мандуулна.

6.4.2. Цэргийн ёслолын жагсаал хийж болно.

6.5. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг дурсан санах өдөр

6.5.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын болон Улсын Их Хурлын гишүүд, төрийн өндөр албан тушаалтнууд, холбогдох яам, нийслэлийн удирдлага, улс төрийн намууд, олон нийтийн байгууллагын төлөөлөл Хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөөнд цэцэг өргөнө.

6.5.2. Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, холбогдох яамд, газрын төлөөлөл Сонгинохайрхан дахь хэлмэгдэгсдийн булшинд цэцэг өргөнө.

6.6. Ардчилал, хүний эрхийн өдөр

6.6.1. Тэгш ойн жил Засгийн газрын гишүүн тэргүүлсэн Комиссын баталсан төлөвлөгөөний дагуу тэмдэглэнэ.

6.7. Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр

6.7.1. Улсын Их Хурлын дарга Монголын үндэсний олон нийтийн радио телевизээр ард түмэндээ мэндчилгээ дэвшүүлнэ.

6.7.2. Тэгш ойн жил Засгийн газрын гишүүний тэргүүлсэн Комиссын баталсан төлөвлөгөөний дагуу тэмдэглэнэ.

6.8. Тэмдэглэлт бусад өдөр

6.8.1 Хуульд заагдсан тэмдэглэлт бусад өдрөөр төр, захиргааны болон олон нийтийн байгууллагаас тодорхой хөтөлбөрийн дагуу ёслолын үйл ажиллагаа зохион байгуулж болно.

7. Төрийн сүлд байрлуулах, Төрийн далбаа мандуулах, Төрийн дууллыг эгшиглүүлэх

7.1. Төрийн сүлд байрлуулах, Төрийн далбаа мандуулах, Төрийн дуулал эгшиглүүлэх ажиллагааг Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль, энэхүү журамд заасны дагуу зохион байгуулна.

7.2. Төрийн далбааг хийх, үйлдэхдээ Монгол Улсын Төрийн далбааны стандартыг дагаж мөрдөнө.

7.3. Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд өглөөний 09.00 цагт Хүндэт харуулын 18 цэрэг Төрийн 6 далбааг Чингисийн талбайд мандуулна. Үлээвэр найрал хөгжим “Бүгдээрээ сонс” аялгуу эгшиглүүлэхэд, Төрийн ордны хоёр талаас ес есөн Хүндэт харуул /гурав гурваар гурван эгнээ, нийт зургаан эгнээ/ жагсаалын алхаагаар алхан Д.Сүхбаатарын хөшөөний хойно байрлах далбааны 6 суурь тус бүрийн харалдаа нэг эгнээ Төрийн ордон руу харж зогсоно. Нэг эгнээнд далбаа баригч, хоёр хамгаалагч явна.

“Туг хүндэтгэх аялгуу” эгшиглэхэд баруун гар талын хамгаалагч далбаа баригчийн гар дээрээс Монгол Улсын Төрийн далбааг авч эвхээсийг задална. Далбаа баригч далбааны бүчүүдийг суурины оосорт бэхлэн уяж, мандуулахад бэлтгэнэ. Энэ үед далбаа баригчийн зүүн гар талын хамгаалагч нэг алхам ухарч зогсоно. Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэмэгц далбаа баригч Төрийн далбааг мандуулж эхэлнэ, зүүн гар талын хамгаалагч далбааны зүг эгц харж ёсолно. Төрийн дууллын 1 дүгээр бадгийн 3 дахь мөр эхэлмэгц далбаа баригчийн баруун гар талын хамгаалагчид далбааг нэгэн зэрэг намируулан нэг алхам ухарч, далбааны зүг эгц харж ёсолно.

Төрийн дууллын 2 дугаар бадгийн 2 дахь мөр дуусахад далбаа баригч далбааг мандуулж дуусаад нэг алхам ухарч, далбааны зүг эгц харж ёсолно. Төрийн дуулал эгшиглэж дууссаны дараа Хүндэт харуулууд Төрийн ордны баруун, зүүн тал руу жагсаалын алхаагаар буцна.

Орой нар шингэхээс өмнө Төрийн далбааг буулгана. Нийтээр тэмдэглэх баярын өдрүүд нэгээс дээш хоног үргэлжлэх тохиолдолд сүүлийн өдөр нь далбааг буулгана. Хүндэт харуулын 18 цэрэг Төрийн ордны баруун, зүүн талаас ес есөөр жагсаалын алхаагаар алхаж Д.Сүхбаатарын хөшөөний хойно байрлах Төрийн далбааны суурийн дэргэд ирнэ. Хүндэт харуулын цэргүүд Төрийн далбааг алгуурхан буулгаж газарт хүргэлгүйгээр, ёслолын байдалтай, нэгэн зэрэг нямбай

эвхэж далбаа баригчийн гар дээр тавьж өгнө. Хүндэт харуул ёслолын алхаагаар Төрийн ордны баруун, зүүн талаар алхаж байрандаа буцна.

7.4. Гадаа мандуулсан Төрийн далбааг шөнийн цагт гэрэлтүүлнэ.

7.5. Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд аймгийн төвүүдэд Төрийн далбаа мандуулахдаа дээрх жишгийг баримтална.

7.6. Төрийн далбааг бусад далбаатай хамт мандуулахдаа төв хэсэгт байрлуулж, эхэнд нь мандуулж, сүүлд нь буулгана.

7.7. Төрийн далбааг гадаад орны төрийн далбаатай хамт мандуулж болох бөгөөд ижил хэмжээтэй далбааг нэгэн зэрэг ишний дог хүртэл мандуулна. Далбаа руу харан зогссон хүндэт зочдын зүүн гар талд Монгол Улсын Төрийн далбаа, баруун гар талд зочин орны далбаа байхаар мандуулна.

8. Төрийн тугийг хүндэтгэн дээдлэх

8.1. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд заасны дагуу Төрийн Их цагаан тугийг хүндэтгэн дээдлэнэ.

8.2. Төрийн Их цагаан туг нь Чингис хааны байгуулсан тулгар төрийн бэлгэдэл бөгөөд Монгол улсад нэг л байна. Харин аймгийн төвүүдэд төрийн эртний уламжлалын дагуу элч тугийг залж болно.

8.3. Төрийн туг нь Төрийн ордны Төрийн ёслол хүндэтгэлийн Их танхимд байрлах бөгөөд энэ танхимд зөвхөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд ёслолын ажиллагаа зохион байгуулж болно.

8.4. Төрийн туг залах ёслолыг “Төрийн тугийг хүндэтгэн залах журам батлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 67 дугаар зарлигийн дагуу зохион байгуулна.

8.5. Төрийн туганд иргэд, байгууллага хүндэтгэл үзүүлэх ажиллагааг Төрийн ёслолын алба зохицуулан зохион байгуулна.

9. Бүх цэргийн Их Хар сүлдийг цэнгүүлэх

9.1. Бүх цэргийн Их Хар сүлдийг цэнгүүлэх ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 349 дүгээр зарлигийн дагуу зохион байгуулна.

10. Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх

10.1. Шинээр сонгогдсон Ерөнхийлөгч нь Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргаснаас хойш 30 хоногийн дотор Улсын Их Хуралд тангараг өргөнө.

10.2. Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлаас товлосон өдөр, цагт Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хуралд тангараг өргөнө.

10.3. Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэл ажлыг ханган зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулна.

10.4. Тангараг өргөх ёслолд гадаад орны төлөөлөгчдийг урих асуудлыг эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ. Гадаад улсын төлөөлөгчид болон Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад ноот бичиг явуулах асуудлыг Гадаад хэргийн яам хариуцна.

10.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол Улсын Их Хурлын 1993 оны 40, 2013 оны 46 дугаар тогтоолын дагуу Төрийн ордон цогцолбор дахь Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө болно.

10.5.1. Төрийн ордон цогцолбор дахь Их эзэн Чингис хааны хөшөөний баруун талд Монгол Улсын Төрийн далбааг⁵ байрлуулах суурийг байрлуулж, Төрийн далбааны дэргэд ам дөрвөлжин цагаан эсгий дэвссэн байна.

10.5.2. Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө талбайн баруун гар талд шинээр сонгогдсон Ерөнхийлөгч, бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нарт зориулсан ширээ, сандал, Их эзэн Чингис хааны хөшөөний өмнөх талбайн голд Төрийн тугийг байрлуулах суурь, шинээр сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөж, үг хэлэх индэр, индрийн дэргэд Үндсэн хуулийн уг эхийг байрлуулах тавцан, хөшөөний өмнө талбайн зүүн талд Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын ширээ, сандал, индрийн зүүн, баруун урд хэсэгт Улсын Их Хурлын гишүүдийн суух сандлыг хивсэн дээр өөд өөдөөс нь харуулан байрлуулсан байна. Шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийн ширээн дээр Ерөнхийлөгчийн тангараг бичиг, үзэг, дардас байрлуулсан байна.

10.5.3. Их эзэн Чингис хааны хөшөөний доод шатан дээр зассан зүүн жигүүрийн суудалд Ерөнхийлөгчийн гэр бүл, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гэргийн хамт, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Улсын Ерөнхий прокурор болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтан, улс төрийн намын удирдлага болон иргэдийн төлөөлөл, Ерөнхийлөгчийн урилгаар оролцогчид, баруун жигүүрт гадаадын зочин төлөөлөгчид, Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, зочид, Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажилтнууд суух сандлыг байрлуулсан байна.

10.5.4. Чингисийн талбайд хэвлэл, мэдээллийнхэнд зориулсан тусгай тавцан засч, урилгаар оролцогчдод зориулан сандал байрлуулсан байна.

10.5.5. Төрийн ордны баруун, зүүн урд талд тус бүр Төрийн хорин нэгэн далбаа мандуулсан байна. Далбааны дунд байрлах “LED” дэлгэц дээр “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол” гэсэн бичвэр худам монгол бичиг, англиар гарна.

⁵ Тангараг өргөх Ерөнхийлөгч адис авах далбаа

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимын Төрийн далбааг Их эзэн Чингис хааны хөшөөний зүүн талд байрлуулж, дэргэд нь Хүндэт харуул зогсоно.

10.5.6. Их эзэн Чингис хааны сургаалаас олон нийтэд сонордуулна.

10.5.7. Олон нийтэд зориулан урлагийн тоглолт үзүүлж, Цэргийн дуу, бүжгийн чуулгын бүжигчид угтах ёслолын бүжиг хийнэ. Хүндэт зочин төлөөлөгч, урилгаар оролцогчид суудалдаа сууна.

10.5.8. Үлээвэр найрал хөгжим, Хүндэт харуул, цэргийн ёслолын жагсаалд оролцох бие бүрэлдэхүүн Чингисийн талбайд байраа эзэлнэ.

Үлээвэр найрал хөгжим “Төрийн Их Туг заллага” аялгуу тоглоно. Төрийн ордны зүүн талаас Хүндэт харуул Төрийн туг, Төрийн далбаа⁶ Их эзэн Чингис хааны хөшөө рүү зална. Төрийн тугийг хөшөөний өмнө тусгайлан бэлтгэсэн сууринд, Төрийн далбааг хөшөөний баруун талд залж байрлуулна.

10.5.9. Улсын Их Хурлын гишүүд Төрийн ордны зүүн урд голын хаалгаар гарч бүдүүвч зурагт заагдсан суудлаа эзлэнэ.

Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Их эзэн Чингис хааны хөшөөний дэргэд байраа эзлэнэ.

10.5.10. Улсын Их Хурлын дарга гишүүдийн ирцийг мэдээлж, гадаадын хүндэт зочдыг танилцуулан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг нээж “*Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Их Хуралд тангараг өргөнө*” хэмээн зарлан мэдэгдэнэ.

10.5.11. Ийнхүү зарламагц Ерөнхийлөгч Тамгын газрын даргаа, шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслолын албаны даргыг дагуулан Их эзэн Чингис хааны хөшөөний зүүн урд хаалгаар гарч ирэн, ард иргэдтэйгээ гар өргөн мэндчилж, Их эзэн Чингис хааны хөшөө, Төрийн Их цагаан туганд мэхийн ёслоод суудалдаа сууна. Энэ үед Тамгын газрын дарга Үндсэн хуулийн уг эхийг гартаа барьсан байх ба хөшөөний өмнө байрлах индрийн дэргэд тусгайлан зассан тавцан дээр залж байрлуулна.

Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслолын албаны даргыг дагуулан, Ерөнхийлөгч улиран сонгогдсон тохиолдолд Ерөнхийлөгч Тамгын газрын дарга, Төрийн ёслолын албаны даргыг дагуулан Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө хүрэлцэн ирж энэ журамд заасны дагуу тангараг өргөнө.

10.5.12. Улсын Их Хурлын дарга шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийг тангараг өргөхийг урина.

10.5.13. Шинээр сонгогдсон Ерөнхийлөгч индэрт гарч Үндсэн хуулийн уг эх дээр баруун гараа тавиад тангаргийг цээжээр дээдлэн дуудна. Тангарагаа хэлж дуусмагц цэргийн жагсаалд оролцогчид гурван удаа уухайлна. Иргэд

⁶ Тангараг өргөх Ерөнхийлөгч адис авах далбаа

даган түрнэ. Үүний дараа Ерөнхийлөгч суудалдаа сууж, тангарагт гарын үсгээ зураад Улсын Их Хурлын даргад тангарагийн бичгээ гардуулсны дараа Төрийн далбааны дэргэд очиж ам дөрвөлжин цагаан эсгий дээр баруун өвдгөө мэхийж Төрийн далбаанаас адис авна.

10.5.14. Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд Улсын Их Хурлын дарга Төрийн тамгыг шинээр сонгогдсон Ерөнхийлөгчид энэ журмын 10.5.23-д заасны дагуу гардуулан өгнө.

10.5.15. Тангараг өргөсөн Ерөнхийлөгч ширээндээ залармагц Улсын Их Хурлын дарга тангарагаа өргөсөн Ерөнхийлөгчид баяр хүргэн үг хэлж, Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ. Ёслолд оролцогчид хүндэтгэн босч зогсоно.

10.5.16. Улсын Их Хурлын дарга иргэдийг төлөөлж үг хэлэх хүнийг индэрт урина.

10.5.17. Төлөөлөгч индэрт гарч баяр хүргэж үг хэлнэ. Үүний дараа ахмад настай иргэн Ерөнхийлөгчид хадаг, мөнгөн аягатай сүү барина.

10.5.18. Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийг үг хэлэхийг урина.

10.5.19. Монгол Улсын Ерөнхийлөгч индэрт гарч Улсын Их Хурал болон ард түмэндээ хандан үг хэлнэ.

10.5.20. Ерөнхийлөгч үг хэлж дуусмагц Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэж хүндэтгэлийн хуралдааныг хаана.

10.5.21. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Ерөнхийлөгч Тамгын газрын даргаа, шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслолын албаны даргыг дагуулан Төрийн ордны баруун урд хаалгаар орно. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Үндсэн хуулийн уг эхийг Ерөнхийлөгчийн албан өрөөнд зална.

Төрийн Их цагаан туг, Төрийн далбааг Хүндэт харуул Төрийн ордны урд шатаар буун баруун тийш нар зөв залж, Их цагаан тугийг байранд нь, Төрийн далбааг⁷ Ерөнхийлөгчийн албан өрөөнд байрлуулна.

10.5.22. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон болон Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Ерөнхийлөгчийг “Ерөнхийлөгч”, шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийг “Монгол Улсын Ерөнхийлөгч” гэж албан ёсоор нэрлэнэ.

10.5.23. Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын ажиллагаанд зориулж цэргийн ёслолын жагсаал явуулна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Төрийн ордны зүүн урд хаалгаар гарч, гол шатаар буун тусгайлан зассан тавцан дээр зогсоно.

⁷ Ерөнхийлөгчийн адис авсан далбаа

Цэргийн жагсаал командлагч Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид илтгэл өгснөөр цэргийн жагсаал эхэлнэ.

10.5.24. Ёслолын жагсаал өндөрлөхөд Ерөнхийлөгч албан өрөөндөө хүрэлцэн ирж ажил хүлээлцэх ёслол болно.

Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгч ажил хүлээлгэн өгөх ёслолын дараа Төрийн тамгыг хадаг дээр залж Ерөнхийлөгчид хүндэтгэлтэйгээр өргөн барина. Ерөнхийлөгч Төрийн тамгыг хүндэтгэлтэйгээр түшиж адислан гардаж аваад ширээн дээр зална.

Ерөнхийлөгч улиран сонгогдсон тохиолдолд ажил хүлээлцэх, Төрийн тамгыг гардуулах ёслол үйлдэхгүй.

10.5.25. Тангараг өргөх ёслолын ажиллагааг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр орон даяар шууд нэвтрүүлнэ. Чингисийн талбайд том дэлгэц байрлуулж цугласан хүмүүст ёслолын ажиллагааг үзүүлнэ.

10.6. Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгчийг Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Төрийн ёслолын албаны дарга, Төрийн ордны хамгаалалтын албаны дарга нар Төрийн ордны урд гол хаалганы дэргэдээс үднэ.

10.7. Төр засгийн өндөр албан тушаалтнууд, гадаадын зочин төлөөлөгчид Ерөнхийлөгчид бараалхаж баяр хүргэх ёслолыг Төрийн ёслолын алба, Ёслолын газар хамтран дараах байдлаар зохион байгуулна:

10.7.1. Монгол Улсын Ерөнхийлөгчид Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Ерөнхийлөгчийг сонгуульд нэр дэвшүүлсэн намын удирдлага нар тус тус бараалхаж баяр хүргэнэ. Баяр хүргэхэд Тангараг өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч байлцана. Намын удирдлага баяр хүргэх үеэр Ерөнхийлөгч намын батлахаа хүлээлгэн өгнө.

10.7.2. Гадаад орны зочин төлөөлөгчид Ерөнхийлөгчид баяр хүргэх ажиллагааг Төрийн ёслол хүндэтгэлийн Их танхимд зохион байгуулах бөгөөд үүнд Тангараг өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч, Гадаад хэргийн сайд нар байлцана.

10.7.3. Гадаад орны зочин төлөөлөгчид Ерөнхийлөгчид бараалхах уулзалтыг Төрийн ёслолын алба, Ёслолын газар хамтран зохицуулна.

10.7.4. Төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл Ерөнхийлөгчид баяр хүргэх хүсэлтийг Төрийн ёслолын алба хүлээн авч зохицуулна.

10.8. Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөсөнтэй холбогдуулан хүндэтгэлийн урлагийн тоглолт зохион байгуулна.

10.9. Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөсөнтэйгөө холбогдуулан дайллага хийнэ.

10.10. Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөсөнтэй холбогдуулан үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулна.

11. Улсын Их Хурлын анхдугаар чуулганы нээлт

11.1. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу анхдугаар чуулганыг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Ерөнхийлөгч зарлигаар товлон зарлаж хуралдуулна.

Ерөнхийлөгч зарлиг гаргахдаа анхдугаар чуулган нээх өдрийг Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцсөн байна.

11.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн товлосон өдөр Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг нээнэ.

11.3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Ерөнхийлөгч анхдугаар чуулганы нэгдсэн хуралдааныг нээж, шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөж дуустал удирдана. Үүний дараа насаар хамгийн ахмад гишүүн Улсын Их Хурлын дарга сонгогдох хүртэл хуралдааныг даргална.

11.4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганы нэгдсэн хуралдаанд Ерөнхийлөгч, бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Засгийн газрын гишүүд, Улсын Ерөнхий прокурор, Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагууд, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон нийслэлийн удирдлага оролцоно.

11.5. Монгол Улсад суугаа гадаадын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарыг Ёслолын газраас ноот бичиг явуулж Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаанд урина.

11.6. Төрийн ордны хойд гол хаалганы хоёр талд Төрийн далбаа мандуулж, Хүндэт харуул зогсоно.

11.7. Улсын Их Хурлын анхдугаар чуулганы нээлтийн үеэр Төрийн ордны хамгаалалтын албаны ахлах ажилтан чуулганы танхим дахь Төрийн далбааны дэргэд хүндэтгэн зогсоно. Төрийн далбааны өмнө ам дөрвөлжин цагаан эсгий дэвссэн байна.

11.8. Чуулганы танхимын голд тангарагийн бичигт гарын үсэг зурах ширээ сандал, ширээнд төрийн далбаа, үзэг, дардас, тангарагийн бичгийг байрлуулсан байна.

11.9. Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, урилгаар оролцож байгаа албан тушаалтнууд суудлаа эзэлсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч чуулганы танхимын урд гол хаалгаар орж ирэхийг зарлан мэдэгдэхэд бүгд суудлаасаа босч хүндэтгэнэ.

11.10. Ерөнхийлөгч чуулганыг нээснийг мэдэгдэхэд Үлээвэр найрал хөгжим чуулганы нэгдсэн хуралдааны хүлээлгийн танхимаас Төрийн дуулал эгшиглүүлнэ.

11.11. Чуулганы нээлтийн дараа Улсын Их Хурлын гишүүд дурсгалын зураг авахуулж, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлнэ.

11.12. Улсын Их Хурлын анхдугаар чуулганы нэгдсэн хуралдааны нээлтийн ажиллагааг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр орон даяар шууд нэвтрүүлнэ.

12. Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөх

12.1. Улсын Их Хурлын анхдугаар чуулган бүрэн эрхийг нь зөвшөөрсний дараа Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөнө.

12.2. Улсын Их Хурлын насаар хамгийн ахмад гишүүн Улсын Их Хурлын гишүүний тангарагийг уншихад бусад гишүүд даган хэлж тангараг өргөнө.

12.3. Тангараг өргөсний дараа гишүүд цагаан толгойн үсгийн дарааллаар Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, чуулганы танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангарагийн бичигт гарын үсэг зурна. Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга гардуулна.

12.4. Хамгийн сүүлийн гишүүн тангарагийн бичигт гарын үсэг зурж ширээндээ очсоны дараа Үлээвэр найрал хөгжим Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны хүлээлгийн танхимаас Төрийн дуулал эгшиглүүлнэ.

12.5. Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын гишүүдэд баяр хүргэж насаар хамгийн ахмад гишүүнийг хуралдаан даргалахыг урина.

12.6. Анхдугаар чуулганы нээлтийн хуралдаанд оролцож чадаагүй гишүүн өөрийн оролцсон анхны өдрийн хуралдаанд тангараг өргөнө.

13. Улсын Их Хурлын тамга шилжүүлэх

13.1. Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга сонгогдмогц тамга шилжүүлэх ёслол болно.

13.1.1. Улсын Их Хурлын даргыг шинээр сонгож тогтоол баталсны дараа хуралдаан даргалагч Улсын Их Хурлын тамгыг хуралдааны танхимд залахыг хүснэ. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Төрийн ордны хамгаалалтан дор тамгыг хадаг дээр залж танхимд орж хуралдаан даргалагчийн ширээний зүүн хэсэгт байрлуулна.

13.1.2. Хуралдаан даргалагч Улсын Их Хурлын шинээр сонгогдсон даргыг ширээндээ залрахыг урина.

13.1.3. Улсын Их Хурлын дарга ширээндээ заларсны дараа хуралдаан даргалагч тамгыг барихад тэрбээр тамгыг гардан авч цээжин тушаа барин тэргүүнээ бөхийлгөн адис аваад ширээндээ зална.

13.1.4. Улсын Их Хурлын дарга суудлаасаа үг хэлнэ.

13.1.5. Хуралдаан завсарлахад Улсын Их Хурлын дарга тамгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад шилжүүлэн хадгалуулна.

13.2. Улсын Их Хурлын дарга Төрийн туганд мэхийн ёсолно.

13.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар Улсын Их Хурлын даргад баяр хүргэнэ.

13.4. Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын удирдлага баяр хүргэх хүсэлтийг Төрийн ёслолын алба хүлээн авч зохицуулна.

14. Улсын Их Хурлын ээлжит чуулганы нээлт

14.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Засгийн газрын гишүүд, Улсын Ерөнхий прокурор, Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын дарга нар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нийслэлийн удирдлага ээлжит чуулганы нээлтийн хуралдаанд урилгаар оролцоно.

14.2. Монгол Улсад суугаа гадаадын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарт Ёслолын газар ноот бичиг явуулж нээлтийн хуралдаанд урина.

14.3. Улсын Их Хурлын дарга хуралдааныг нээж үг хэлнэ. Үг хэлж дуусмагц Төрийн дууллыг бичлэгээр эгшиглүүлнэ.

14.4. Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдааны нээлтийн явцыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр орон даяар шууд нэвтрүүлнэ.

15. Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан

15.1. Улсын Их Хурлын дарга Монгол Улсын түүхэн ой, чухал тэмдэглэлт үйл явдлыг тэмдэглэх, түүнчлэн гадаад улсын өндөр дээд хэмжээний зочин нэгдсэн хуралдаанд үг хэлэхээр бол захирамж гарган хүндэтгэлийн хуралдаан хуралдуулж болно.

15.2. Монгол Улсад суугаа гадаадын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарт Ёслолын газар ноот бичиг явуулж хүндэтгэлийн хуралдаанд урина.

15.3. Гадаад улсын дээд, өндөр хэмжээний зочин хүндэтгэлийн хуралдаанд үг хэлэхэд зочин, түүнийг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчдийг чуулганы нэгдсэн хуралдааны танхимд, дагалдан яваа бусад хүмүүсийг шаардлагатай тохиолдолд танхимын хоёрдугаар давхарт суулгана.

15.4. Улсын Их Хурлын дарга хүндэт зочныг чуулганы нэгдсэн хуралдааны хүлээлгийн танхимд угтан чуулганы танхимд орж ирэхэд Улсын Их Хурлын гишүүд суудлаасаа босчалга ташина.

15.5. Нэгдсэн хуралдаанд гадаад орны Ерөнхийлөгч үг хэлэхээр бол Ерөнхийлөгчийн суудаг талд, Ерөнхий сайд үг хэлэхээр бол Ерөнхий сайдын суудаг талд тусгайлан бэлтгэсэн суудалд сууна.

15.6. Улсын Их Хурлын дарга хуралдааныг нээж үг хэлсний дараа Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэнэ.

15.7. Улсын Их Хурлын дарга хүндэт зочныг үг хэлэхийг урина. Хүндэт зочин индэрт гарч үг хэлнэ.

15.8. Хуралдаанд хэлсэн үгийг монгол, англи, зочин орны хэлээр шууд орчуулна. Зочны хэлэх үгийг урьдчилан монгол хэлээр орчуулж Улсын Их Хурлын гишүүдийн өмнө тавьж болно.

15.9. Хүндэт зочин үг хэлээд суудалдаа морилсны дараа Улсын Их Хурлын дарга зочинд талархал илэрхийлж хуралдааныг өндөрлүүлнэ.

15.10. Улсын Их Хурлын дарга хүндэт зочныг дагуулан чуулганы танхимаас гарахад гишүүд босч хүндэтгэнэ. Улсын Их Хурлын дарга хүндэт зочныг угтсан газраа үднэ.

15.11. Хүндэтгэлийн хуралдааныг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр шууд нэвтрүүлнэ.

16. Засгийн газрын тамга шилжүүлэх

16.1. Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилмогц Засгийн газрын тамга шилжүүлэх ёслол Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнд болно.

16.2. Монгол Улсын Ерөнхийлөгч өргөөний гол хойморт, шинээр томилогдсон Ерөнхий сайд баруун хойморт, бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхий сайд зүүн хойморт байраа эзэлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Засгийн газрын тамгыг хадаг дээр залж, бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхий сайдын дэргэд зогсоно.

Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхий сайд Засгийн газрын тамгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргаас авч шинээр томилогдсон Ерөнхий сайдад гардуулна. Ерөнхий сайд тамгыг гардаж, тэргүүн бөхийж адис аваад, өргөөний баруун талд гарч зогссон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргад хадгалуулна.

16.3. Ерөнхий сайд улиран томилогдох тохиолдолд тамга шилжүүлэх ёслол үйлдэхгүй.

16.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга нар шинээр томилогдсон Ерөнхий сайдад баяр хүргэнэ.

16.5. Ерөнхий сайд Төрийн туганд мэхийн ёсолно.

16.6. Засгийн газрын харьяа байгууллагын удирдлага Ерөнхий сайдад баяр хүргэх хүсэлтийг Төрийн ёслолын алба хүлээн авч зохицуулна.

17. Төрийн албан хаагчийн тангараг өргөх

17.1. Монгол Улсын иргэн төрийн албанд анх орохдоо албан хаагчийн тангараг /цаашид “тангараг” гэх/-ийг өргөнө.

17.2. Тухайн албан хаагчийн ажиллах байгууллага тангараг өргөх ёслолыг зохион байгуулна.

17.3. Тангараг өргөх байранд Монгол Улсын Төрийн сүлд, Төрийн далбаа, ширээ, сандал, ширээнд тангарагийн бичиг, үзэг, дардас байрлуулсан байна.

17.4. Тангараг өргөх албан хаагч Монгол Улсын Төрийн сүлд рүү харан зогсоно.

17.5. Тангарагийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд хамгийн ахмад ажилтан нь нэг алхам урагш гарч тангарагийг чанга дуудаж бусад нь давтан хэлнэ.

17.6. Тангараг өргөгч Монгол Улсын Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, баруун өвдөг сөхрөн, Төрийн далбаанаас адис авч, ширээнд суун тангарагийн бичигт гарын үсэг зурна.

17.7. Монгол Улсын Төрийн дууллыг бичлэгээр нэг бадаг эгшиглүүлнэ.

18. Төрийн шагнал, улсын цол хүртээх, одон медалиар шагнах

18.1. “Чингис хаан” одон гардуулах ёслолыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 171 дүгээр зарлигийн дагуу зохион байгуулна.

18.2. Төрийн шагнал хүртээх ёслолыг Төрийн хүндэтгэлийн өргөөнд, улсын цол, цэргийн болон дипломат дээд цол хүртээх, одон медалиар шагнах ёслолыг Төрийн ёслол хүндэтгэлийн Их танхимд тус тус зохион байгуулна.

18.3. Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажилтан зарлигийг уншихад нэр дуудагдсан хүн Ерөнхийлөгчийн баруун гар талд очиж зогсоно. Ерөнхийлөгч улсын цол, төрийн шагнал, шагналын тэмдэг, одон медалийг зүүж, үнэмлэхийг гардуулна.

18.4. Ерөнхийлөгч шагнал хүртэгчдэд хандан баяр хүргэж, шагнал хүртэгчдийн төлөөлөл талархал илэрхийлж хариу үг хэлж болно.

18.5. Ерөнхийлөгч цол олгох, одон медаль гардуулахад Засгийн газар, Улсын Их Хурлын холбогдох гишүүн, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байлцана.

18.6. Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс эрх бүхий албан тушаалтан шагнал гардуулж болно.

19. Улсын Их Хурлаас Б.Чимидийн нэрэмжит шагнал гардуулах

19.1. Улсын Их Хурлын даргын 2014 оны 176 дугаар захирамжид зааснаар Улсын Их Хурлаас Б.Чимидийн нэрэмжит шагнал гардуулах ёслолыг Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр зохион байгуулна.

19.2. Улсын Их Хурлын дарга шагналыг Төрийн ёслол хүндэтгэлийн Их танхимд гардуулна.

20. Засгийн газрын “Хүндэт өргөмжлөл” гардуулах

20.1. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын “Хүндэт өргөмжлөл”-ийг Төрийн ёслол хүндэтгэлийн Их танхимд олгоно. Ёслолын арга хэмжээнд Засгийн газрын гишүүд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага оролцоно.

20.2. Ерөнхий сайдын нэрийн өмнөөс эрх бүхий албан тушаалтан өргөмжлөл гардуулж болно.

21. Уул, овооны тэнгэрийг тайх төрийн тахилга

21.1. Төрийн тахилгатай уул, овооны тэнгэрийг тайх төрийн тахилгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 85 дугаар зарлигаар батлагдсан журам, 2010 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 203 дугаар зарлигийн дагуу үйлдэнэ.

22. Хөрөг байрлуулах

22.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын албан тушаал хашиж байсан хүмүүсийн хөргийг он дарааллын дагуу Төрийн ордонд байрлуулна. Хөрөг байрлуулах асуудлыг тус тусын Тамгын газар хариуцна.

22.2. Монгол Улсын төрийн тэргүүний хөргийг төрийн захиргааны байгууллагуудын дарга, цэргийн ангийн захирагч, Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарын албан тасалгаанд байрлуулна.

23. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд орон нутагт ажиллах

23.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг орон нутагт нисэх онгоц, галт тэргээр явж ажиллахад Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, тэднийг эзгүйд тамгын газрын дэд дарга, Төрийн ёслолын албаны даргын хамт үдэж, угтана.

Аймаг, сумын удирдлага орон нутаг дахь нисэх онгоц, галт тэрэгний буудалд угтаж, үднэ.

Үдэх, угтахад Улаанбаатар хот болон орон нутаг дахь нисэх онгоц, галт тэрэгний буудалд Монгол Улсын Төрийн далбаа мандуулж, тухайн нисэх онгоц, галт тэрэгний дарга илтгэл өгнө.

23.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар аймаг орон нутагт ажиллахаар авто машинаар явахад аймгийн удирдлага

тухайн аймгийн хилийн зааг дээр угтаж, ажил танилцуулж дууссан газраа үднэ. Аймгийн хилийн зааг хол байгаа тохиолдолд угтах газрыг Тамгын газар тухай бүр тогтооно.

Сумдын удирлага ажил танилцуулах газраа угтаж, үднэ.

Аймгийн тагнуул болон цагдаагийн дарга тухайн аймгийн хилийн заагаас угтаж, дараагийн аймгийн хилийн зааг хүртэл шадарлан явна.

23.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийг албан ажлаар очих бүрт тухайн аймгийн төвд буюу цэргийн хүрээний анги бүхий суурин газарт Төрийн далбаа мандуулж, цэргийн хүндэт харуул жагсаж, Төрийн дуулал эгшиглүүлэн хүндэтгэн угтана.

23.4. Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар шинээр сонгогдож, томилогдсоны дараа орон нутагт анх удаа очиход тухайн аймгийн төвд буюу цэргийн хүрээний анги бүхий суурин газарт Төрийн далбаа мандуулж, цэргийн хүндэт харуул жагсаж, Төрийн дуулал эгшиглүүлэн хүндэтгэн угтана.

23.5. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар аймаг, сумын төвд иргэдтэй уулзах байранд Төрийн далбаа байрлуулна.

24. Ёслолын үйл ажиллагаанд оролцох

24.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг ёслолын арга хэмжээнд урьсан урилгыг Төрийн ёслолын албаар дамжуулна. Ёслолын арга хэмжээнд оролцох эсэхийг Төрийн ёслолын алба тус тусын Тамгын газар, зөвлөхүүдтэй зөвшилцөж шийдвэрлэнэ.

24.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарыг ёслолын арга хэмжээнд давхцуулан оролцуулахгүй байх зарчмыг баримтална.

24.3. Төрийн ёслолын алба Улсын Их Хурлын дэд дарга, Шадар сайд, Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүдийн урилгыг хүлээн авч өөрсдөд нь мэдэгдэж, зохицуулалт хийнэ.

24.4. Дипломат төлөөлөгчийн газраас зохиох арга хэмжээнд төрийн дээд, өндөр албан тушаалтныг хэрхэн оролцуулахыг Ёслолын газраар дамжуулан шийдвэрлэнэ.

25. Уулзалт зохион байгуулах

25.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдтай иргэд, албан тушаалтан, олон нийтийн байгууллагын удирдлагын уулзах тухай хүсэлтийг Төрийн ёслолын алба хүлээн авч, холбогдох Тамгын газартай ярьж тохирсоны үндсэн дээр зохион байгуулна.

25.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд гадаадын албан ёсны зочин, төлөөлөгчидтэй хийх уулзалтыг Төрийн ёслолын алба, Ёслолын газартай хамтран зохион байгуулна.

25.3. Төрийн ёслолын алба уулзалт болох өрөө танхим, үйлчилгээг зохицуулж, оролцох хүний тоог тогтооно. Уулзалт хүссэн, айлчлал хариуцсан байгууллага ярианы сэдэв болон холбогдох материалыг урьдчилан ирүүлнэ.

25.4. Айлчлал хариуцсан байгууллага уулзалт болохоос 24-өөс доошгүй цагийн өмнө тухайн уулзалтад оролцох зочид, төлөөлөгчдийн нэрс, албан тушаал, тэдний машины марк, улсын дугаарыг багтаасан дэлгэрэнгүй мэдээлэл, хөтөлбөрийг Төрийн ёслолын албанд хүргүүлнэ. Хөтөлбөрт өөрчлөлт орвол хариуцсан байгууллага энэ тухай шуурхай мэдэгдэнэ.

25.5. Монгол Улсад төрийн болон албан ёсны айлчлал хийж буй гадаад улсын төрийн тэргүүнд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар бараалхана.

25.6. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхуулах ба Ерөнхий сайд түүнд бараалхана.

25.7. Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй гадаад орны Засгийн газрын тэргүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын даргад бараалхуулна.

25.8. Гадаад орны Гадаад хэргийн сайд Монгол Улсад албан ёсоор айлчлах үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарын аль нэгэнд бараалхуулж болно. Монгол Улсад айлчилж буй гадаад орны Засгийн газрын гишүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдад бараалхуулж болно.

25.9. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гадаадын албан ёсны зочин, төлөөлөгчидтэй хийх уулзалтад Гадаад хэргийн яамны удирдлага, гадаад бодлогын зөвлөх нар байлцана.

25.10. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гадаад улсын төрийн дээд албан тушаалтантай хоёр талын болон олон улсын харилцааны асуудлаар утсаар ярихад гадаад бодлогын зөвлөх, Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал нар байлцаж, тэмдэглэл хөтлөнө.

25.11. Улс төрийн нам, хувийн хэвшил, төрийн бус байгууллагаас урьж ирүүлсэн гадаадын төлөөлөгчийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарт бараалхуулах хүсэлтээ 14 хоногийн өмнө Ёслолын газарт албан бичгээр тавих бөгөөд урьж ирүүлсэн төлөөлөгчийн болон өөрийн байгууллагын тухай дэлгэрэнгүй танилцуулгыг хамт ирүүлнэ.

25.12. Төр, засгийн удирдагчидтай гадаадын зочин төлөөлөгч уулзах үеэр орчуулга хийх хэлмэрчийг Ёслолын газар зохицуулна.

26. Баримт бичигт гарын үсэг зурах

26.1. Баримт бичигт гарын үсэг зурах танхимд Монгол Улсын болон зочин улсын Төрийн далбааг байрлуулна. Зочин улсын далбаа баруун гар талд нь байна. Ширээн дээр гарын үсэг зурах баримт бичиг, үзэг, дардас, талуудын далбааг байрлуулсан байна.

26.2. Гарын үсэг зурах талуудаас тус бүр нэг хүн баримт бичгийг түшнэ.

26.3. Танхимын зүүн гар талд Монголын талын албаны хүмүүс, баруун гар талд зочин төлөөлөгчид байраа эзэлнэ.

26.4. Гарын үсэг зурах албан тушаалтны өмнө баримт бичгийн тухайн талд үлдэх хувийг байрлуулсан байна. Талуудад үлдэх хувь нь гарын үсэг зурах албан тушаалтны төлөөлж байгаа улс, байгууллагын нэрээр эхэлсэн байна.

26.5. Гарын үсэг зурах ёслолд оролцогч талуудыг ахалж байгаа албан тушаалтан ирж ширээний ард байраа эзэлснээр ёслол эхэлнэ.

26.6. Хөтлөгч баримт бичгийн нэр, гарын үсэг зурах хүний албан тушаал, нэрийг зарлаж, ширээнд суухыг урина. Орчуулгыг хоёр талын тохиролцсон хэлээр хийнэ.

26.7. Түшиж байгаа хүн албан тушаалтанд ойртон очиж, баримт бичигт гарын үсэг зурах хэсгийг зааж өгнө. Албан тушаалтнууд гарын үсэг зурсны дараа түшиж буй хүмүүс гарын үсэг зурсан хэсгийн үзэгний бэхийг дардсаар шингээж аваад, баримт бичгийг ширээнээс авч, гарын үсэг зурсан албан тушаалтнуудын ар талаар солилцоно. Дараа нь солилцсон хувийг өөрийн талын албан тушаалтны өмнө тавьж, гарын үсэг зурах хэсгийг зааж өгнө. Гарын үсэг зурсны дараа бэхийг дардсаар шингээж аваад баримт бичгийн хавтсыг хаана.

26.8. Гарын үсэг зурсан албан тушаалтнууд босож, баримт бичгээ солилцон, гар барьж, дурсгалын зураг авахуулна.

26.9. Дараа нь ёслолд оролцогчдод оргилуун дарс, жүүс барина. Дээд албан тушаалтнаас эхлэн үйлчилнэ.

26.10. Ёслолд оролцогч талууд хэвлэл мэдээлэлд ярилцлага өгч болно.

27. Бэлэг дурсгалын зүйл бэлтгэх, гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах

27.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын айлчлал, тэдний урилгаар ирэх гадаадын зочин төлөөлөгчдөд өгөх бэлэг дурсгалын зүйлс нь монгол үндэстний түүх, зан заншил, ахуй, соёлыг харуулсан бэлгэдлийн агуулгатай зүйл байна. Бэлэг дурсгалын зүйлс нь хүндэтгэл, талархал илэрхийлэх, баяр хүргэх гэсэн утгыг агуулах бөгөөд онцгойлон үзэх харилцааны нөхцөл байдлын улмаас тусгайлан захиалж бэлтгүүлж болно.

27.2. Бэлэг дурсгалын зүйлс нь Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон түүх дурсгалын үнэт эдлэл, байгалийн үнэт эрдэнэс, ховор эд зүйлс байж үл болно.

27.3. Бэлгийг бэлтгэхдээ тухайн үндэстний зан заншил, шашин, онцлон дээдэлдэг болон цээрлэдэг зүйлс, хувь хүний сонирхол зэргийг харгалзан үзнэ.

27.4. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бэлэг дурсгалын сангийн нөөц бүрдүүлэлтэд шаардагдах зардлыг гаргаж, бэлэг дурсгалын санг бүрдүүлнэ.

27.5. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын айлчлал, тэдний урилгаар ирэх гадаадын зочин төлөөлөгчдөд өгөх бэлэг дурсгалын зүйлсийг батлагдсан төсвийн дагуу Ёслолын газрын саналыг авч Төрийн ёслолын алба хариуцаж бэлтгэнэ.

27.6. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын урилгаар Монгол Улсад айлчилж байгаа гадаадын төлөөлөгчдийн зөвхөн албан ёсны бүрэлдэхүүнд бэлэг өгнө.

27.7. Монгол Улсад айлчилж байгаа гадаадын өндөр дээд хэмжээний төлөөлөгчдийн тэргүүнд зөвхөн хүлээн авагч албан тушаалтан бэлэг өгөх зарчим барина. Онцгойлон үзэх харилцааны нөхцөл байдлаас шалтгаалан бусад албан тушаалтан бэлэг өгч болно.

27.8. Монгол Улсын түүх, зан заншил, соёлтой холбоотой тухайлан бэлтгэсэн бэлгийн зүйлсийн онцлог, холбогдох тайлбарыг англи хэлээр бэлтгэж хавсаргана.

27.9. Төрийн ёслолын арга хэмжээний үеэр төрийн дээд, өндөр албан тушаалтан гадаадын адилтгах зиндааны дээд, өндөр албан тушаалтантай харилцан бэлэг солилцож болно. Бусад бэлгийг дипломат шугамаар солилцоно.

27.10. Дипломат шугамаар солилцсон бэлгийг ёслолын ажилтан хүлээн авснаас хойш 24 цагийн дотор холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгнө. Ёслолын ажилтан бэлгийн гэрэл зураг, дагалдах тайлбарыг хуулбарлан авна. Ёслолын газар, Төрийн ёслолын алба бэлгийн тайланг улирал бүр гаргаж албан тушаалтанд танилцуулж, бэлгийг хэрхэн зарцуулах талаар шийдвэр гаргуулна.

27.11. Бэлэг дурсгалын зүйл хүлээн авч тайлагнан зарцуулахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 133, 141 дүгээр тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

28. Хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх, цэцэг өргөх

28.1. Төр, засгийн дээд, өндөр албан тушаалтнууд, төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, нам, олон нийтийн байгууллагын удирдлага хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх, цэцэг өргөхөд дараах дарааллыг баримтална:

а) Дараалал:

- Төрийн дээд, өндөр албан тушаалтнууд;
- Төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;
- Орон нутгийн удирдлагын төлөөлөл;
- Гадаад орны дипломат төлөөлөгчийн газрын төлөөлөл;
- Улс төрийн намын төлөөлөл;

-Олон нийтийн байгууллагын төлөөлөл.

б) Төрийн дээд, өндөр албан тушаалтны байрлал:

-Эхний эгнээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний баруун гар талд Улсын Их Хурлын дарга, Үндсэн хуулийн цэцийн дарга, зүүн гар талд Ерөнхий сайд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нар зогсоно. Тэдний арын эгнээнд төрийн бусад өндөр албан тушаалтан ёслолын ахлалаар зогсоно.

28.2. Их эзэн Чингис хааны хөшөөнд

28.2.1 Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслолыг долоо хоног бүрийн Бямба, Ням гарагийн 11.40-өөс 12.00 цагийн хооронд Хүндэт харуул гүйцэтгэнэ.

-Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх Хүндэт харуулын бүрэлдэхүүн нь Төрийн ордны баруун, зүүн талд жагссан байна. Төрийн ордны урд талбайд 11.40 цагт “Марш” аялгуу тоглоно. Хүндэт харуулын 26 цэрэг 13, 13-аараа Төрийн ордны баруун, зүүн жигүүрээс алхаж Чингис хааны хөшөөний хоёр талаар өгсөж хөшөөний хоёр талд жагсаалын алхаагаар ирж талбай, шат болон хөшөөний дэргэд дэлгэмэл байдлаар долоон минутын дотор байраа эзэлнэ.

-Хүндэт харуул хөшөөний дэргэд 13 минут зогсох бөгөөд жагсаалын даргын командаар 12.00 цагт Хүндэт харуул жагсаалын алхаагаар буцаж бууна.

28.2.2. Нийтээр тэмдэглэх баярын үеэр хүндэтгэл илэрхийлэхэд Их эзэн Чингис хааны хөшөөний хоёр талд болон хөшөөний өмнөх шатны дагуу Хүндэт харуулын 16 цэрэг өөд өөдөөсөө харан жагссан байна;

-Үлээвэр найрал хөгжим, Хүндэт харуул шатны доод талд зүүн тийш харан жагссан байна;

-Их эзэн Чингис хааны хөшөөний өмнөх шатны доод хэсгээс хөшөө хүртэл нарийн хивс, ёслолд оролцогчид хөшөөнд мэхийн ёслох газарт хивс тус тус дэвссэн байна. Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлснээр ёслол эхэлнэ. Дараа нь Үлээвэр найрал хөгжим Б.Шаравын “Дурсамж” аялгууг тоглоход ёслолд оролцогчид эгнээ эгнээгээр хөшөө өөд шатаар өгсөнө. Төрийн дээд, өндөр албан тушаалтнууд Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө дэвссэн хивсэн дээр очиж зогсоод, мэхийн ёсолж, хөшөөний баруун талын хаалгаар Төрийн ордон руу орно. Ёслолд оролцогч бусад хүмүүс хөшөөнд мэхийн ёсолж, шатны зүүн хэсгээр буцаж бууна. Ёслол дуусахад Үлээвэр найрал хөгжим “Миний нутаг” марш эгшиглүүлнэ.

28.2.3. Байгууллага, иргэний хүсэлтийг үндэслэн Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслолыг Төрийн ёслолын алба зохион байгуулж болно.

28.3. Д.Сүхбаатарын хөшөөнд

28.3.1. Хөшөөний зүүн өмнө Хүндэт харуул, Үлээвэр найрал хөгжим жагсаж, хөшөөний зүүн талаас хөшөө хүртэл цэцэг өргөх зам дагуу нарийн хивс, цэцэг өргөх газарт хивс тус тус дэвсэж, цэцгүүдийг өргөх дарааллаар байрлуулна.

28.3.2. Үлээвэр найрал хөгжим “Шивээ хиагт” аяыг эгшиглүүлэхэд Хүндэт харуулын цэргүүд цэцгүүдийг хоёр талаас нь барьж хүндэтгэлийн алхаагаар явж Д.Сүхбаатарын хөшөөний өмнө дэвссэн хивсэн дээр дарааллын дагуу баруун, зүүн тал руу нь ээлжлэн байрлуулна. Цэцэг өргөгчид цэцгийн өмнө мэхийн ёслоод хөшөөг нар зөв тойрч, хөшөөний зүүн хойд талд гаран цэцэг өргөсөн дарааллаар Хүндэт харуулын Цагаан туг /цаашид “цэргийн Цагаан туг” гэх/ руу харж цуван зогсоно.

28.3.3. Цэцэг өргөх ёслол дуусахад Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал, цэцэг өргөгчид тарж явахад “Миний нутаг” марш эгшиглүүлнэ.

28.3.4. Гадаадын зочин төлөөлөгчид цэцэг өргөхөд тухайн орны болон Монгол Улсын төрийн дууллыг эгшиглүүлнэ.

28.4. Төрийн тамганы хөшөөнд

28.4.1. Хөшөөний баруун талд Үлээвэр найрал хөгжим, зүүн талд Хүндэт харуулын цэргүүд урагшаа харан жагссан байна. Төрийн ордны хойд гол хаалганаас хөшөө хүртэл цэцэг өргөх зам дагуу нарийн хивс, цэцэг өргөх газарт хивс тус тус дэвсэж, цэцгийг өргөх дарааллын дагуу байрлуулна.

28.4.2. Үлээвэр найрал хөгжим “Төрийн Их Туг заллага” аяыг эгшиглүүлэхэд Хүндэт харуулын цэргүүд цэцгийг хоёр талаас нь барьж хүндэтгэлийн алхаагаар явж хивсэн дээр дарааллын дагуу баруун, зүүн тал руу нь ээлжлэн байрлуулна. Цэцэг өргөгчид мэхийн ёслоод хөшөөг нар зөв тойрч хөшөөний баруун урд болон зүүн урд талд зогсоно.

28.4.3. Цэцэг өргөж дуусахад Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал, цэцэг өргөгчид тарж явахад “Ялалт” марш эгшиглүүлнэ.

28.5. Хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөө болон Сонгино хайрхан дахь Хэлмэгдэгсдийн булшинд

28.5.1. Хэлмэгсдийн дурсгалын хөшөөний баруун урд талбайд Хүндэт харуул, Үлээвэр найрал хөгжим зүүн тийш харж жагсана. Хөшөө хүртэл нарийн хивс дэвсэж цэцгийг өргөх дарааллаар байрлуулна.

28.5.2. Үлээвэр найрал хөгжим “Эмгэнэн дуурсах” аялгуу эгшиглүүлэхэд Хүндэт харуулын цэргүүд цэцгүүдийг хоёр талаас нь барьж хүндэтгэлийн алхаагаар явж хөшөөний өмнө талд дарааллуулан байрлуулна. Цэцэг өргөгчид хөшөөний өмнө мэхийн ёслоод шатаар өгсөн хөшөөг нар зөв бүтэн тойрч хөшөөний зүүн урд талд гаран цэцэг өргөсөн дарааллаар цэргийн Цагаан туг руу харж зогсоно.

28.5.3. Цэцэг өргөх ёслол өндөрлөхөд Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал, цэцэг өргөгчид тарж явахад “Миний нутаг” марш эгшиглүүлнэ.

28.5.4. Хэлмэгдэгсдийн булшны хайсны гадна зүүн талбайд Хүндэт харуул, Үлээвэр найрал хөгжим жагсана. Булшны хайсны хаалга хүртэл нарийн хивс дэвсэж цэцгийг өргөх дарааллаар байрлуулна.

28.5.5. Үлээвэр найрал хөгжим “Эмгэнэн дуурсах” аялгуу эгшиглүүлэхэд Хүндэт харуулын цэргүүд цэцгүүдийг хоёр талаас нь барьж хүндэтгэлийн алхаагаар явж хайсан дотор булшны өмнө байрлуулна. Цэцэг өргөгчид мэхийн ёслоод хайсны гадна талаар нар зөв тойрч булшны баруун талд цэргийн Цагаан туг руу харж зогсоно.

28.5.6. Цэцэг өргөх ёслол өндөрлөхөд Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал, цэцэг өргөгчид тарж явахад “Миний нутаг” марш эгшиглүүлнэ.

28.6. Зайсан толгой дахь Зөвлөлтийн дайчдын дурсгалын болон Г.К.Жуков, “Хувьсгалт Монгол” танк, “Монгол Ард” эскадрилийн хөшөөнд

28.6.1. Хөшөөний дэргэд Хүндэт харуул, Үлээвэр найрал хөгжим жагссан байна. Хөшөө хүртэл нарийн хивс дэвсэж, цэцгүүдийг өргөх дарааллаар байрлуулна.

28.6.2. Үлээвэр найрал хөгжим “Зөвлөлтийн дайчдын хөшөө” аялгуу эгшиглүүлнэ. Хүндэт харуулын цэргүүд цэцгийг хоёр талаас нь барьж хүндэтгэлийн алхаагаар явж хөшөөний өмнө дараалуулан байрлуулна. Цэцэг өргөгчид хүндэтгэл илэрхийлээд, хөшөөг нар зөв тойрч байраа эзлэн зогсоно.

28.6.3. Цэцэг өргөж дуусахад Төрийн дуулал, цэцэг өргөгчид тарж явахад “Ялалтын өдөр” марш эгшиглүүлнэ.

28.6.4. Гадаадын зочин төлөөлөгчид цэцэг өргөхөд тухайн орны болон Монгол Улсын Төрийн дуулал эгшиглүүлнэ.

29. Эмгэнэн гашуудах ёслол

29.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд таалал төгсөхөд

29.1.1. Таалал төгссөн тухай Улсын Их Хурал, Засгийн газраас гүн эмгэнэлтэйгээр мэдэгдэж талийгаачийн зураг, намтрыг хэвлэлд нийтлүүлэн, Монголын үндэсний олон нийтийн радио телевизээр нэвтрүүлж, хилийн чанадад суугаа болон Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад мэдээлнэ.

29.1.2. Засгийн газраас оршуулах ажлыг зохион байгуулах Комисс томилох бөгөөд уг Комисс орон даяар гашуудал зарлах өдрүүд, шарил байрлуулах газар, салах ёс гүйцэтгэх хугацааг товлож, хэзээ, хаана оршуулахыг шийдвэрлэж зарлана.

29.1.3. Орон даяар Төрийн далбааг гашуудлын өдрүүдэд 45 хэмээр бөхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулгаж, урлагийн тоглолт болон баяр ёслолын арга хэмжээ зохиохыг хориглоно.

29.1.4. Гадаадын төлөөлөгчид оршуулах ёслолд оролцох болон оролцуулах асуудлыг эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

29.2. Салах ёс гүйцэтгэх

29.2.1. Салах ёс гүйцэтгэх танхимын гадаа гол хаалган дээр талийгаачийн хөргийг байрлуулна. Танхимын цонх, чийдэнг эмгэнэлийн байдлаар бүдгэрүүлэн бүтээнэ.

29.2.2. Танхимын хоймор талд тусгай зассан тавцан дээр шарилыг байрлуулж, сагстай амьд цэцэг тойруулан тавина. Танхимд байнга арц, хүж уугиулна. Хүндэт харуулын цэргүүд шарилыг хүндэтгэн зогсоно.

29.2.3. Талийгаачийн гэр бүлийн саналыг харгалзан Шарилын хайрцагны тагийг хөх цэнхэр, хайрцгийг ногоон торгоор доторлож, шарилыг цагаан өнгийн торгоор бүтээсэн байна. Хайрцгийг алтан саатай шар бүсээр гурав бүсэлсэн байдлаар бэхлэхээр бэлтгэнэ.

29.2.4. Талийгаачийн жаазтай том хөргийг шарилын толгой талд өндөрт байрлуулж хадгаар бүтээн, жаазны зүүн доод өнцгийг хар, улаан даавуугаар чагтална. Хөргийн баруун талд Төрийн далбааг бөхийлгөн зална. Хөргийн өмнө улаан жинтүүн дээр шагналын одон, тэмдгийг байрлуулсан байна. Хөргийн урд 108 зул бэлтгэсэн байна /ар гэрийн хүсэлтээр/.

29.2.5. Салах ёс гүйцэтгэх ёслол эхлэхэд талийгаачийн гэр бүл, төрөл төрөгсөд, Комиссын гишүүд болон төрийн дээд, өндөр албан тушаалтан нар дээр дурдсан дарааллын дагуу ээлж ээлжээр шарилийн дэргэд эмгэнэл илэрхийлж зогсоно.

29.2.6. Салах ёс гүйцэтгэхээр хүрэлцэн ирсэн хүмүүс Комиссын зохион байгуулснаар салах ёс гүйцэтгэнэ.

29.2.7. Салах ёс гүйцэтгэх ёслол эхлэхээс дуусах хүртэл Симфони найрал хөгжим гашуудлын аялгуу эгшиглүүлж байна.

29.3. Оршуулах

29.3.1. Шарилыг танхимаас гаргахын өмнө Комиссын гишүүд, талийгаачийн төрөл төрөгсөд, гэр бүл гэсэн дарааллаар шарилын дэргэд эмгэнэл илэрхийлж зогсоно.

29.3.2. Салах ёс гүйцэтгэх байрнаас гашуудлын цуваа талийгаачийн хөрөг, шагнал, албан байгууллага, хүмүүсээс тавьсан цэцгүүд, шарил, талийгаачийн гэр бүл, Комисс, ёслолд оролцогчид гэсэн дарааллаар гарна.

29.3.3. Шарил байрлуулсан байрны гадна босгон дээр нь хөндлөн байдлаар нарийн мод тавьж, шарилаа толгой талаар нь гаргахдаа гишгэн хугална. Шарилыг гаргахад Үлээвэр найрал хөгжим гашуудлын ая эгшиглүүлж, Хүндэт харуул жагсана. Гашуудлын цуваа салах ёс гүйцэтгэх байрнаас гарч алгуурхан явсаар зүг

гарган байрлуулсан шарил ачих машины харалдаа ирэхэд талийгаачийн хөрөг, шагнал, байгууллага, хүмүүсээс тавьсан цэцгүүдийг барьсан ар гэрийн төлөөлөл, Хүндэт харуулууд баруун, зүүн тийш ээлжлэн байрлаж зам гарган зогсоно. Хүндэт харуулууд шарилыг толгой талаар нь машинд зална. Машинд цагаан эсгий дэвссэн байна.

29.3.4. Гашуудлын цуваа оршуулах газрын зүг алгуурхан хөдөлнө. Цувааны эхэнд хөтөч машин, ёслолын албаны машин, шарил байрлуулсан машин түүний дараа гэр бүл, Комиссын гишүүд, төр, засгийн өндөр албан тушаалтнууд, төрөл, төрөгсөд, бусад ёслолд оролцогчдын машин явна. Цуваанд явах машинуудыг дугаарлана.

29.3.5. Цуваа “Алтан-Өлгий” хүндэтгэлийн оршуулгын газрын “А” хэсэгт ирэхэд Үлээвэр найрал хөгжим гашуудлын ая эгшиглүүлнэ. Шарилыг машинаас буулган цагаан эсгий дээр зассан суурь дээр байрлуулна. Талийгаачийн хөрөг, шагнал болон цэцгүүдийг шарилын толгой талд нь барьж зогсоно. Төр, засгийн удирдагчид, Комиссын гишүүд, гэр бүл болон оршуулах ёслолд оролцогчид байраа эзэлнэ.

29.3.6. Комиссын дарга гашуудлын цуглааныг нээж үг хэлнэ. Цуглаан дээр гэр бүл, төрөл төрөгсөд болон иргэдийг төлөөлж тус бүр нэг хүн үг хэлж болно. Үг хэлж дуусах бүрт Үлээвэр найрал хөгжим гашуудлын аялгуу эгшиглүүлнэ.

29.3.7. Гэр бүл, төрөл төрөгсөд нь салах ёс гүйцэтгэхэд гашуудлын аялгууг зогсооно. Хайрцагны тагийг хааж бэхлэхэд Үлээвэр найрал хөгжим гашуудлын аялгуу эгшиглүүлнэ. Шарилыг эх газрын алтан хөрсөнд байрлуулж далдална. Энэ үед их бугаар төрийн ёслолын ахлалын 1-т хамаарах албан тушаалтанд 21 удаа, 2-3-т 18 удаа ёслолын буудлага хийнэ. Төв, орон нутагт бөхийлгөсөн болон буулгасан Төрийн далбааг хэвийн байдалд оруулна. Комиссын дарга ар гэрийн төлөөллийн хамт хөшөөний бүтээлгийг авахад Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ.

29.3.8. Комиссоос гашуудал тайлах цагаалга хийнэ. Цагаалга дээр Комиссын дарга, ар гэрийн төлөөлөл үг хэлж гашуудал тайлна.

29.3.9. Гадаадын төлөөлөгчид оршуулах ёслолд ирсэн тохиолдолд Ёслолын газрын захирал буюу ажилтан угтаж, үднэ.

29.3.10. Энэхүү журамд заасан оршуулах ёслолд ар гэрийн хүсэлтийг харгалзан оруулах өөрчлөлтийг комисс шийдвэрлэнэ.

29.4. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад

29.4.1. Таалал төгссөн тухай мэдээ авмагц суугаа орны Гадаад хэргийн яам болон тухайн оронд суугаа манай улстай дипломат харилцаатай орнуудын Дипломат төлөөлөгчийн газарт ноот бичгээр мэдээлнэ. Ноот нь ёслол хүндэтгэлийн үггүй байх бөгөөд манай Дипломат төлөөлөгчийн газарт эмгэнэл илэрхийлэх өдөр, цагийг заана.

29.4.2. Талийгаачийн хөргийг жаазлан, жаазны зүүн доод өнцгийг хар, улаан даавуугаар чагтлан гашуудлын байдлаар бэлтгэн тусгай танхимд зассан өндөр тавиур дээр байрлуулж, эргэн тойрон амьд цэцэг байрлуулна. Хөргийн баруун талд Төрийн далбааг бөхийлгөн зална. Танхимд эмгэнэлийн дэвтэр бэлтгэж, ширээн дээр тавина.

29.4.3. Суугаа орны удирдагчид болон иргэдийн төлөөлөгчид, Дипломат төлөөлөгчийн газруудаас эмгэнэл илэрхийлэхээр ирэхэд нь Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн эсхүл түүний дараах албан тушаалтан хүлээн авч, явахад нь талархал илэрхийлнэ.

29.4.4. Дипломат төлөөлөгчийн газрын албан байр дээр Төрийн далбааг гашуудлын өдрүүдэд 45 хэмээр бөхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулган эмгэнэл илэрхийлнэ.

29.5. Төр, засгийн удирдах албан тушаалтан таалал төгсөхөд

29.5.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын болон Улсын Их Хурлын холбогдох гишүүд, орон нутгийн удирдлага эмгэнэлийн бичигт гарын үсэг зурж хэвлэлд нийтэлж, радио телевизээр мэдээлнэ.

29.5.2. Салах ёс гүйцэтгэх, оршуулахдаа энэхүү журмын 29.2.2-29.2.7, 29.3.1-29.3.8-д заасныг жишиг болгох бөгөөд орон даяар гашуудал зарлахгүй, Төрийн далбааг бөхийлгөх буюу буулгахгүй, шарил байрлуулсан байрны гадна талд талийгаачийн хөргийг байрлуулахгүй, оршуулгын газарт Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлэх боловч ёслолын буудлага хийхгүй.

29.5.3. Төрийн ёслолын ахлалын 1-3-т хамаарах албан тушаал хашиж явсан төрийн зүтгэлтэн, төрийн ёслолын ахлалын 4-7-д хамаарах албан тушаалтан таалал төгсөхөд энэхүү журмын 29.5.2-т заасныг мөрдөн тэдний оршуулгын ажиллагаа “Алтан-Өлгий” хүндэтгэлийн оршуулгын газрын “А” хэсэгт болно. Төр, засгийн бусад өндөр албан тушаалтан таалал төгсөхөд нутаглуулах газрыг тэдний гэрээслэл, ар гэрээс гаргасан хүсэлтийг харгалзан шийдвэрлэнэ.

29.6. Эмгэнэлийн бичиг үйлдэх

29.6.1. Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, төр, нийгмийн зүтгэлтэн, төрийн шагналтан, ардын болон гавьяат цолтон, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Элчин, цэргийн дээд цолтны эмгэнэлийн бичигт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын болон Улсын Их Хурлын холбогдох гишүүд, орон нутгийн удирдлагууд гарын үсэг зурна.

29.6.2. Төрийн ёслолын алба Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гарын үсэг зурсан эмгэнэлийн бичгийг хэвлэлд нийтлэх, радио телевизээр мэдээлэх зөвшөөрөл олгоно.

29.6.3. Албан үүргээ гүйцэтгэж яваад амь нас эрсэдсэн төр, захиргааны албан хаагчдад төр, засгийн нэрийн өмнөөс Засгийн газрын холбогдох гишүүн эмгэнэл илэрхийлнэ. Оршуулах ажиллагааг зохион байгуулах Комисс томилон ажиллуулж, ар гэрийнхэнд нь туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж болно.

29.6.4. Эх орон, ард түмнийхээ төлөө онцгой гавьяа байгуулж, амь насаа алдсан хүмүүст төр, засгийн тэргүүн нар эмгэнэл илэрхийлж, орон даяар гашуудал зарлаж болно.

29.7. Эмгэнэл илэрхийлэх

29.7.1. Монгол Улсын төрийн дээд, өндөр албан тушаалтан таалал төгсөх тохиолдолд эмгэнэл илэрхийлэх, салах ёс гүйцэтгэх ёслолд гадаад улсын төлөөлөгч, гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд, Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгч нарыг оролцуулах асуудлыг Гадаад хэргийн яам зохицуулж, Ёслолын газар, Төрийн ёслолын алба хамтран хэрэгжүүлнэ.

29.7.2. Гадаад улсын төрийн дээд, өндөр албан тушаалтан, гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд, Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгч таалал төгсөхөд монголын талаас эмгэнэл илэрхийлэх хэлбэр, эмгэнэл илэрхийлэх, салах ёс гүйцэтгэх ёслолд оролцох асуудлыг Гадаад хэргийн яам зохицуулж, Ёслолын газар хэрэгжүүлнэ.

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ ЁСЛОЛ

30. Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайдад Итгэмжлэх жуух бичиг олгох

30.1. Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсаас гадаад улсад суух Элчин сайдад Итгэмжлэх жуух бичиг, түүний өмнөх Элчин сайдын Эгүүлэн дуудах захидлыг шийтгэн олгоно.

30.2. Гадаад улсын Засгийн газар Монгол Улсаас тус улсад суух Элчин сайдад зөвшөөрөл /агреман/ олгосны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган Элчин сайдыг томилох бөгөөд гадаад улсын Засгийн газар шинэ Элчин сайдад зөвшөөрөл олгосны дараа олон нийтэд албан ёсоор зарлана.

30.3. Итгэмжлэх жуух бичиг, Эгүүлэн дуудах захидлыг монгол бичгээр үйлдэнэ. Итгэмжлэх жуух бичиг, Эгүүлэн дуудах захидлын эх хувьд Монгол Улсын Ерөнхийлөгч гарын үсэг зурж, Гадаад хэргийн сайд баталгаажуулан гарын үсэг зурна. Итгэмжлэх жуух бичиг, Эгүүлэн дуудах захидлын хувийг мөн үйлдэнэ. Итгэмжлэх жуух бичиг, Эгүүлэн дуудах захидлын орчуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын аль нэг хэлээр үйлдэж хавсаргана.

30.4. Монгол Улсын Ерөнхийлөгч шинээр томилогдсон Элчин сайдыг хүлээн авч Итгэмжлэх жуух бичгийг нь гардуулна.

31. Монгол Улсаас Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчид Итгэмжлэх захидал олгох

31.1. Монгол Улсын Ерөнхий сайд тус улсаас Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчид Итгэмжлэх захидал, түүний өмнөх Байнгын төлөөлөгчид Эгүүлэн дуудах захидал шийтгэн олгоно.

31.2. Итгэмжлэх захидал, Эгүүлэн дуудах захидлыг монгол бичгээр үйлдэнэ. Итгэмжлэх захидал, Эгүүлэн дуудах захидлын эх хувьд Монгол Улсын Ерөнхий сайд гарын үсэг зурж, Гадаад хэргийн сайд баталгаажуулан гарын үсэг зурна. Итгэмжлэх захидал, Эгүүлэн дуудах захидлын хувийг мөн үйлдэнэ. Итгэмжлэх захидал, Эгүүлэн дуудах захидлын орчуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын аль нэг хэлээр үйлдэж хавсаргана.

31.3. Монгол Улсын Ерөнхий сайд шинээр томилогдсон Байнгын төлөөлөгчийг хүлээн авч Итгэмжлэх захидлыг нь гардуулна.

32. Гадаад улсаас Монгол Улсад суух Элчин сайдыг хүлээн авах, үдэх

32.1. Гадаад улсаас Монгол Улсад суух Элчин сайдыг хүлээн авах

32.1.1. Гадаад улсаас Монгол Улсад суух Элчин сайд анх удаа ирэхэд нисэх онгоцны буудалд Ёслолын газрын ахлах дипломат ажилтан угтана.

32.1.2. Монгол Улсын Гадаад хэргийн дэд сайд, түүний эзгүйд Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Элчин сайдтай уулзан түүний

Итгэмжлэх жуух бичиг болон өмнөх Элчин сайдыг Эгүүлэн дуудах захидлын хувийг хүлээн авна.

32.1.3. Ёслолын газрын захирал Элчин сайдтай уулзан Итгэмжлэх жуух бичиг болон өмнөх Элчин сайдыг Эгүүлэн дуудах захидал гардуулах ёслолын журмыг тайлбарлаж өгнө.

32.1.4. Монгол Улсад суух Элчин сайд Итгэмжлэх жуух бичиг, өмнөх Элчин сайдын Эгүүлэн дуудсан захидлаа Монгол Улсын Ерөнхийлөгчид гардуулна.

32.1.5. Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад байнга суух Элчин сайдын Итгэмжлэх жуух бичгийг ирснээс нь хойш нэг сарын дотор хүлээн авна.

32.1.6. Монгол Улсын Ерөнхийлөгч хавсран суух Элчин сайдын жуух бичгийг улиралд нэг удаа хүлээн авна. Нэг удаад 5 хүртэл тооны хавсран суух Элчин сайдыг хүлээн авч болно.

32.1.7. Ёслолын газар Элчин сайдын жуух бичиг барих ёслолыг зохион байгуулах товыг Ерөнхийлөгчийн Тамгын газартай хэлэлцэн тогтоож, Элчин сайдад хувийн ноотоор мэдэгдэнэ.

32.1.8. Итгэмжлэх жуух бичиг гардуулах ёслолд Гадаад хэргийн сайд, түүний эзгүйд дэд сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, түүний эзгүйд Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх, Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал, Ёслолын газрын захирал нар оролцоно. Энэ ёслолд тухайн улсын Элчин сайдын гэргий /нөхөр/, хоёр хүртэл дипломат ажилтан оролцоно.

32.1.9. Гадаад хэргийн яам шинээр томилогдсон Элчин сайдын намтар, уулзалт ярианы сэдэв, холбогдох лавлах материалыг Ерөнхийлөгчийн Тамгын газарт урьдчилан хүргүүлнэ.

32.1.10. Хэрэв Элчин сайд хүсвэл, Цэргийн Үлээвэр найрал хөгжим тухайн улсын төрийн дууллыг тоглож урьдчилан хянуулж болно. Ёслолын газар тухайн улсын төрийн дууллын албан ёсны аудио бичлэг, ноотыг Цэргийн Үлээвэр найрал хөгжимд 7 хоногийн өмнө хүргүүлж бэлтгүүлнэ.

32.2. Итгэмжлэх жуух бичиг гардуулах ёслол

32.2.1. Элчин сайдын Итгэмжлэх жуух бичиг гардуулах ёслол Чингисийн талбайд болон Төрийн ордны Ёслол, хүндэтгэлийн Их танхимд тус тус явагдана.

32.2.2. Итгэмжлэх жуух бичиг гардуулах ёслолын бэлтгэл ажил бүрэн хангагдсаныг ёслол эхлэхээс нэг цагийн өмнө Төрийн ёслолын алба, Ёслолын газар хамтран шалгаж нягтална.

32.2.3. Чингисийн талбайд угтах ёслол

а/ Чингисийн талбайн төвд Монгол Улсын төрийн далбаа, тухайн улсын төрийн далбааг мандуулна. Тухайн улсын төрийн далбааг баруун талд, Монгол Улсын Төрийн далбааг зүүн талд тус тус мандуулна. Ёслолын газар тухайн улсын

Төрийн далбааны албан ёсны загвар, стандартыг Төрийн ёслолын албанд 7 хоногийн өмнө хүргүүлж бэлтгүүлнэ.

б/ Элчин сайдын хөлөглөсөн машин зогсох газарт, Ёслолын газрын захирал, Элчин сайд нар Хүндэт харуулын даргын айлтгалыг хүлээн авч, хоёр орны Төрийн дуулалыг хүндэтгэн сонсох газарт, Их эзэн Чингис хааны хөшөөний болон Төрийн ёслолын цэргийн цагаан тугийн өмнө хивс тус тус дэвссэн байна. Элчин сайдын хөлөглөсөн машин зогсох газраас эхлэн Төрийн ордонд орох хүртэлх угтах ёслол үйлдэх бүх замын дагуу улаан хивс дэвсэнэ.

в/ Хүндэт харуулын хоёр салаа, нийт 55 цэрэг Чингисийн талбайн төв хэсэгт Төрийн ордон руу харан хоёр эгнээгээр жагссан байна. Хүндэт харуулын жагсаалын тэргүүнд Төрийн ёслолын цэргийн цагаан тугийг залсан байна.

г/ Үлээвэр найрал хөгжим Чингисийн талбайд Хүндэт харуулын баруун гар талд Төрийн ордон руу харан жагссан байна.

д/ Их эзэн Чингис хааны хөшөөний хоёр талд Хүндэт харуулын 4 цэрэг зогссон байна.

е/ Итгэмжлэх жуух бичиг гардуулах Элчин сайдын хөлөглөх үндсэн болон нөөц машиныг Төрийн тусгай хамгаалалтын газар гаргаж, Элчин сайдын яам, Элчин сайдын өргөө, зочид буудлаас Чингисийн талбай хүргэх, буцаан хүргэхэд Цагдаагийн байгууллага хамгаалалтын хөтөч машин гаргаж үйлчилнэ.

ё/ Д.Сүхбаатарын хөшөөний урдаас эхлэн Чингисийн талбайн хойд хэсгийг цагдаагийн хамгаалалтад авна. Хамгаалалтыг цагдаагийн байгууллага зохион байгуулна.

ж/ Байнга суух Элчин сайдыг Ёслолын газрын захирал, хавсран суух Элчин сайдыг Ёслолын газрын дэд захирал ёслолын автомашинаар Чингисийн талбайд залж авчирна.

з/ Элчин сайдын хөлөглөсөн машин Чингисийн талбайд ирэхэд, Үлээвэр найрал хөгжим “Угтах ая” эгшиглүүлж байна.

и/ Элчин сайдын хөлөглөсөн машин товлосон газарт зогсоход Төрийн ордны хамгаалалтын албаны хоёр ажилтан машины хойд талын хоёр хаалгыг зэрэг нээн өгч ёсолно.

й/ Элчин сайд, Ёслолын газрын захирал нар машинаас бууж, улаан хивсэн дээгүүр явна. Ёслолын газрын захирал Элчин сайдыг баруун гар талдаа авч явна.

к/ Элчин сайд, Ёслолын газрын захирал нар тусгайлан зассан хивсэн дээр ирж, Хүндэт харуулын зүг харан зогсоно. Ёслолын газрын захирал Элчин сайдыг баруун гар талдаа авч зогсоно.

л/ Ёслолын газрын ажилтан Элчин сайдын гэргий, дипломат ажилтан нарыг угтан авч, Төрийн ордны хүндэтгэлийн шатны өмнө урд зүг рүү харуулан баруун гар талаас дипломат ёслолын ахлалаар нэг эгнээгээр зогсоно.

м/ Элчин сайд, Ёслолын газрын захирал нар хивсэн дээр ирж зогсоход, Хүндэт харуулын дарга жагсаалын алхаагаар угтан очиж, "... Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрхэмсэг ноён/хатагтай/ Таныг хүндэтгэн Монгол Улсын Хүндэт харуул жагссан. Хүндэт харуулын даргацэргийн цол, нэр овог/" гэж айлтгал өргөөд, байрандаа баруун гар тийш эргэж Элчин сайд, Ёслолын газрын захирал нарын зүг хараа шилжүүлэн зогсоход Үлээвэр найрал хөгжим эхлээд тухайн улсын төрийн дууллыг дараа нь Монгол Улсын төрийн дууллыг эгшиглүүлнэ.

н/ Төрийн дуулал эгшиглэж дуусахад Ёслолын газрын захирал Элчин сайдыг баруун гар талдаа авч Хүндэт харуулын жагсаалын тэргүүнд залсан Төрийн ёслолын цэргийн цагаан тугны зүг улаан хивсэн дээгүүр явна. Хүндэт харуулын дарга гурван алхамын зайнд жагсаалын алхаагаар явна. Элчин сайд, Ёслолын газрын захирал нар Төрийн ёслолын цэргийн цагаан тугны өмнө очиж толгой мэхийн хүндэтгэл илэрхийлнэ. Ёслолын газрын захирал Элчин сайдыг баруун гар талдаа авч зогсоно.

о/ Төрийн ёслолын цэргийн цагаан туганд хүндэтгэл үзүүлсний дараа Ёслолын газрын захирал Элчин сайдыг зүүн гар талдаа авч яван Хүндэт харуулын өмнүүр алхана. Ёслолын газрын захирал, Элчин сайд нар Хүндэт харуулын жагсаалыг голлон хүндэт харуулын зүг харан зогсоно. Элчин сайд Хүндэт харуулын цэргүүдтэй "Цэргүүд ээ, сайн байцгаана уу" гэж төрөлх хэл дээрээ мэндэлнэ. Хүндэт харуулын цэргүүд "Хүндэт Элчин сайдын амрыг эрье" хэмээн хариу мэндэлнэ. Ёслолын газрын захирал Элчин сайдын баруун хойд талд нэг алхам зайтай зогсож байна.

ө/ Хүндэт харуулын цэргүүд мэндэлсний дараа Ёслолын газрын захирал Элчин сайдыг зүүн гар талдаа авч Хүндэт харуулын жагсаалын төгсгөл хүртэл явна. Ёслолын газрын захирал, Элчин сайд нар жагсаалын төгсгөлд очоод эргэж харан зогсоод харуулын даргад толгой мэхийн ёслоод цааш эргэж явна. Хүндэт харуулын дарга эргэж, жагсаалын дунд хүртэл буцаж алхана.

п/ Ёслолын газрын захирал энэ үеэс Элчин сайдыг баруун гар талдаа дагуулан Төрийн ордны зүг улаан хивсэн дээгүүр явна.

р/ Ёслолын газрын захирал Элчин сайдыг баруун гар талдаа авч хүндэтгэлийн шатаар өгсөн, Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө дэвссэн хивсэн дээр очин зогсож, толгой бөхийн ёслоод Төрийн ордонд хөшөөний баруун талын хаалгаар орно. Элчин сайдын гэргий, дипломат ажилтан нар дагалдан явна.

32.2.4. Төрийн ёслол хүндэтгэлийн Их танхимд хүлээн авах ёслол

а/ Ёслолын газрын захирал Элчин сайдыг Төрийн ёслол хүндэтгэлийн "Баганат" танхимд дагуулан орж ирэхэд Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал угтана. Тухайн орон хариуцсан дипломат ажилтан байлцана.

б/ Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн Их танхимд Монгол Улсын Ерөнхийлөгч, Гадаад хэргийн сайд, түүний эзгүйд дэд сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, түүний эзгүйд Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх нар хүрэлцэн ирж байраа эзэлмэгц, Ёслолын газрын захирал Элчин сайдыг урьж оруулна. Элчин сайдын арын эгнээнд зүүн гар талаас Ёслолын газрын захирал, баруун гар талаас

Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал, тэдний ар талд Элчин сайдын гэргий /нөхөр/, дипломат ажилтан нар нэг эгнээгээр баруун гар талаас дипломат ёслолын ахлалаар зогсоно.

в/ Ёслолд оролцогчид байраа эзэлмэгц Ёслолын газрын захирал “Эрхэмсэг ноён Ерөнхийлөгч өө, ... Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрхэмсэг ноён /хатагтай/ ... Итгэмжлэх жуух бичгээ гардуулахаар хүрэлцэн ирснийг айлтгая” гэж монгол хэлээр танилцуулна. Элчин сайд Ерөнхийлөгчид толгой мэхийн ёслоод эх хэлээр, эсвэл НҮБ-ын аль нэг хэлээр “Эрхэмсэг ноён Ерөнхийлөгч өө, ...Улсын Ерөнхийлөгч /Эзэн хаан, Хатан хаан/ Эрхэмсэг ноён /хатагтай/ ... намайг Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тохоон томилсон Итгэмжлэх жуух бичгээ гардуулахад баяртай байна” гэж хэлээд Ерөнхийлөгчийн зүг алхаж жуух бичгээ хоёр гараар өргөн бариад ар тийш алхаж байраа эзэлнэ.

г/ Ерөнхийлөгч жуух бичгийг хүлээн аваад Элчин сайдад хандан “Эрхэмсэг ноён /хатагтай/ Элчин сайд аа, Таныг ... Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тохоон томилсон Итгэмжлэх жуух бичгийг хүлээн авч байгаадаа баяртай байна” гэж монгол хэлээр хариу хэлэх бөгөөд Ерөнхийлөгчийн үгийг орчуулахгүй.

д/ Ерөнхийлөгч хариу үгээ төгсгөмөгц Ёслолын газрын захирал Элчин сайдыг Ерөнхийлөгчид залж хүргэнэ. Элчин сайд Ерөнхийлөгчтэй гар барин мэндэлнэ. Элчин сайд дагалдан яваа гэргий /нөхөр/, дипломат ажилтан нараа Ерөнхийлөгчид танилцуулна.

е/ Ёслолын газрын захирал Гадаад хэргийн сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нарыг Элчин сайдад танилцуулна.

ё/ Ерөнхийлөгч, Элчин сайд, Элчин сайдын гэргий /нөхөр/ нар дурсгалын гэрэл зураг авахуулна. Ерөнхийлөгчийн баруун гар талд Элчин сайд, зүүн гар талд гэргий /нөхөр/ нь зогсоно.

ж/ Ерөнхийлөгч Монгол Улсад байнга суух Элчин сайдтай Ёслол хүндэтгэлийн “А” танхимд ёслолын уулзалт хийнэ. Уулзалтад Гадаад хэргийн сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх, Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал нар, тухайн улсын дипломат ажилтнууд оролцоно. Хоёр талын хэлмэрч, тэмдэглэл хөтлөгч байна. Элчин сайдын гэргий /нөхөр/ ёслолын уулзалтад оролцохгүй бөгөөд Ёслол хүндэтгэлийн “Б” танхимд хүлээж байна.

з/ Хавсран суух Элчин сайдтай ёслолын уулзалт хийхгүй. Тухайн өдөр Итгэмжлэх жуух бичиг гардуулсан хавсран суух Элчин сайд нарт зориулан Итгэмжлэх жуух бичиг гардуулсан ёслолын дараа цайллага зохион байгуулна. Цайллагын үеэр Ерөнхийлөгч хавсран суух Элчин сайд бүртэй товч ярилцана.

и/ Ёслолын уулзалт, цайллага өндөрлөсний дараа Ёслолын газрын захирал Элчин сайдыг Төрийн ордны ёслолын хаалгаар авч гаран, ёслолын машинаар өргөө, зочид буудалд нь хүргэж өгнө. Элчин сайдын машинд тухайн улсын Төрийн далбааг мандуулна.

й/ Итгэмжлэх жуух бичиг гардуулсан ёслолын гэрэл зурагнаас Элчин сайдад дурсгана.

к/ Элчин сайд Итгэмжлэх жуух бичгээ гардуулж, үүрэгт ажилдаа орсны дараа өөрийн хүсэлтээр Монгол Улсын төр, засгийн удирдагчидтай танилцах уулзалт хийж болно. Элчин сайд энэ хүсэлтээ Ёслолын газарт ноот бичгээр тавина. Гадаад хэргийн яам хоёр орны харилцааны түвшин, харилцан адил байх зарчмыг харгалзан зохицуулна.

32.3. Гадаад улсаас Монгол Улсад суух Элчин сайдыг үдэх

32.3.1. Монгол Улсад байнга суугаа Элчин сайд эх орондоо бүрмөсөн буцахад Монгол Улсын төрийн дээд, өндөр албан тушаалтнуудтай хүсэлтийнх нь дагуу ёслолын үдэлтийн уулзалт хийлгэнэ.

32.3.2. Монгол Улсад суугаа Элчин сайд ажиллах хугацаандаа үр дүнтэй ажиллаж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд жинтэй хувь нэмэр оруулсан бол Монгол Улсын төрийн одон, медалиар шагнаж болно. Энэ тохиолдолд тухайн улсын Засгийн газрын зөвшөөрлийг урьдчилан авна.

32.3.3. Монгол Улсад байнга суугаа Элчин сайд эх орондоо бүрмөсөн буцахад Гадаад хэргийн сайд зоог барьж, дурсгалын зүйл бэлэглэнэ.

32.3.4. Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд эх орондоо бүрмөсөн буцахад Монгол Улсын Гадаад хэргийн сайд хүсэлтийнх нь дагуу ёслолын үдэлтийн уулзалт хийнэ.

32.3.5. Монгол Улсад суугаа Элчин сайд эх орондоо бүр мөсөн буцахад нисэх онгоцны буудалд Ёслолын газрын ажилтан үднэ.

33. Гадаад улсаас Монгол Улсад суух Хэргийг хамаарагчийг хүлээн авах, үдэх

33.1. Монгол Улсад байнга суух Хэргийг хамаарагч анх удаа хүрэлцэн ирэх болон бүр мөсөн буцахад нисэх онгоцны буудалд Ёслолын газрын ажилтан угтаж, үднэ.

33.2. Монгол Улсад байнга суух Хэргийг хамаарагч Итгэмжлэх захидлаа Гадаад хэргийн сайдад барина. Хэргийг хамаарагчийн Итгэмжлэх захидлыг ирснээс нь хойш нэг сарын дотор хүлээн авна. Ёслолын газрын захирал Итгэмжлэх захидал гардуулах товыг Хэргийг хамаарагчид хувийн ноотоор мэдэгдэнэ.

33.3. Итгэмжлэх захидал гардуулах ёслолд Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал, Ёслолын газрын захирал нар оролцоно. Газрын захирал нар эзгүй тохиолдолд газрын дэд захирал нар оролцоно. Тухайн улсын Элчин сайдын яамны хоёр хүртэл дипломат ажилтан оролцоно.

33.4. Монгол Улсад байнга суух Хэргийг хамаарагч Итгэмжлэх захидал гардуулах ёслолын үеэр Гадаад хэргийн яамны гол хаалганы баруун талд Монгол Улсын, зүүн талд тухайн улсын Төрийн далбааг тус тус мандуулж, улаан хивс дэвсэнэ.

33.5. Итгэмжлэх захидал гардуулсан ёслолын гэрэл зурагнаас Түр хамаарагчид дурсгана.

33.6. Монгол Улсад байнга суугаа Хэргийг хамаарагч эх орондоо бүрмөсөн буцахад Гадаад хэргийн сайд хүлээн авч ёслолын үдэлтийн уулзалт хийж болно.

33.7. Монгол Улсад байнга суугаа Хэргийг хамаарагч эх орондоо бүрмөсөн буцахад Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга үдэлтийн зоог барьж, бэлэг дурсгалын зүйл гардуулна.

34. Засгийн газар хоорондын олон улсын байгууллагаас Монгол Улсад суух Суурин төлөөлөгчийг хүлээн авах, үдэх

34.1. Монгол Улсад суух Суурин төлөөлөгч анх удаа хүрэлцэн ирэх болон бүрмөсөн буцахад Ёслолын газрын ажилтан угтаж, үднэ.

34.2. Монгол Улсад суух Суурин төлөөлөгч Итгэмжлэх захидлаа Гадаад хэргийн сайдад барина. Суурин төлөөлөгчийн Итгэмжлэх захидлыг ирснээс нь хойш нэг сарын дотор хүлээн авна. Ёслолын газрын захирал Итгэмжлэх захидал гардуулах товыг Суурин төлөөлөгчид хувийн ноотоор мэдэгдэнэ.

34.3. Монгол Улсад суух Суурин төлөөлөгч Итгэмжлэх захидал гардуулах ёслолд Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал, Ёслолын газрын захирал нар оролцоно. Газрын захирал эзгүй тохиолдолд газрын дэд захирал оролцоно. Тухайн олон улсын байгууллагын Суурин төлөөлөгчийн газрын хоёр хүртэл ажилтан оролцоно.

34.4. Монгол Улсад суух Суурин төлөөлөгч Итгэмжлэх захидал гардуулах ёслолын үеэр Гадаад хэргийн яамны гол хаалганы баруун талд Монгол Улсын, зүүн талд тухайн олон улсын байгууллагын далбааг тус тус мандуулж, улаан хивс дэвсэнэ.

34.5. Итгэмжлэх захидал гардуулсан ёслолын гэрэл зурагнаас Байнгын төлөөлөгчид дурсгана.

34.6. Монгол Улсад суугаа Суурин төлөөлөгчийг эх орондоо бүрмөсөн буцахад Гадаад хэргийн сайд хүлээн авч ёслолын үдэлтийн уулзалт хийж болно.

34.7. Монгол Улсад суугаа Суурин төлөөлөгчийг эх орондоо бүрмөсөн буцахад Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга үдэлтийн зоог барьж, бэлэг дурсгалын зүйл гардуулна.

35. Гадаад улсаас Монгол Улсад суух батлан хамгаалах, цэргийн атташег хүлээн авах

35.1. Гадаад улс Монгол Улсад суулгах батлан хамгаалахын атташе, цэргийн атташег томилохдоо Монгол Улсын Батлан хамгаалах яамнаас урьдчилан зөвшөөрөл авна. Зөвшөөрлийг Гадаад хэргийн яамаар дамжуулан олгоно.

35.2. Гадаад улсаас Монгол Улсад суух батлан хамгаалахын атташе, цэргийн атташе нар Монгол Улсад ирж, албан ажилдаа орохдоо Монгол Улсын Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд бараалхана.

36. Төлөөлөгчийн газруудтай харилцах

36.1. Элчин сайд нарыг ёслолын аливаа арга хэмжээнд оролцуулахдаа ёслолын ахлалыг ямагт чанд баримтална. Монгол Улсын Ерөнхийлөгчид Итгэмжлэх жуух бичгээ гардуулсан хугацааны дарааллаар Элчин сайд нарын ахлалыг тогтооно. Дипломат корпус нь ахлагч /дуайен/-тай байна. Элчин сайд нараас Итгэмжлэх жуух бичиг гардуулсан хугацааны дарааллаар хамгийн ахмад нь дуайен байна.

36.2. Гадаад улсын Хэргийг хамаарагч нарыг ёслолын аливаа арга хэмжээнд оролцуулахдаа ёслолын ахлалыг ямагт чанд баримтална. Монгол Улсын Гадаад хэргийн сайдад Итгэмжлэх захидлаа гардуулсан хугацааны дарааллаар Хэргийг хамаарагч нарын ахлалыг тогтооно. Дипломат төлөөлөгчийн газрын Түр хамаарагч нарын хувьд Гадаад хэргийн яаманд энэ тухай ноот бичгээр мэдэгдсэн хугацааны дарааллаар ахлалыг нь тогтооно.

36.3. Монгол Улсын Гадаад хэргийн сайд Итгэмжлэх захидлаа гардуулсан хугацааны дарааллаар Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын суурин төлөөлөгч нарын ахлалыг тогтооно.

36.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар Дипломат төлөөлөгчийн болон Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нартай хийх аливаа ажил хэргийн уулзалтыг Ёслолын газар холбогдох газартай хамтран зохион байгуулна. Эдгээр уулзалтад Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал, хэлмэрч, тэмдэглэл хөтлөх ажилтан байлцана.

36.5. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд нар Дипломат төлөөлөгчийн болон Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нарт зориулан жилд нэг удаа ёслолын арга хэмжээ тус тус зохион байгуулж болно.

36.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, Улсын Их Хурлын анхдугаар болон ээлжит чуулганы нээлт, үндэсний баяр наадмын үйл ажиллагаанд Дипломат төлөөлөгчийн болон Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нарыг урьж оролцуулах бөгөөд Ёслолын газар, Төрийн ёслолын албатай хамтран зохион байгуулна.

36.7. Үндэсний баяр, дипломат харилцаа тогтоосны ой, бусад тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан Дипломат төлөөлөгчийн болон Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газраас зохиох ёслолын арга хэмжээнд монголын талаас оролцох төлөөлөгчдийн түвшинг Ёслолын газар холбогдох газартай хамтран зохицуулна.

37. Гадаадын зочид, төлөөлөгчидтэй уулзах

37.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд гадаадын албан ёсны зочин, төлөөлөгчидтэй хийх

уулзалтыг Ёслолын газар, Төрийн ёслолын алба, холбогдох яамдын гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй хамтран зохицуулж, зохион байгуулна.

37.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гадаадын албан ёсны зочин, төлөөлөгчидтэй хийх уулзалтад холбогдох яамны удирдлага, гадаад бодлогын асуудал эрхэлсэн зөвлөх, Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал, хэлмэрч, тэмдэглэл хөтлөх ажилтан байлцана.

37.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд нар гадаад улсын төрийн дээд албан тушаалтан, Гадаад хэргийн сайдтай хоёр талын болон олон улсын харилцааны асуудлаар утсаар ярихад гадаад бодлогын асуудал эрхэлсэн зөвлөх, гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын захирал нар байлцаж, тэмдэглэл хөтөлнө.

37.4. Улс төрийн нам, төрийн бус байгууллага, аж ахуйн байгууллага урьж ирүүлсэн гадаадын төлөөлөгчийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарт бараалхуулах хүсэлтээ 14 хоногийн өмнө Ёслолын газарт албан бичгээр тавих бөгөөд урьж ирүүлсэн төлөөлөгчийн болон өөрийн байгууллагын тухай дэлгэрэнгүй танилцуулгыг хамт ирүүлнэ. Гадаад хэргийн яам хүсэлтийг хянан үзэж зохицуулна.

37.5. Төрийн ордонд болох уулзалтын хугацаа, танхим болон ёслолын үйлчилгээг зохицуулан холбогдох албадад мэдээлэх, зочдыг угтах, үдэх ажлыг Төрийн ёслолын алба эрхлэн гүйцэтгэнэ.

38. Баяр хүргэх, захидал илгээх

38.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд нар хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны тэгш ой, бусад томоохон үйл явдлыг тохиолдуулан гадаад улс, олон улсын байгууллагын холбогдох албан тушаалтнуудад баяр хүргэж захидал илгээнэ. Энэ захидал нь дипломат баримт бичиг мөн бөгөөд хувийн ноотны хэлбэртэй, монгол бичгээр бичсэн байна.

38.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд нар аргын тооллын шинэ жилийг тохиолдуулан гадаад улсын холбогдох албан тушаалтанд мэндчилгээний хуудас илгээж баяр хүргэнэ.

38.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар шинээр сонгогдох болон томилогдох, аргын тооллын шинэ жилийн баяраар гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нар Төрийн ордонд ирж баяр хүргэж болно.

39. Дээд, өндөр түвшний айлчлал

39.1. Дээд түвшний айлчлалд дараах айлчлал орно:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлал;
- Гадаад улсын төрийн тэргүүний айлчлал;

- Монгол Улсын Их Хурлын даргын айлчлал;
- Гадаад улсын парламентын даргын айлчлал;
- Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлал;
- Гадаад улсын Засгийн газрын тэргүүний айлчлал зэрэг болно.

39.2. Өндөр түвшний айлчлалд дараах айлчлал орно:

- Гадаад улсын дэд ерөнхийлөгчийн айлчлал;
- Монгол Улсын Гадаад хэргийн сайдын айлчлал;
- Гадаад улсын Гадаад хэргийн сайдын айлчлал;
- Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын айлчлал;
- НҮБ-ын төрөлжсөн болон Засгийн газар хоорондын олон улсын бусад байгууллагын тэргүүний айлчлал;
- Гадаад улсын төрийн болон Засгийн газрын тэргүүний бие төлөөлөгчийн айлчлал;
- Гадаад улсын төр, парламент, Засгийн газрын тэргүүн асан хүний айлчлал;
- Гадаад улсын төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнжийн айлчлал;
- Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төр, парламент, Засгийн газрын тэргүүний айлчлал зэрэг болно.

39.3. Дээд, өндөр түвшний айлчлалыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлнэ.

39.4. Дээд, өндөр түвшний айлчлал нь төрийн айлчлал, албан ёсны айлчлал, ажлын айлчлал, хувийн айлчлал гэсэн ангилалтай байна.

39.5. Дээд, өндөр түвшний айлчлалыг Гадаад хэргийн яам удирдан зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

39.6. Дээд, өндөр түвшний айлчлалын түвшин, ангилал, хугацаа, хөтөлбөр, албан ёсны хэлийг дипломат шугамаар тохиролцоно.

40. Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтны айлчлал

40.1. Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтны айлчлал нь төрийн айлчлал, албан ёсны айлчлал, ажлын айлчлал, хувийн айлчлал гэсэн ангилалтай байна. Төрийн айлчлалыг Монгол Улсын Ерөнхийлөгч хийнэ.

40.2. Тухайн улсад анх удаа айлчлах, харилцаа, хамтын ажиллагааны онцгой чухал асуудал хэлэлцэх, баримт бичиг байгуулах зэрэг зорилго бүхий айлчлалыг төрийн болон албан ёсны айлчлалд хамааруулна.

40.3. Хоёр орны хамтын ажиллагааны болон олон улс, бүс нутгийн харилцааны асуудал хэлэлцэх, зөвлөлдөх, санал солилцох, хоёр талын болон олон талын баримт бичиг байгуулах, олон улсын хурал, соёл, урлаг, спортын арга хэмжээ, түүхт ой, тэмдэглэлт үйл явдалд урилгаар оролцох, эмгэнэл илэрхийлэх зорилго бүхий айлчлалыг ажлын айлчлалд хамааруулна.

40.4. Эмчлүүлэх, соёл, урлаг, спортын арга хэмжээ үзэж сонирхох, жуулчлах зэрэг ажил төрлийн бус зорилгоор зорчвол хувийн айлчлалд хамааруулна.

40.5. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гадаад улсад хийх айлчлалын албан ёсны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн-сайд, дэд сайд, Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Гадаад хэргийн яамны холбогдох газрын удирдлага нар багтана. Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд, тухайн олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч нар албан ёсны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтана.

40.6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд нар гадаад улсад төрийн болон албан ёсны айлчлал хийхэд түүний гэргий /нөхөр/ дагалдан явж болох бөгөөд гэргий /нөхөр/-д зориулан тусгай хөтөлбөр гаргана.

40.7. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын гадаад улсад хийх аливаа айлчлалын ёслол хүндэтгэл, зохион байгуулалтын асуудлыг Гадаад хэргийн яам хариуцан зохион байгуулна.

40.8. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гадаад улсад хийх айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн, хөтөлбөрийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нар Гадаад хэргийн сайдтай тус тус хамтран батална.

40.9. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гадаад улсад хийх айлчлалын зардлыг айлчлал хэрэгжихээс ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нар тус тус баталж, гаргана. Айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсон төрийн захиргааны байгууллагын албан тушаалтан зардлаа өөрийн харьяа байгууллагын төсвөөс гаргуулна.

40.10. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гадаад улсад хийх айлчлалыг төрийн бус байгууллагын болон хувь хүний урилга, зардал, зохицуулалтаар хэрэгжүүлэхийг хориглоно.

40.11. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд нар гадаад улсад айлчлахдаа хүлээн авагч улс, олон улсын байгууллагын удирдлагад монгол үндэсний агуулгатай дурсгалын зүйл бэлэглэнэ. Айлчлалын бэлэг, дурсгалын зүйлийг Гадаад хэргийн яамны саналын дагуу Төрийн ёслолын алба бэлтгэнэ.

40.12. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гадаад улсад хийх төрийн болон албан ёсны айлчлалын бэлтгэл ажлыг хангах зорилгоор Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад хэргийн яам, Төрийн тусгай хамгаалалтын газар зэрэг холбогдох байгууллагуудын эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг айлчлал эхлэхээс өмнө тухайн гадаад улсад томилолтоор явж ажиллаж болно.

40.13. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гадаад улсад айлчлалаар очих, буцахад Монгол Улсаас тухай улсад суугаа Элчин сайд, олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, тэдгээрийн эзгүйд Түр хамаарагч нар угтаж, үднэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гэргий/нөхөр/-н хамт айлчилж байгаа бол Элчин сайд, Байнгын төлөөлөгч, Түр хамаарагч нарын гэргий /нөхөр/ угтана.

40.14. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын гадаад улсад айлчлал хийх үед тухайн орны нөхцөл байдлаас шалтгаалан Төрийн тусгай хамгаалалтын газраас явах ажилтны тоог Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Гадаад хэргийн яамтай тохиролцсоны үндсэн дээр нэмж болно.

40.15. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын гадаад улсад хийх аливаа айлчлалын аюулгүй байдлыг Төрийн тусгай хамгаалалтын газар хариуцан хангана. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Гадаад хэргийн сайд гадаад улсад айлчлахдаа албан ёсны хамгаалалтын ажилтантай явж болно.

40.16. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гадаад улсад айлчлалаар явах, буцаж ирэхэд нисэх онгоцны болон галт тэрэгний буудалд Монгол Улсын Төрийн далбаа мандуулна.

40.17. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гадаад улсад айлчлалаар явах, буцаж ирэхэд Монгол Улсын тухайн хилийн боомтын дарга айлтгал өргөнө.

40.18. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар гадаад улсад айлчлалаар явахдаа хөлөглөх Монгол Улсын нисэх онгоцны болон галт тэрэгний дарга түүнд нисэх онгоц болон галт тэрэг бэлэн болсныг илтгэж айлтгал өргөнө.

41. Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлал

41.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн төрийн болон албан ёсны айлчлал

41.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад төрийн болон албан ёсны айлчлал хийхээр явахад түүний гэргий /нөхөр/, албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсгийн мэргэжилтнүүд, хамгаалалт, үйлчилгээний албаны ажилтнууд дагалдан явна.

41.1.2. Ерөнхийлөгч, түүний гэргий /нөхөр/ нар гадаад улсад төрийн болон албан ёсны айлчлал хийхээр явахад дагалдах төлөөлөгчдийг айлчлалын агуулга, онцлог, ажлын шаардлага зэргийг харгалзан томилох бөгөөд 24 хүртэл төлөөлөгч дагалдан явна. Үүнд:

- Гадаад хэргийн сайд;
- Тухайн улсад суугаа Элчин сайд;-Засгийн газрын гишүүн, сайд 2 хүн;
- Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх;
- Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал;

- Ёслолын газрын захирал;
- Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч;
- Ерөнхийлөгчийн шадар туслах;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын мэргэжилтэн 2 хүн;
- Гадаад хэргийн яамны мэргэжилтэн 2 хүн;
- Бэлэг хариуцсан ажилтан 1 хүн;
- Төрийн бусад байгууллагын мэргэжилтэн 3 хүн;
- Албан ёсны хэлмэрч 1 хүн;
- Албан ёсны гэрэл зурагчин 1 хүн;
- Албан ёсны зураглаач 1 хүн;
- Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан 3 хүн;
- Эмч 1 хүн;
- Үйлчилгээний ажилтан 1 хүн.

41.1.3. Айлчлах улсын тоо, тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамааран дагалдан явах төлөөлөгчийн бүрэлдэхүүн өөр байж болно.

41.1.4. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад төрийн болон албан ёсны айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Гадаад хэргийн дэд сайд нар нисэх онгоцны буудалд үдэж, угтана.

41.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ажлын айлчлал

41.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад ажлын айлчлал хийхээр явахад албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсгийн мэргэжилтнүүд, хамгаалалт, үйлчилгээний ажилтан зэрэг нийт 19 хүртэл төлөөлөгч дагалдан явна. Үүнд:

- Засгийн газрын гишүүн, сайд;
- Тухайн улсад суугаа Элчин сайд;
- Гадаад хэргийн дэд сайд;
- Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх;
- Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал;
- Ёслолын газрын захирал;
- Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч;
- Ерөнхийлөгчийн шадар туслах;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын мэргэжилтэн 1 хүн;
- Гадаад хэргийн яамны мэргэжилтэн 1 хүн;
- Төрийн бусад байгууллагын мэргэжилтэн 1 хүн;
- Албан ёсны хэлмэрч 1 хүн;
- Албан ёсны гэрэл зурагчин 1 хүн;
- Албан ёсны зураглаач 1 хүн;
- Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан 3 хүн;
- Эмч 1 хүн;
- Үйлчилгээний ажилтан 1 хүн.

41.2.2. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад ажлын айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар нисэх онгоцны буудалд үдэж, угтана.

41.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувийн айлчлал

41.3.1. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад хувийн айлчлал хийхээр явахад албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсгийн мэргэжилтнүүд дагалдан явахгүй.

41.3.2. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад хувийн айлчлал хийхээр явахад зөвлөх, шадар туслах, хамгаалалт, эмч, үйлчилгээний ажилтан зэрэг нийт 8 хүртэл ажилтан дагалдан явж болно.

41.3.3. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад хувийн айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар нисэх онгоцны буудалд үдэж, угтана.

42. Монгол Улсын Их Хурлын даргын айлчлал

42.1. Монгол Улсын Их Хурлын даргын албан ёсны айлчлал

42.1.1. Улсын Их Хурлын дарга гадаад улсад албан ёсны айлчлал хийхээр явахад түүний гэргий /нөхөр/, албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсгийн мэргэжилтнүүд, хамгаалалт, үйлчилгээний албаны ажилтнууд дагалдана.

42.1.2. Улсын Их Хурлын дарга, гэргий /нөхөр/ нар гадаад улсад албан ёсны айлчлал хийхээр явахад 18 хүртэл төлөөлөгч дагалдан явж болно. Үүнд:

- Улсын Их Хурлын гишүүн 4 хүн;
- Тухайн улсад суугаа Элчин сайд;
- Улсын Их Хурлын даргын зөвлөх;
- Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга;
- Гадаад хэргийн яамны холбогдох газрын дарга;
- Улсын Их Хурлын даргын хэвлэлийн төлөөлөгч;
- Улсын Их Хурлын Тамгын газрын мэргэжилтэн 1 хүн;
- Албан ёсны хэлмэрч 1 хүн;
- Албан ёсны гэрэл зурагчин 1 хүн;
- Албан ёсны зураглаач 1 хүн;
- Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан 3 хүн;
- Эмч 1 хүн;
- Үйлчилгээний ажилтан 1 хүн.

42.1.3. Айлчлах улсын тоо, тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамааран дагалдан явах төлөөлөгчийн бүрэлдэхүүн өөр байж болно.

42.1.4. Улсын Их Хурлын дарга гадаад улсад албан ёсны айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Гадаад хэргийн дэд сайд нар нисэх онгоцны буудалд үдэж, угтана.

42.2. Монгол Улсын Их Хурлын даргын ажлын айлчлал

42.2.1. Улсын Их Хурлын дарга гадаад улсад ажлын айлчлал хийхээр явахад албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсгийн мэргэжилтнүүд, хамгаалалт-үйлчилгээний ажилтнууд зэрэг нийт 16 хүртэл төлөөлөгч дагалдан явж болно. Үүнд:

- Улсын Их Хурлын гишүүн 2 хүн;
- Тухайн улсад суугаа Элчин сайд;
- Улсын Их Хурлын даргын зөвлөх;
- Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга;
- Улсын Их Хурлын даргын хэвлэлийн төлөөлөгч;
- Улсын Их Хурлын Тамгын газрын мэргэжилтэн 1 хүн;
- Гадаад хэргийн яамны мэргэжилтэн 1 хүн;
- Албан ёсны хэлмэрч 1 хүн;
- Албан ёсны гэрэл зурагчин 1 хүн;
- Албан ёсны зураглаач 1 хүн;
- Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан 3 хүн;
- Эмч 1 хүн;
- Үйлчилгээний ажилтан 1 хүн.

42.2.2. Улсын Их Хурлын дарга гадаад улсад ажлын айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар нисэх онгоцны буудалд үдэж, угтана.

42.3. Монгол Улсын Их Хурлын даргын хувийн айлчлал

42.3.1. Улсын Их Хурлын дарга гадаад улсад хувийн айлчлал хийхээр явахад албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсгийн мэргэжилтнүүд дагалдан явахгүй.

42.3.2. Улсын Их Хурлын дарга гадаад улсад хувийн айлчлал хийхээр явахад зөвлөх, шадар туслах, хамгаалалт, эмч, үйлчилгээний ажилтан зэрэг нийт 8 хүртэл хүн дагалдан явж болно.

42.3.3. Улсын Их Хурлын дарга гадаад улсад хувийн айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар нисэх онгоцны буудалд үдэж, угтана.

43. Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлал

43.1. Монгол Улсын Ерөнхий сайдын албан ёсны айлчлал

43.1.1. Ерөнхий сайд гадаад улсад албан ёсны айлчлал хийхээр явахад түүний гэргий /нөхөр/, албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсгийн мэргэжилтнүүд, хамгаалалт-үйлчилгээний албаны ажилтнууд дагалдана.

43.1.2. Ерөнхий сайд, түүний гэргий /нөхөр/ нар гадаад улсад албан ёсны айлчлал хийхээр явахад дагалдах төлөөлөгчдийг айлчлалын агуулга, онцлог, ажлын шаардлага зэргийг харгалзан томилох бөгөөд 24 хүртэл төлөөлөгч дагалдан явж болно. Үүнд:

- Тухайн улсад суугаа Элчин сайд;
- Засгийн газрын гишүүн сайд 3 хүн;
- Гадаад хэргийн яамны дэд сайд/Төрийн нарийн бичгийн дарга;
- Ерөнхий сайдын зөвлөх;

- Гадаад хэргийн яамны холбогдох газрын дарга;
- Ерөнхий сайдын хэвлэл, мэдээллийн төлөөлөгч;
- Ёслолын газрын захирал/дэд захирал;
- Ерөнхий сайдын ажлын албаны мэргэжилтэн 2 хүн;
- Гадаад хэргийн яамны мэргэжилтэн 2 хүн;
- Бэлэг хариуцсан ажилтан 1 хүн;
- Төрийн бусад байгууллагын мэргэжилтэн 3 хүн;
- Албан ёсны хэлмэрч 1 хүн;
- Албан ёсны гэрэл зурагчин 1 хүн;
- Албан ёсны зураглаач 1 хүн;
- Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан 3 хүн;
- Эмч 1 хүн;
- Үйлчилгээний ажилтан 1 хүн.

43.1.3. Айлчлах улсын тоо, тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамааран дагалдан явах төлөөлөгчийн бүрэлдэхүүн өөр байж болно.

43.1.4. Ерөнхий сайд гадаад улсад албан ёсны айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар нисэх онгоцны буудалд үдэж, угтана.

43.2. Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын айлчлал

43.2.1. Ерөнхий сайд гадаад улсад ажлын айлчлал хийхээр явахад албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсгийн мэргэжилтнүүд, хамгаалалт, үйлчилгээний ажилтан зэрэг нийт 18 хүртэл төлөөлөгч дагалдан явж болно. Үүнд:

- Тухайн улсад суугаа Элчин сайд;
- Засгийн газрын гишүүн сайд 1 хүн;
- Гадаад хэргийн яамны дэд сайд/Төрийн нарийн бичгийн дарга;
- Ерөнхий сайдын зөвлөх;
- Гадаад хэргийн яамны холбогдох газрын дарга;
- Ерөнхий сайдын хэвлэл, мэдээллийн төлөөлөгч;
- Ёслолын газрын захирал/дэд захирал;
- Ерөнхий сайдын ажлын албаны мэргэжилтэн 1 хүн;
- Гадаад хэргийн яамны мэргэжилтэн 1 хүн;
- Төрийн бусад байгууллагын мэргэжилтэн 1 хүн;
- Албан ёсны хэлмэрч 1 хүн;
- Албан ёсны гэрэл зурагчин 1 хүн;
- Албан ёсны зураглаач 1 хүн;
- Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан 3 хүн;
- Эмч 1 хүн;
- Үйлчилгээний ажилтан 1 хүн.

43.2.2. Ерөнхий сайд гадаад улсад ажлын айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар нисэх онгоцны буудалд үдэж, угтана.

43.3. Монгол Улсын Ерөнхий сайдын хувийн айлчлал

43.3.1. Ерөнхий сайд гадаад улсад хувийн айлчлал хийхээр явахад албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсгийн мэргэжилтнүүд дагалдан явахгүй.

43.3.2. Ерөнхий сайд гадаад улсад хувийн айлчлал хийхээр явахад зөвлөх, шадар туслах, хамгаалалт, эмч, үйлчилгээний ажилтан зэрэг нийт 8 хүртэл хүн дагалдан явж болно.

43.3.3. Ерөнхий сайд гадаад улсад хувийн айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар нисэх онгоцны буудалд үдэж, угтана.

44. Монгол Улсын Гадаад хэргийн сайдын айлчлал

44.1. Гадаад хэргийн сайд гадаад улсад албан ёсны болон ажлын айлчлал хийхээр явахад 4 хүртэл хүн дагалдан явж болно. Албан ёсны айлчлал хийхээр явахдаа Гадаад хэргийн сайд гэргий /нөхөр/-н хамт явж болно.

44.2. Гадаад хэргийн сайд гадаад улсад албан ёсны болон ажлын айлчлал хийхээр явахад Ёслолын газрын захирал үдэж, угтана.

44.3. Гадаад хэргийн сайд гадаад улсад албан ёсны болон ажлын айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд тухайн улс, олон улсын байгууллагаас Монгол Улсад суугаа Элчин сайд, Суурин төлөөлөгч, тэдгээрийн эзгүйд Түр хамаарагч, орлогчийг үдэх, утгах ёслолд урьж оролцуулна.

45. Гадаад улсын төрийн дээд, өндөр албан тушаалтны айлчлал

45.1. Гадаад улсын төрийн дээд, өндөр албан тушаалтны Монгол Улсад хийх айлчлал нь төрийн айлчлал, албан ёсны айлчлал, ажлын айлчлал, хувийн айлчлал гэсэн ангилалтай байна.

45.2. Гадаад улсын төрийн дээд, өндөр албан тушаалтан Монгол Улсад анх удаа айлчлах, харилцаа, хамтын ажиллагааны онцгой чухал асуудал хэлэлцэх, баримт бичиг байгуулах зэрэг зорилгоор айлчилбал төрийн болон албан ёсны айлчлалд хамааруулна.

45.3. Монгол Улсад хийх төрийн айлчлалыг гадаад улсын төрийн тэргүүн хийнэ. Монгол Улстай түншлэлийн харилцаатай, хаант болон парламентын засаглалтай, хүчтэй гүйцэтгэх засаглалтай зарим орны Засгийн газрын тэргүүнийг төрийн айлчлалаар хүлээн авч болно. Энэ тохиолдолд ёслол, хүндэтгэл нь төрийн тэргүүний төрийн айлчлалын ёслол хүндэтгэлтэй адил байна.

45.4. Хоёр орны хамтын ажиллагааны болон олон улс, бүс нутгийн харилцааны асуудал хэлэлцэх, зөвлөлдөх, санал солилцох, хоёр талын болон олон талын баримт бичиг байгуулах, олон улсын хурал, соёл, урлаг, спортын арга хэмжээ, түүхт ой, тэмдэглэлт үйл явдалд урилгаар оролцох, эмгэнэл илэрхийлэх зорилгоор айлчилбал ажлын айлчлалд хамааруулна.

45.5. Гадаад улсын төрийн дээд, өндөр албан тушаалтан, гадаад хэргийн сайд нар оролцсон олон улсын хурал Монгол Улсад зохион байгуулагдвал, тэдний

айлчлалыг ажлын айлчлалд хамааруулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл ёслол, хүндэтгэлийг нь тусгай журмаар зохицуулна.

45.6. Эмчлүүлэх, соёл, урлаг, спортын арга хэмжээ үзэж сонирхох, жуулчлах зэрэг ажил төрлийн бус зорилгоор зорчвол хувийн айлчлалд хамааруулна.

45.7. Төрийн болон албан ёсны айлчлалыг ажлын 3 хоногт, ажлын айлчлалыг ажлын 2 хоногт багтаан хэрэгжүүлэх зарчим баримтлана.

45.8. Гадаад улсын төрийн дээд, өндөр албан тушаалтны айлчлалыг Гадаад хэргийн яам удирдан зохицуулна.

45.9. Гадаад улсын төрийн дээд, өндөр албан тушаалтны Монгол Улсад хийх аливаа айлчлалын ёслол хүндэтгэл, зохион байгуулалтыг Гадаад хэргийн яам удирдан зохицуулж, Ёслолын газар холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

45.10 Гадаад улсын төрийн дээд, өндөр албан тушаалтан Монгол Улсад айлчлан ирэх, буцахад түүнд, түүний гэргий /нөхөр/, дагалдан яваа төлөөлөгчдөд хилийн болон гаалийн хүндэтгэл үзүүлнэ.

45.11. Монгол Улсад хэрэгжих аливаа дээд, өндөр, түвшний айлчлалын ёслол хүндэтгэл, зохион байгуулалтын асуудлаар Ёслолын газар, Төрийн ёслолын алба нягт хамтран ажиллана.

Айлчлалын хөтөлбөр

45.12. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд нар Монгол Улсад хийх айлчлалын хөтөлбөрийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар айлчлал эхлэхээс 7 хоногийн өмнө тус тус батална.

45.13. Айлчлалын хөтөлбөрийг монгол хэл дээр хэвлүүлнэ.

45.14. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайдын гэргий /нөхөр/-д айлчлалын хугацаанд тусгай хөтөлбөр гаргаж үйлчилнэ. Гэргий /нөхөр/-н хөтөлбөрт Монгол Улсын түүх, дурсгалын газартай танилцах, соёл, хүмүүнлэг, боловсролын чиглэлээр зохиох арга хэмжээнд оролцох, үйлдвэр, аж ахуйн газартай танилцах зэрэг арга хэмжээг тусгаж болно.

45.15. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд нар Монгол Улсад хийх айлчлалын хөтөлбөрийн төслийг ажлын 10 хоногийн өмнө Төрийн тусгай хамгаалалтын газарт хүргүүлнэ.

Айлчлалын зардал

45.16. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд нар Монгол Улсад хийх айлчлалын зардлыг Монгол

Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад хэргийн яам тус тусын чиглэлээр хариуцаж, айлчлал хэрэгжихээс ажлын 10 хоногийн өмнө эдгээр байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална. Шаардлагатай тохиолдолд зардлын асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийвэрлүүлнэ.

45.17. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад төрийн айлчлал хийхэд түүний болон гэргий /нөхөр/-н 3 хоногийн зардлыг монголын тал хариуцна. Гадаад улсын төрийн тэргүүнийг дагалдан яваа зөвхөн албан ёсны 12 хүртэлх төлөөлөгчийн зардлыг монголын тал хариуцах бөгөөд харилцан адил байх зарчмыг баримтална.

45.18. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд нар Монгол Улсад албан ёсны айлчлал хийхэд 2-3 хоногийн зардлыг монголын тал хариуцаж, дагалдан яваа зөвхөн албан ёсны 10 хүртэлх төлөөлөгчийн зардлыг монголын тал мөн гаргах бөгөөд харилцан адил байх зарчмыг баримтална.

45.19. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд нар Монгол Улсад ажлын айлчлал хийхэд 2 хоногийн зардлыг монголын тал хариуцаж, дагалдан яваа зөвхөн албан ёсны 5 хүртэлх төлөөлөгчийн зардлыг монголын тал мөн гаргах бөгөөд харилцан адил байх зарчмыг баримтална.

45.20. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд нар Монгол Улсад хувийн айлчлалаар зочлоход монголын тал аливаа зардлыг хариуцахгүй.

45.21. Албан ёсны төлөөлөгчидтэй холбоотой монголын талаас хариуцах айлчлалын зардалд зочид буудал, хот дотор болон хөдөө орон нутагт явах унаа болон өглөөний цай, өдөр, оройн зоог, ундаа, хот доторх харилцаа холбоо зэрэг үйлчилгээний зардлууд орно. Гадаад улсын төрийн тэргүүний айлчлалын зардлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, гадаад улсын Парламентын даргын айлчлалын зардлыг Улсын Их Хурлын Тамгын газар, гадаад улсын Засгийн газрын тэргүүний айлчлалын зардлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад улсын гадаад хэргийн сайдын айлчлалын зардлыг Гадаад хэргийн яам тус тус хариуцан гаргана.

Бэлэг дурсгалын зүйл

45.22. Монгол Улсад айлчилж буй гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд болон түүний гэргий /нөхөр/-д болон албан ёсны төлөөлөгчдөд зөвхөн урьсан албан тушаалтан монгол үндэсний агуулга бүхий дурсгалын зүйл бэлэглэнэ.

45.23. Бэлэг дурсгалын зүйлийг ёслолын албадаар дамжуулан солилцох бөгөөд хоёр тал урьдчилан тохиролцсон тохиолдолд төр, засгийн удирдагчид түүнийг өөрсдөө шууд солилцож болно. Бэлэг солилцох ёслолыг хүндэтгэлийн зоогийн төгсгөлд хийнэ.

45.24. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд Монгол Улсад хийсэн төрийн болон албан ёсны айлчлалын гэрэл зургуудаар цомог бэлтгэн гардуулж болно.

Байрлах байр

45.25. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд Монгол Улсад айлчлал хийхдээ байрлах байрыг нөгөө талтай хэлэлцэн урьдчилан тохирно.

45.26. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд байрлах байранд Монгол Улсын болон тухайн улсын төрийн далбааг мандуулна. Тухайн улсын төрийн далбааг Монгол Улсын төрийн далбааны баруун гар талд мандуулна.

Хөлөглөх машин

45.27. Монгол Улсад айлчлах гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд, тэдгээрийн гэргийд тусгай зориулалтын машинаар үйлчилнэ. Зочны тал өөрийн машинаа авчирч ашиглаж болно. Тусгай зориулалтын машиныг Төрийн тусгай хамгаалалтын газар хариуцан гаргах бөгөөд шалгаж бэлэн байдлыг хангана.

45.28. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайдын хөлөглөх машинд Монгол Улсын болон тухайн улсын төрийн далбааг мандуулна. Тухайн улсын төрийн далбааг Монгол Улсын төрийн далбааны баруун гар талд мандуулна.

45.29. Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд, түүний гэргий /нөхөр/-н хөлөглөх машинуудад Цагдаагийн байгууллага хөтөч машин гаргаж үйлчилнэ. Төлөөлөгчдийн машины цуваанд айлчлалын нийт хугацаанд Цагдаагийн байгууллага хөтөч машин мөн гаргаж үйлчилнэ.

Аюулгүй байдал, хамгаалалт

45.30.1. Монгол Улсад айлчлал хийж буй Гадаад улсын төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд, тэдгээрийн гэргий /нөхөр/-н хамгаалалт, бүх талын аюулгүй байдлыг хангах асуудлыг Төрийн тусгай хамгаалалтын газар, Цагдаагийн байгууллага бусад хүчний байгууллагатай хамтран зохион байгуулж хэрэгжүүлнэ. Айлчлалын ерөнхий аюулгүй байдлыг Төрийн тусгай хамгаалалтын газар хариуцан хэрэгжүүлнэ.

45.30.2. Айлчлалын хугацаанд Цагдаагийн байгууллага, хөтөч, цоожлогч автомашин гаргаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган зорчих чиглэлийн дагуу болох байрлах, зочлох объектуудыг хамгаалалтад авна.

45.30.3 Төрийн тусгай хамгаалалтын 3 дугаар зэрэглэлээр хамгаалалт авагдсан тохиолдолд хүндэт зочны байрлах зочид буудал, зочлох газарт цагдаагийн байгууллагаас хэв журам сахиулах эргүүл ажиллуулж, аюулгүй байдлыг хангана.

Нислэгийн зөвшөөрөл

45.31. Монгол Улсад айлчлалаар ирж буй гадаад улсын төр, Парламент, Засгийн газрын тэргүүний хөлөглөх нисэх онгоцны онцгой үүргийн нислэгийн буулт, хөөрөлт, нислэгийн зөвшөөрлийг монголын холбогдох байгууллагуудаас авч өгөх асуудлыг Ёслолын газар хариуцна.

45.32. Онцгой болон тусгай үүргийн нислэг үйлдэх нисэх онгоцны багийн гишүүд, зорчигчдын нэрсийн жагсаалт, нислэгийн зам маршрут, цагийн хуваарь, нисэх онгоц агаарт мөргөлдөхөөс сэргийлэх ACAS/TCAS тоноглол байгаа эсэх зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг зөвшөөрөл хүсэгч улс өөрийн Элчин сайдын яамаар дамжуулан 72 цагийн өмнө ноот бичгээр Ёслолын газар ирүүлнэ.

45.33. Монгол Улсад айлчлалаар ирж буй гадаад улсын төр, Парламент, Засгийн газрын тэргүүний хөлөглөх нисэх онгоцны онцгой үүргийн үндсэн нислэгийн буулт, хөөрөлт, нислэгийн хураамжийг монголын тал хариуцах бөгөөд шаардагдах хураамжийг айлчлалын төсөвт тусгана.

46. Гадаад улсын төрийн тэргүүний айлчлал

46.1. Гадаад улсын төрийн тэргүүний төрийн болон албан ёсны айлчлал

46.1.1 Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгын дагуу тус улсад төрийн болон албан ёсны айлчлал хийнэ.

46.1.2. Гадаад улсын төрийн тэргүүний төрийн болон албан ёсны айлчлал нь дараах үндсэн арга хэмжээг багтааж болно. Үүнд:

- Нисэх онгоцны буудалд угтах, үдэх ёслол;
- Чингисийн талбайд албан ёсоор угтах ёслол;
- Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслол;
- Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслол;
- Ганцаарчилсан уулзалт;
- Өргөтгөсөн хэлэлцээ эсхүл уулзалт;
- Албан ёсны хэлэлцээ;
- Бараалхах уулзалт;
- Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд үг хэлэх;

- Баримт бичигт гарын үсэг зурах ёслол;
- Хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд хийх мэдээлэл;
- Хүндэтгэлийн зоог;
- Одон, медалиар харилцан шагнах ёслол;
- Орон нутагт зочлох зэрэг.

46.1.3. Гадаад улсын төрийн тэргүүний төрийн болон албан ёсны айлчлал Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос эхэлнэ.

46.1.4. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад хийх төрийн айлчлалыг ажлын 3 хоногт, албан ёсны айлчлалыг ажлын 2 хоногт багтаан хэрэгжүүлнэ.

46.1.5. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад төрийн болон албан ёсны айлчлал хийхэд Монголын талаас Засгийн газрын гишүүн сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд байнга дагалдан явна. Гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/-г Элчин сайдын гэргий /нөхөр/ байнга дагалдан явна.

46.1.6. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад төрийн болон албан ёсны айлчлал хийхэд дараах газруудад Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбааг мандуулж, байрлуулна. Үүнд:

- Чингисийн талбай;
- Сүхбаатарын гудамж;
- Энхтайваны гүүр;
- Нисэх буудал;

- Байрлах өргөө, зочид буудал;
- Хөлөглөх машин;

- Төрийн ордны ёслол, хүндэтгэлийн Их танхим;
- Төрийн ордны “Баганат” танхим;
- Албан ёсны хэлэлцээний танхим;
- Бараалхах уулзалт хийх танхим;
- Хүндэтгэлийн зоог барих танхим;
- Албан ёсны хэлэлцээний ширээ;
- Баримт бичигт гарын үсэг зурах ширээ.

46.1.7. Монгол Улсын болон гадаад улсын Төрийн далбааг үйлдэхдээ стандартыг чанд баримтална.

46.1.8. Тухайн улсын Төрийн далбааг Монгол Улсын Төрийн далбааны баруун гар талд мандуулна.

46.1.9. Чингисийн талбай, Сүхбаатарын гудамж, Энхтайваны гүүрэнд мандуулах Төрийн далбааг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, бусад газарт мандуулж байрлуулах Төрийн далбааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар тус тус хариуцан бэлтгэнэ.

46.1.10. Нисэх буудалд угтах ёслол

а/ Гадаад улсын төрийн тэргүүн онцгой үүргийн болон хуваарьт нислэгээр ирж байгаа бол угтах ёслолыг нислэгийн талбайд хийнэ. Шаардлагатай тохиолдолд олон улсын нисэх буудлын байранд хийж болно.

б/ Онгоцны шат, онгоцноос машин хүртэлх зам дагуу улаан хивс дэвсэнэ.

в/ Хүндэт харуулын нэг салаа 25 цэрэг улаан хивсний хоёр талаар жагссан байна.

г/ Гадаад улсын төрийн тэргүүн төрийн болон албан ёсны айлчлал хийхээр ирэхэд Монгол Улсын Гадаад хэргийн сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд нар нисэх буудалд угтана. Гадаад улсын төрийн тэргүүн гэргий /нөхөр/-

н хамт айлчилбал Гадаад хэргийн сайдын гэргий /нөхөр/, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд гэргий /нөхөр/-н хамт угтана. Гадаад хэргийн сайд эзгүй тохиолдолд гадаад улсын төрийн тэргүүнийг айлчлалын хугацаанд дагалдах Засгийн газрын гишүүн-сайд угтана.

д/ Гадаад улсын төрийн тэргүүн төрийн болон албан ёсны айлчлал хийхээр ирэхэд нисэх буудалд угтах ёслолд тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдыг урьж оролцуулна. Гадаад улсын төрийн тэргүүн гэргий /нөхөр/-н хамт айлчилбал Элчин сайдын гэргий /нөхөр/-г угтах ёслолд урьж оролцуулна.

е/ Онгоц зогсоолд ирж зогсон хаалгаа нээхэд Ёслолын газрын захирал, тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд нар нисэх онгоцонд орж төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/-г Монгол Улсад тавтай зочлохыг ерөөж, нисэх онгоцноос урьж буулгана.

ё/ Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нисэх онгоцноос бууж ирэхэд монгол үндэсний хувцастай бүсгүй, залуу мөнгөн аягатай ааруул, хадаг барьж угтан мэндчилнэ.

ж/ Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ монголын талаас албан ёсоор угтаж буй Гадаад хэргийн сайд, түүний гэргий /нөхөр/-тэй мэндчилнэ.

з/ Гадаад улсын төрийн тэргүүн, Монгол Улсын Гадаад хэргийн сайд нар хүндэт харуулын цэргүүдийн дундуур улаан хивсэн дээгүүр явж, монголын талаас албан ёсоор угтаж буй бусад төлөөлөгчид рүү очно.

и/ Монголын талын албаны хүмүүсийг Ёслолын газрын захирал төрийн тэргүүнд танилцуулна. Тухайн улсын Элчин сайд өөрийн талын албаны хүмүүсийг танилцуулна.

й/ Гадаад улсын төрийн тэргүүн, Монгол Улсын Гадаад хэргийн сайд нар хамт нэг машинд сууж явна. Гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/, Монгол Улсын Гадаад хэргийн сайдын гэргий /нөхөр/ нар хамт нэг машинд сууж явна.

к/ Гадаад улсын төрийн тэргүүн байрлах өргөө, зочид буудалд хүрэлцэн ирэхэд өргөөний болон зочид буудлын удирдлага улаан хивс дэвсэж, цэцгийн баглаа барьж угтана. Монгол Улсын Гадаад хэргийн сайд гадаад улсын төрийн тэргүүнийг байрлах өргөөнд хүргэж өгөөд буцна. Ёслолын газрын захирал хүндэт зочныг өрөөнд нь оруулж өгнө.

л/ Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ байрлах өргөөнд Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний гэргий /нөхөр/ нараас дурсгасан цэцгийн баглаа тавьсан байна.

46.1.11. Чингисийн талбайд албан ёсоор угтах ёслол

-Гадаад улсын төрийн тэргүүн төрийн болон албан ёсны айлчлал хийхээр Монгол Улсад ирэхэд албан ёсоор угтах ёслолыг Чингисийн талбайд үйлдэнэ.

-Гадаад улсын төрийн тэргүүний хөлөглөсөн машин зогсох, Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нар анх уулзаж, мэндчилэх зэрэг газарт

тус тус хивс дэвсэнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нар Хүндэт харуулын даргын илтгэлийг хүлээн авч, хоёр орны Төрийн дуулалыг хүндэтгэн сонсох газарт 3м х 2м хэмжээтэй хүндэтгэлийн тавцан байрлуулсан байна. Төрийн тэргүүн нарын гэргий /нөхөр/ нарт зориулан хүндэтгэлийн тавцангийн баруун талд хивс дэвсэнэ. Гадаад улсын төрийн тэргүүний хөлөглөсөн машин зогсох газраас эхлэн Төрийн ордонд орох хүртэлх угтах ёслол үйлдэх бүх замын дагуу улаан хивс дэвсэнэ.

-Чингисийн талбайн төвд Монгол Улсын болон гадаад улсын төрийн далбааг мандуулсан байна. Гадаад улсын Төрийн далбааг Монгол Улсын Төрийн далбааны баруун талд мандуулна.

-Хүндэт харуулын 25 цэрэг бүхий гурван салаа нийт 80 цэрэг Чингисийн талбайн төв хэсэгт Төрийн ордон руу харан хоёр эгнээгээр жагссан байна. Хүндэт харуулын жагсаалын тэргүүнд Төрийн ёслолын цэргийн цагаан тугийг залсан байна.

-Төрийн ордны өмнө Хүндэт харуулын 30 морьт цэрэг өмнө зүг харан жагссан байна.

-Үлээвэр найрал хөгжим Хүндэт харуулын баруун гар талд Төрийн ордон руу харан жагссан байна.

-Гадаад улсын төрийн тэргүүний хийж буй төрийн айлчлалын угтах ёслолд монголын талаас дараах албан тушаалтан оролцоно. Үүнд:

- Гадаад хэргийн сайд;
- Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд;-Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь парламентын бүлгийн дарга;
- Албан ёсны хэлэлцээнд оролцох Засгийн газрын гишүүд, сайд нар;

- Улаанбаатар хотын захирагч бөгөөд Нийслэлийн Засаг дарга;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх;
- Ерөнхийлөгчийн хэвлэл, мэдээллийн төлөөлөгч;
- Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал зэрэг болно

-Гадаад улсын төрийн тэргүүн гэргий /нөхөр/-н хамт айлчилж байгаа бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэргий /нөхөр/, гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/ нар албан ёсоор угтах ёслолд оролцоно.

-Гадаад улсын төрийн тэргүүний хийж буй төрийн айлчлалын угтах ёслолд Улаанбаатар дахь Дипломат корпусыг урьж оролцуулна.

-Албан ёсоор угтах ёслолд монголын талаас оролцох албан тушаалтнууд Чингисийн талбайд ёслол эхлэхээс 10 минутын өмнө ирсэн байх бөгөөд Хүндэт харуулын зүүн гар талд Соёлын төв өргөө рүү харан баруун гар талаасаа ёслолын ахлалаар нэг эгнээгээр зогсоно.

-Гадаад орны төрийн тэргүүнийг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчид албан ёсоор угтах ёслол эхлэхээс 10 минутын өмнө Чингисийн талбайд урьдчилан

ирсэн байх бөгөөд монголын талын албаны хүмүүсийн дараа баруун гар талаасаа ёслолын ахлалаар Соёлын төв өргөө рүү харан нэг эгнээгээр зогсоно.

-Гадаад орны төрийн тэргүүнийг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчдийн дараа тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дипломат ажилтнууд баруун гар талаасаа ёслолын ахлалаар Соёлын төв өргөө рүү харан нэг эгнээгээр зогсоно.

-Албан ёсоор угтах ёслолд уригдсан Монгол Улсад суугаа Дипломат корпусын төлөөлөгчид Чингисийн талбайд ёслол эхлэхээс 10 минутын өмнө ирсэн байх бөгөөд Хүндэт харуулын зүүн гар талд Соёлын төв өргөө рүү харан баруун гар талаасаа ёслолын ахлалаар нэг эгнээгээр зогсоно.

-Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний гэргий /нөхөр/ албан ёсоор угтах ёслол эхлэхээс 5 минутын өмнө Чингисийн талбайд ирнэ. Төрийн ёслолын албаны дарга тэднийг угтан мэндчилж, тусгайлан зассан хүндэтгэлийн тавцан руу залж ирүүлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч хүндэтгэлийн тавцан дээр хойд талаас нь гарч зогсоход Хүндэт харуулын дарга жагсаалын алхаагаар угтан очиж “Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Танаа, Төрийн хүндэт харуул ёслолын ажиллагаанд бэлэн болсныг айлтгая. Хүндэт харуулын дарга” гэж цэргийн цол, овог нэрээ хэлж айлтгал өргөнө. Ерөнхийлөгч толгой дохин айлтгалыг хүлээн аваад, хүндэтгэлийн тавцангаас буцаж хойд тал руу нь бууж, улаан хивсэн дээгүүр явж гадаад улсын төрийн тэргүүнийг угтах хивсэн дээр очиж зогсоно. Монгол Улсын Ерөнхийлөгч Хүндэт харуултай мэндэлсэн тохиолдолд “Хүндэт Ерөнхийлөгчийн амрыг эрье” хэмээн мэндэлнэ. Ерөнхийлөгчийн гэргий энэ үед хүндэтгэлийн тавцангийн баруун талд зассан хивсэн дээр зогсож байна. Айлтгал дууссаны дараа Ерөнхийлөгчийг гэргийн хамт гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/-г угтах хивснээс хэдэн алхмын наана улаан хивсэн дээр очиж зогсоно.

- Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нар нэг машинд хамт суух бөгөөд төрийн тэргүүн машины баруун хойд талын суудалд, түүний гэргий /нөхөр/ машины зүүн хойд талын суудалд тус тус сууна.

-Гадаад улсын төрийн тэргүүний хөлөглөсөн машин Чингисийн талбайд ирэхэд Үлээвэр найрал хөгжим “Угтах ая” эгшиглүүлж байна.

-Гадаад улсын төрийн тэргүүний хөлөглөсөн машин товлосон газарт зогсоход Төрийн ордны хамгаалалтын албаны хоёр ажилтан машины хоёр талын хойд хаалгыг зэрэг нээн өгч ёсолно.

-Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нар машинаас бууж Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний гэргийн зүг алхахад Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний гэргий нар угтан алхаж, хивсний төвд уулзан гар барьж мэндчилнэ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэргий Ерөнхийлөгчийн баруун гар талд явна. Гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/ төрийн тэргүүний баруун гар талд явна. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнтэй мэндчилээд дараа нь түүний гэргий /нөхөр/-тэй мэндчилнэ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэргий гадаад улсын төрийн тэргүүнтэй мэндчилээд дараа нь түүний гэргий /нөхөр/-тэй мэндчилнэ.

-Харилцан мэндчилсний дараа монгол үндэсний хувцастай эрэгтэй, эмэгтэй хоёр монгол хүүхэд гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/-д цэцгийн баглаа өргөн барина.

-Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад орны тэргүүн нар гэргий /нөхөр/ нар хүүхдүүдийн хамт дурсгалын гэрэл зураг авахуулна. Баруун гар талаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэргий, гадаад улсын төрийн тэргүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/ гэсэн дарааллаар эгнэн зогсоно. Хүүхдүүд эхний эгнээнд зогсоно.

-Дурсгалын гэрэл зураг авахуулсны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг баруун гар талдаа авч улаан хивсэн дээгүүр тавцангийн зүг явна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэргий гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/-г баруун гар талдаа аван Ерөнхийлөгч, төрийн тэргүүн нарын араас хоёр алхмын зайд араас нь даган явна.

-Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нар хүндэтгэлийн тавцангийн хойд талаас гарч Хүндэт харуулын зүг харан зогсоно. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг баруун гар талдаа авч зогсоно.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэргий /нөхөр/ гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/-г баруун гар талдаа авч дагуулан явж, хүндэтгэлийн тавцангийн баруун талд зассан хивсэн дээр зогсоно. Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэргий /нөхөр/ гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/-г зүүн гар талдаа авч зогсоно.

-Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нар хүндэтгэлийн тавцан дээр хойд талаас нь гарч зогсоход Хүндэт харуулын дарга жагсаалын алхаагаар угтан очиж, “Монгол Улсад төрийн /албан ёсны/ айлчлал хийж байгаа/улсын нэр/ .. улсын/албан ёсны дуудлага/ Таныг хүндэтгэн Монгол Улсын Төрийн хүндэт харуул жагссан. Хүндэт харуулын дарга .../цэргийн цол, нэр овог/” гэж айлтгал өргөөд баруун гар тийш эргэж Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нарын зүг хараа гарган зогсоход Үлгэр жишээ Үлээвэр найрал хөгжим эхлээд тухайн улсын Төрийн дуулал дараа нь Монгол Улсын төрийн дууллыг тус тус эгшиглүүлнэ.

-Төрийн дуоллууд эгшиглэж дуусахад Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүн нар хүндэтгэлийн тавцангаас урагш бууж, Хүндэт харуулын жагсаалын тэргүүнд залсан Төрийн ёслолын цэргийн цагаан тугны зүг улаан хивсэн дээгүүр явна. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг баруун гар талдаа авч явна. Хүндэт харуулын дарга гурван алхамын зайд жагсаалын алхаагаар дагалдан явна. Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад орны төрийн тэргүүн нар Төрийн ёслолын цэргийн цагаан тугны өмнө очиж түүнд толгой мэхийн хүндэтгэл илэрхийлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг баруун гар талдаа авч зогсоно.

-Төрийн ёслолын цэргийн цагаан туганд хүндэтгэл илэрхийлсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг зүүн гар талдаа авч яван Хүндэт харуулын жагсаалын өмнүүр алхана. Ерөнхийлөгч, төрийн тэргүүн нар Төрийн ёслолын хүндэт харуулын жагсаалыг голлон Хүндэт харуулын зүг харан зогсоно. Гадаад улсын төрийн тэргүүн Хүндэт харуулын цэргүүдтэй “Цэргүүд ээ,

сайн байцгаана уу” гэж төрөлх хэл дээрээ мэндэлнэ. Төрийн ёслолын хүндэт харуулын цэргүүд “Хүндэт Ерөнхийлөгч /эзэн хаан, хатан хаан/-ийн амрыг эрье” хэмээн хариу мэндэлнэ. Энэ үед Монгол Улсын Ерөнхийлөгч гадаадын төрийн тэргүүний баруун хойд талд нэг алхам зайтай зогсож байна.

-Хүндэт харуулын цэргүүд хариу мэндэлсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнийг зүүн гар талдаа авч Хүндэт харуулын жагсаалын төгсгөл хүртэл явна. Хүндэт харуулын дарга эргэж, жагсаалын алхаагаар жагсаалын дунд хүртэл буцаж алхана.

-Ерөнхийлөгч, төрийн тэргүүн нар албан ёсоор угтах ёслолд оролцож буй албаны хүмүүсийн зүг явна. Энэ үед Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэргий, гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/ тэдэнтэй нийлнэ.

-Гадаад улсын төрийн тэргүүн албан ёсоор угтах ёслолд оролцож байгаа монголын талын албаны хүмүүстэй гар барьж мэндэлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч монголын талын албаны хүмүүсийг танилцуулна.

-Монгол Улсын Ерөнхийлөгч албан ёсоор угтах ёслолд оролцож буй гадаад улсын төрийн тэргүүнийг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчидтэй гар барьж мэндэлнэ. Гадаад улсын төрийн тэргүүн албан ёсны төлөөлөгчдөө танилцуулна.

-Тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дипломат ажилтнуудтай Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн тэргүүн нар гар барьж мэндэлнэ. Тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд дипломат ажилтнуудаа танилцуулна.

-Гадаад улсын төрийн тэргүүн албан ёсоор угтах ёслолд оролцож байгаа Монгол Улсад суугаа Дипломат корпусын төлөөлөгчидтэй гар барьж мэндэлнэ. Ёслолын газрын захирал Элчин сайд, Хэргийг хамаарагч, Түр хамаарагч, Суурин төлөөлөгч нарыг танилцуулна. Үүгээр албан угтах ёслол өндөрлөнө.

46.1.13. Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслол

-Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслолыг Чингисийн талбайд хийсэн албан ёсоор угтах ёслолын дараа үйлдэнэ.

-Их эзэн Чингис хааны хөшөөний хоёр талд болон шатны дагуу Хүндэт харуулын 16 цэрэг жагссан байна.

-Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө том хивс, шатны дагуу улаан хивс дэвсэнэ.

-Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүнийг баруун гар талдаа авч шатаар өгсөнө. Түүний араас хоёр алхамын зайд Ерөнхийлөгчийн гэргий төрийн тэргүүний гэргийг баруун гар талдаа аван шатаар өгсөнө. Гадаад улсын төрийн тэргүүнийг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчид тав, таваараа нэг эгнээ болон шатаар өгсөнө.

-Ерөнхийлөгч, төрийн тэргүүн, гэргий /нөхөр/ нар, албаны ёсны төлөөлөгчид Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө дэвссэн хивсэн дээр очиж зогсоод, толгой бөхийн хүндэтгэл илэрхийлнэ.

-Хүндэтгэл илэрхийлсний дараа Ерөнхийлөгч, гэргий нар Төрийн ордон руу хөшөөний баруун талын хаалгаар орно. Дагалдан яваа албан ёсны төлөөлөгчид Төрийн ордон руу хөшөөний зүүн талын хаалгаар орно.

46.1.14. Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслол

-Албан ёсоор угтах ёслол өндөрлөж, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч, гэргий нар гадаад улсын төрийн тэргүүн, гэргий /нөхөр/ нарын хамт Төрийн ордны “Баганат” танхимд орж ирнэ.

-“Баганат” танхимд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа мандуулсан байна.

-Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нар Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах танхимд ёслолын ширээ, сандлыг бэлтгэж, Хүндэт зочны дэвтэр, үзэг бэлтгэсэн байна. Ширээг амьд цэцгээр чимэглэсэн байна.

-Гадаад улсын төрийн тэргүүн Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурна.

-Гадаад улсын төрийн тэргүүн Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурж байхад түүний гэргий /нөхөр/, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний гэргий нар ширээний ард зогсож байна. Албан ёсны төлөөлөгчид уулзалт, хэлэлцээний танхим руу явна.

-Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад орны тэргүүн нар гэргий /нөхөр/ нарын хамт дурсгалын гэрэл зураг авахуулна. Баруун гар талаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн гэргий, гадаад улсын төрийн тэргүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүний гэргий /нөхөр/ гэсэн дарааллаар эгнэн зогсоно.

-Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслол өндөрлөсний дараа гэргий нар тусдаа ёслолын уулзалт хийх, эсхүл тусгай хөтөлбөрийн дагуу салж явна.

46.1.15. Ганцаарчилсан уулзалт

-Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын төрийн тэргүүнтэй Төрийн ёслол, хүндэтгэлийн гэр өргөөнд ганцаарчилсан уулзалт хийнэ.

-Ганцаарчилсан уулзалт хийх Төрийн ёслол, хүндэтгэлийн гэр өргөөнд Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан байна.

-Төрийн ёслол, хүндэтгэлийн гэр өргөөний хойморын зүүн талын суудалд Монгол Улсын Ерөнхийлөгч, баруун талын суудалд гадаад улсын төрийн тэргүүн сууна. Уулзалтад оролцох монголын талын албаны хүмүүс өргөөний зүүн талын суудлуудад, гадаад улсын төрийн тэргүүнийг дагалдан яваа албаны төлөөлөгч баруун талын суудлуудад тус тус сууна.

-Ганцаарчилсан уулзалтад тал бүрээс албан ёсны 4 төлөөлөгч, албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөгч тус тус оролцоно. Ганцаарчилсан уулзалт 15 минут орчим үргэлжилнэ.

-Уулзалтад оролцогсдыг айраг, цагаан идээ, төрөл бүрийн ундаагаар дайлна.

-Уулзалтад оролцогсод Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүнийг дагалдан гэрийн хоймороор нар зөв тойрч гарна.

46.1.16. Бараалхах уулзалт

-Монгол Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гадаад улсын төрийн тэргүүний байрлаж буй өргөө, зочид буудалд очиж, түүнд бараалхаж болно. Бараалхах уулзалтыг хоёр тал тохиролцсоны дагуу Төрийн ордонд хийж болно. Бараалхах уулзалтад байлцах хүмүүсийг хоёр тал урьдчилан тохирно. Бараалхах уулзалтад хоёр талын хэлмэрч, тэмдэглэл хөтлөх хүн байлцана.

46.1.17. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд үг хэлэх

-Монгол Улсад төрийн болон албан ёсны айлчлал хийж буй гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд үг хэлэх эсэхийг харилцааны түвшин, харилцан адил байх зарчмыг харгалзан тухай бүр шийдвэрлэнэ.

-Гадаад улсын төрийн тэргүүн Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд үг хэлэх тохиолдолд Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу түүнийг зохион байгуулна.

46.1.18. Албан ёсны хэлэлцээ

-Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад орны төрийн тэргүүнтэй албан ёсны хэлэлцээ хийнэ. Хэлэлцээг Төрийн ордны хэлэлцээний танхимд явуулна. Хэлэлцээний ширээнд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа мандуулж, хэлэлцээнд оролцогсдын нэрс, микрофон, бичгийн хэрэгсэл /дэвтэр, үзэг/, цэвэр ус, ундаа зэргийг тавина.

-Хэлэлцээний танхимын цонхон талд монголын талын төлөөлөгчид, эсрэг талд гадаадын төлөөлөгчид сууна. Хоёр талын зөвлөх, мэргэжилтэн нар арын эгнээнд сууна. Хэлэлцээнд албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

-Хэлэлцээний аудио бичлэгийг хийнэ.

-Хэлэлцээний үеэр цай, кофе зэрэг халуун ундаагаар үйлчилнэ.

46.1.19. Баримт бичигт гарын үзэг зурах ёслол

-Гадаад улсын төрийн тэргүүний айлчлалын үеэр болох баримт бичигт гарын үсэг зурах ёслолыг Төрийн ёслол, хүндэтгэлийн Их танхимд зохион байгуулна. Баримт бичигт гарын үсэг зурах ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нар оролцоно. Баримт бичигт гарын үсэг зурах

ширээн дээр баруун гар талд тухайн улсын, зүүн гар талд Монгол Улсын Төрийн далбаа, гарын үсэг зурах хос үзэг, бэх дарагч, баримт бичиг зэргийг тавьсан байна.

-Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүнийг баруун гар талдаа авч баримт бичигт гарын үсэг зурах ширээний суудлын ард зогсоно. Ёслолд оролцох монголын талын албаны хүмүүс танхимын зүүн талд баруун гар талаасаа ёслолын ахлалаар танхимын гол руу харан зогсоно. Ёслолд оролцох зочин талын албаны хүмүүс танхимын баруун талд зүүн гар талаасаа ёслолын ахлалаар танхимын гол руу харан зогсоно.

-Баримт бичигт гарын үсэг зурахын өмнө баримт бичгийн болон түүнд гарын үсэг зурах хүний албан тушаал, овог нэрийг монгол хэлээр болон тухайн орны эсхүл Нэгдсэн Үндэстний байгууллагын албан ёсны аль нэг хэлээр зарлана. Баримт бичгийг Гадаад хэргийн яамны Олон улсын эрх зүйн газрын дипломат ажилтан түшнэ. Баримт бичигт гарын үсэг зурсан хүмүүс баримт бичгээ харилцан солилцож, гар барина. Дараа нь Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нартай гар барина. Ёслолд оролцогсад алга ташиж баяр хүргэнэ. Баримт бичигт гарын үсэг зурж дуусмагц, хундага өргөнө.

46.1.20. Хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийх

-Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нар уулзалт, хэлэлцээний дүнгийн талаар хоёр талын болон олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийж болно. Энэ талаар хоёр тал дипломат шугамаар урьдчилан тохирсон байна.

-Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нар хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд хийх мэдээллийг Төрийн ёслол, хүндэтгэлийн Их танхимд зохион байгуулна.

-Эхлээд Монгол Улсын Ерөнхийлөгч дараа нь гадаад улсын төрийн тэргүүн мэдээлэл хийнэ. Хоёр тал урьдчилан тохирсны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын тэргүүн нар хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдийн асуултад хариулж болно.

-Гадаад хэргийн яамны хэвлэлийн төлөөлөгч арга хэмжээг хөтлөн явуулна. Мэдээллийг хоёр талын албан ёсны хэлмэрч орчуулна. Тэмдэглэл хөтөлж, аудио бичлэг хийнэ.

46.1.21. Хүндэтгэлийн зоог

-Монгол Улсад төрийн болон албан ёсны айлчлал хийж буй гадаад орны төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/-г хүндэтгэн Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний гэргий зоог барина. Хүндэтгэлийн зоогийг албан ёсоор утгах ёслол, хэлэлцээ явагдсан өдрийн орой нь зохион байгуулна.

-Зоог барих байрны үүдэнд Хүндэт харуул, байр уруу очих зам дагуу морьтой Хүндэт харуул байрласан байна.

-Зоогт уригдсан хүмүүс албан ёсны, цэргийн, ёслолын болон үндэсний хувцастай байна.

-Зоогт уригдсан хүмүүс зоог эхлэхээс 15 минутын өмнө ирсэн байна. Тэдэнд дарс, төрөл бүрийн ундаагаар аперитив барина.

-Гадаад улсын төрийн тэргүүн гэргий /нөхөр/-н хамт хүндэтгэлийн зоог барих байранд ирэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч, гэргий нар угтана.

-Ерөнхийлөгч, гэргий нар зоогийн эхэнд тусгай танхимд түр саатаж, аперитив барина. Цаг агаар тааламжтай үед зоогийн эхэнд гадаадын төлөөлөгчдөд монгол ахуйг харуулсан үзвэр үзүүлж, монгол гэрт зочлуулж болно.

-Зоогт уригдсан зочин талын дараа нь монголын талын төлөөлөгчдийг Ерөнхийлөгч, гэргий, гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нарт дуудаж танилцуулна. Зоогт уригдагсад Ерөнхийлөгч, гэргий /нөхөр/, гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нартай гар барьж мэндчилэн, зоогийн танхимд орж хуваарьт суудлын ард зогсож хүлээнэ.

-Мэндчилгээ өндөрлөж Ерөнхийлөгч, төрийн тэргүүн нар гэргий /нөхөр/-н хамт зоогийн танхимд орж үндсэн ширээнд хуваарьт суудлынхаа ард зогсоход Үлээвэр найрал хөгжим эхлээд тухайн улсын, дараа нь Монгол Улсын Төрийн дууллыг тус тус эгшиглүүлнэ. Зоогт уригдагсад зогсож хүндэтгэнэ.

-Төрийн дуулал эгшиглэж дууссаны дараа зоогт уригдагсад суудлаа эзэлнэ. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч үг хэлж, хундага өргөнө. Дараа нь гадаад улсын төрийн тэргүүн хариу үг хэлж хундага өргөнө. Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нарын хэлэх үгийг орчуулан ширээн дээр урьдчилан тавьсан байна.

-Зоогийн ширээн дээр кувертийн хуудас, зоогийн цэс, урлагийн тоглолтын хөтөлбөр байна. Зоогийн үеэр мэргэжлийн урлагийн хамтлаг үндэсний болон сонгодог дуу, хөгжмийн бүтээлээс тоглоно.

-Зоогийн төгсгөл цайны хэсгийг монгол гэрт барихаар зохион байгуулж болно.

-Зоог өндөрлөхөд Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад улсын төрийн тэргүүн нар суудлаасаа эхэлж босно. Бусад хүмүүс дараа нь босно.

-Ерөнхийлөгч нар бэлэг дурсгалын зүйлс өөрсдөө солилцохоор хоёр тал урьдчилан тохирсон бол энэ ёслолыг хүндэтгэлийн зоогийн төгсгөлд тусгай танхимд, эсхүл монгол гэрт хийнэ.

-Монгол Улсын Ерөнхийлөгч гэргийн хамт гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/-г зоог барьсан өргөөний үүдэнд үдэж өгнө.

46.1.22. Одон, медалиар харилцан шагнах ёслол

-Гадаад улсын төрийн тэргүүний төрийн айлчлалын үеэр одон, медалиар харилцан шагнах ёслол зохион байгуулж болно.

-Одон медалиар харилцан шагнах асуудлыг хоёр тал урьдчилан тохиролцоно.

46.1.23. Орон нутагт зочлох

-Гадаад улсын төрийн тэргүүн төрийн болон албан ёсны айлчлал хийхдээ Монгол Улсын орон нутагт зочилж болно.

-Төрийн тэргүүн орон нутагт зочлоход Монгол Улсын Засгийн газрын нэг гишүүн-сайд дагалдан явна.

-Төрийн тэргүүн орон нутагт очих, буцахад нь тухайн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар угтаж, үднэ.

-Төрийн тэргүүн орон нутагт зочлох хөтөлбөрт малчин айлд зочлох, үйлдвэр, аж ахуйн газартай танилцах, эрдэм шинжилгээний байгууллагад зочлох, соёл, спортын арга хэмжээ сонирхуулах зэрэг арга хэмжээг тусгана.

46.1.24. Нисэх буудалд үдэх ёслол

-Гадаад улсын төрийн тэргүүн онцгой үүргийн болон хуваарьт нислэгээр буцаж байгаа бол үдэх ёслолыг нислэгийн талбайд үйлдэнэ. Шаардлагатай тохиолдолд олон улсын нисэх онгоцны буудлын байранд хийнэ.

-Онгоцны шат, машинаас нисэх онгоцны шат хүртэлх зам дагуу улаан хивс дэвсэнэ.

-Хүндэт харуулын нэг салаа 25 цэрэг улаан хивсний хоёр талаар жагссан байна.

-Гадаад улсын төрийн тэргүүн төрийн болон албан ёсны айлчлал хийгээд буцахад Монгол Улсын Гадаад хэргийн сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд нар нисэх онгоцны буудалд үднэ. Гадаад улсын төрийн тэргүүн гэргий /нөхөр/-н хамт айлчилсан бол Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайдын гэргий /нөхөр/ хамт үднэ. Гадаад хэргийн сайд эзгүй тохиолдолд гадаад улсын төрийн тэргүүнийг айлчлалын хугацаанд дагалдах Засгийн газрын гишүүн-сайд үднэ.

-Гадаад улсын төрийн тэргүүн төрийн болон албан ёсны айлчлал хийгээд буцахад нисэх онгоцны буудалд үдэх ёслолд тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдыг урьж оролцуулна. Гадаад улсын төрийн тэргүүн гэргий /нөхөр/-н хамт айлчилсан бол Элчин сайдын гэргий /нөхөр/-г үдэх ёслолд урьж оролцуулна.

-Гадаад улсын төрийн тэргүүний байрласан өргөө, зочид буудлын удирдлага улаан хивс дэвсэж, амьд цэцгийн баглаа барьж үднэ.

-Монгол Улсын Гадаад хэргийн сайд гэргий /нөхөр/-н хамт гадаад улсын төрийн тэргүүний байрласан өргөө, зочид буудалд очиж, нисэх онгоцны буудал руу хамт явна. Гадаад хэргийн сайд төрийн тэргүүнтэй хамт нэг машинд, гэргий /нөхөр/ нар хамт нэг машинд сууж явна.

-Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нар албан ёсоор үдэж буй монголын талын төлөөлөгчидтэй гар барьж салах ёслол хийгээд, цааш Хүндэт харуулын цэргүүдийн дундуур алхаж өнгөрнө.

-Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нар монгол үндэсний хувцастай бүсгүй, залуу амьд цэцгийн баглаа барина.

-Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нар албан ёсоор үдэж буй Монгол Улсын Гадаад хэргийн сайд, түүний гэргий /нөхөр/-тэй нисэх онгоцны шатны дэргэд гар барьж, салах ёс гүйцэтгэнэ.

46.2. Гадаад улсын төрийн тэргүүний ажлын айлчлал

46.2.1. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгын дагуу тус улсад ажлын айлчлал хийнэ.

46.2.2. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад хийх ажлын айлчлалыг ажлын 2 хоногт багтаан хэрэгжүүлнэ.

46.2.3. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад хийх ажлын айлчлалаа орон нутгаас эхлэн хэрэгжүүлж болно.

46.2.4. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад ажлын айлчлал хийхэд Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд байнга дагалдан явна.

46.2.5. Гадаад улсын төрийн тэргүүний ажлын айлчлал нь нисэх онгоцны буудалд угтах, үдэх ёслол, ажлын уулзалт, баримт бичигт гарын үсэг зурах ёслол, хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийх, ажлын зоог зэрэг үндсэн арга хэмжээг багтаана.

46.2.6. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад ажлын айлчлалаар ирэх, буцахад Монгол Улсын Засгийн газрын гишүүн-сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд нисэх буудалд угтаж, үднэ.

46.2.7. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад ажлын айлчлал хийхэд Чингисийн талбайд албан ёсоор угтах ёслол үйлдэхгүй.

46.2.8. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад ажлын айлчлал хийхэд нисэх буудал, хөлөглөх машин, байрлах байранд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа мандуулна.

46.2.9. Монгол Улсад ажлын айлчлал хийж буй гадаад улсын төрийн тэргүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч ажлын зоог барина. Зоогийн эхэнд товч үг хэлнэ. Зоогийн эхэнд төрийн дуулалууд эгшиглүүлэхгүй.

46.2.10. Монгол Улсад ажлын айлчлал хийж буй гадаад улсын төрийн тэргүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч бэлэг дурсгалын зүйл өгч болно.

46.3. Гадаад улсын төрийн тэргүүний хувийн айлчлал

46.3.1. Гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэргий /нөхөр/ Монгол Улсад хувийн айлчлалаар ирэх, буцахад тэднийг нисэх буудалд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга угтаж, үднэ.

46.3.2. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсад хувийн айлчлал хийхэд хөлөглөх машин, байрлах байранд тухайн улсын төрийн далбаа мандуулна.

46.3.3. Монгол Улсад хувийн айлчлал хийж буй гадаад улсын төрийн тэргүүнтэй Монгол Улсын Ерөнхийлөгч уулзаж, зоог барьж, бэлэг, дурсгалын зүйл өгч болно.

46.4. Гадаад улсын төрийн тэргүүн дамжин өнгөрөх

46.4.1. Гадаад улсын төрийн тэргүүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тохиолдолд Гадаад хэргийн сайд нисэх буудалд очиж хүндэтгэл үзүүлнэ.

47. Гадаад улсын Парламентын даргын айлчлал

47.1. Гадаад улсын Парламентын даргын албан ёсны айлчлал

47.1.1. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсын Их Хурлын даргын урилгын дагуу тус улсад албан ёсны айлчлал хийнэ.

47.1.2. Гадаад улсын Парламентын даргын албан ёсны айлчлал нь дараах үндсэн арга хэмжээг багтаана. Үүнд:

- Нисэх буудалд угтах, үдэх ёслол;
- Чингисийн талбайд угтах ёслол;
- Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслол;
- Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслол;
- Ганцаарчилсан уулзалт;
- Албан ёсны хэлэлцээ;
- Бараалхах уулзалт;
- Баримт бичигт гарын үсэг зурах ёслол;
- Хүндэтгэлийн зоог;
- Орон нутагт зочлох зэрэг.

47.1.3. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад хийх албан ёсны айлчлалаа Улаанбаатар хотоос эхлэн хэрэгжүүлнэ.

47.1.4. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад хийх албан ёсны айлчлалыг ажлын 3 хоногт багтаан хэрэгжүүлнэ.

47.1.5. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад албан ёсны айлчлал хийхэд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Парламентын бүлгийн дарга байнга дагалдан явна.

47.1.6. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад албан ёсны айлчлал хийхэд дараах газруудад Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбааг мандуулна. Үүнд:

- Чингисийн талбай;
- Нисэх онгоцны буудал;
- Хүндэтгэлийн зоог барих байр;
- Байрлах өргөө, зочид буудал;
- Хөлөглөх машин;
- Төрийн ордны ёслол, хүндэтгэлийн Их танхим;
- Төрийн ордны “Баганат” танхим;
- Ганцаарчилсан уулзалт хийх танхим;
- Албан ёсны хэлэлцээ хийх танхим;
- Бараалхах уулзалт хийх танхим;
- Хүндэтгэлийн зоог барих танхим;
- Албан ёсны хэлэлцээний ширээ;
- Баримт бичигт гарын үсэг зурах ширээ.

47.1.7. Нисэх онгоцны буудалд угтах ёслол

-Гадаад улсын Парламенын дарга онцгой үүргийн болон хуваарьт нислэгээр ирж байгаа бол угтах ёслолыг нислэгийн талбайд үйлдэнэ. Шаардлагатай тохиолдолд олон улсын нисэх буудлын байранд хийнэ.

-Онгоцны шат, онгоцноос машин хүртэлх зам дагуу улаан хивс дэвсэнэ.

-Гадаад улсын Парламентын дарга албан ёсны айлчлал хийхээр ирэхэд Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь парламентын бүлгийн дарга нар угтана.

-Гадаад улсын Парламентын дарга албан ёсны айлчлал хийхээр ирэхэд нисэх буудалд угтах ёслолд тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдыг урьж оролцуулна. Гадаад улсын парламентын дарга гэргий /нөхөр/-н хамт айлчилбал Элчин сайдын гэргий /нөхөр/-г угтах ёслолд урьж оролцуулна.

-Онгоц зогсоолд ирж зогсон хаалгаа нээхэд Ёслолын газрын захирал, тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд нар нисэх онгоцонд орж парламентын дарга, түүний гэргийг Монгол Улсад тавтай зочлохыг ерөөж, нисэх онгоцноос урьж буулгана.

-Гадаад улсын парламентын дарга, түүний гэргий /нөхөр/ нисэх онгоцноос бууж ирэхэд монгол үндэсний хувцастай бүсгүй, залуу мөнгөн аягтай ааруул, хадаг өргөн барьж угтан мэндчилнэ.

-Гадаад улсын Парламентын дарга, түүний гэргий Монголын талаас албан ёсоор угтаж буй Улсын Их Хурлын дэд дарга, түүний гэргийтэй мэндчилнэ.

-Гадаад улсын Парламентын дарга, Монгол Улсын Их Хурлын дэд дарга нар улаан хивсэн дээгүүр явж, монголын талаас албан ёсоор угтаж буй бусад төлөөлөгчид рүү очно.

-Монголын талын албаны хүмүүсийг Ёслолын газрын захирал Парламентын даргад танилцуулна.

-Гадаад улсын Парламентын дарга, Монгол Улсын Их Хурлын дэд даргын хамт нэг машинд сууж явна. Гадаад улсын Парламентын даргын гэргий, Монгол Улсын Их Хурлын дэд даргын гэргий нар хамт нэг машинд сууж явна.

-Гадаад улсын Парламентын дарга байрлах өргөө, зочид буудалд хүрэлцэн ирэхэд өргөөний болон зочид буудлын удирдлага улаан хивс дэвсэж, цэцгийн баглаа барьж угтана. Монгол Улсын Их Хурлын дэд дарга гадаад улсын Парламентын даргыг байрлах өргөөнд нь хүргэж өгөөд буцна. Ёслолын газрын захирал хүндэт зочныг өрөөнд нь оруулж өгнө.

-Гадаад улсын Парламентын дарга, түүний гэргий /нөхөр/ байрлах өргөөнд Монгол Улсын Их Хурлын дарга, түүний гэргий нараас дурсгасан цэцгийн баглаа тавьсан байна.

47.1.8. Чингисийн талбайд угтах ёслол

-Гадаад улсын Парламентын даргын хөлөглөсөн машин зогсох газарт, Төрийн ордны хүндэтгэлийн шатны доод гол хэсэгт тус тус хивс дэвсэж, хивс хоорондын зайд гудаслаг улаан хивс дэвсэнэ. Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө хивс, шатны дагуу улаан хивс дэвсэнэ.

-Их эзэн Чингис хааны хөшөөний хоёр талд болон шатны дагуу хүндэт харуулын 16 цэрэг жагссан байна.

- Гадаад улсын Парламентын дарга, гэргийн хамт нэг машинд сууна. Гадаад улсын Парламентын дарга машины баруун хойд талын суудалд сууна. Гэргий нь зүүн хойд талын суудалд сууна.

-Гадаад улсын Парламентын даргын хөлөглөсөн машин Чингисийн талбайд ирэн, Төрийн ордны хүндэтгэлийн шатны зүүн өмнө зогсоход Төрийн хамгаалалтын албаны хоёр ажилтан хаалгыг зэрэг нээж өгнө.

-Гадаад улсын Парламентын дарга, гэргийн хамт улаан хивсэн дээгүүр алхаж, Төрийн ордны хүндэтгэлийн шатны өмнө зогсож буй Улсын Их Хурлын дарга, түүний гэргий нартай очиж мэндчилнэ.

-Монгол Улсын Их Хурлын дарга гадаад улсын Парламентын даргатай мэндчилээд дараа нь түүний гэргий /нөхөр/-тэй мэндчилнэ. Монгол Улсын Их Хурлын даргын гэргий гадаад улсын төрийн тэргүүнтэй мэндчилээд дараа нь түүний гэргий /нөхөр/-тэй мэндчилнэ.

-Харилцан мэндчилсний дараа монгол үндэсний хувцастай эрэгтэй, эмэгтэй хоёр монгол хүүхэд гадаад улсын парламентын дарга, түүний гэргий /нөхөр/-д амьд цэцгийн баглаа өргөн барина.

-Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын дарга нар гэргий нарын хамт дурсгалын гэрэл зураг авахуулна. Баруун гар талаасаа Монгол Улсын Их Хурлын даргын гэргий, гадаад улсын Парламентын дарга, Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын даргын гэргий гэсэн дарааллаар эгнэн зогсоно.

47.1.9. Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслол

-Дурсгалын гэрэл зураг татуулсны дараа Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын даргыг баруун гар талдаа авч шатаар өгсөнө. Улсын Их Хурлын даргын гэргий, гадаад улсын Парламентын даргын гэргийг баруун гар талдаа авч шатаар дагалдан өгсөнө. Гадаад улсын Парламентын даргыг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчид тав, таваараа нэг эгнээ болон шатаар өгсөнө.

-Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын дарга, албан ёсны төлөөлөгчид Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө дэвссэн хивсэн дээр очиж зогсоод, толгой бөхийн хүндэтгэл илэрхийлнэ.

-Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын дарга, гэргий нар хүндэтгэл илэрхийлсэний дараа хөшөөний баруун талын хаалгаар Төрийн ордонд, дагалдан яваа албаны төлөөлөгчид хөшөөний зүүн талын хаалгаар орно.

47.1.10. Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслол

-Албан ёсоор угтах ёслол өндөрлөж, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлсэний дараа Монгол Улсын Их Хурлын дарга, гэргий нар гадаад улсын Парламентын дарга, гэргий /нөхөр/ нарын хамт Төрийн ордны “Баганат” танхимд орж ирнэ.

-“Баганат” танхимд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа мандуулсан байна.

-Гадаад улсын Парламентын дарга Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслолын ширээ, сандлыг бэлтгэж, Хүндэт дэвтэр, үзэг бэлтгэсэн байна. Ширээг амьд цэцгээр чимэглэсэн байна.

-Гадаад улсын Парламентын дарга Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурна.

-Гадаад улсын Парламентын дарга Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурж байхад түүний гэргий, Монгол Улсын Их Хурлын дарга, түүний гэргий нар ширээний ард зогсож байна. Албан ёсны төлөөлөгчид уулзалт, хэлэлцээний танхим руу явж байна.

-Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад орны Парламентын дарга гэргий /нөхөр/ нарын хамт дурсгалын гэрэл зураг авахуулна. Баруун гар талаас Монгол Улсын Их Хурлын даргын гэргий, гадаад улсын Парламентын дарга, Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын даргын гэргий /нөхөр/ гэсэн дарааллаар эгнэн зогсоно.

-Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслол өндөрлөсний дараа гэргий нар тусдаа ёслолын уулзалт хийх, эсхүл тусгай хөтөлбөрийн дагуу явна.

47.1.11. Ганцаарчилсан уулзалт

-Монгол Улсын Их Хурлын дарга гадаад улсын Парламентын даргатай ганцаарчилсан уулзалт хийж болно.

-Ганцаарчилсан уулзалт 15 минут орчим үргэлжилнэ. Уулзалтыг албан ёсны орчуулагч хэлмэрчилж, ярианы тэмдэглэл хөтөлнө. Уулзалтад оролцогсдыг цай, цагаан идээ, төрөл бүрийн ундаагаар зочилно.

47.1.12. Бараалхах уулзалт

-Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй гадаад улсын Парламентын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхана. Бараалхах уулзалт Төрийн хүндэтгэлийн гэр өргөөнд болно.

-Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн-сайд гадаад улсын Парламентын даргад бараалхаж болно.

47.1.13. Албан ёсны хэлэлцээ

-Монгол Улсын Их Хурлын дарга гадаад улсын Парламентын даргатай Төрийн ордны хэлэлцээний танхимд албан ёсны хэлэлцээ хийнэ. Хэлэлцээний ширээнд Монгол Улсын болон тухайн улсын төрийн далбаа мандуулж, хэлэлцээнд оролцогсдын нэрс, микрофон, бичгийн хэрэгсэл /дэвтэр, үзэг/, цэвэр ус, ундаа зэргийг тавина.

-Хэлэлцээний танхимын цонхон талд монголын талын төлөөлөгчид, эсрэг талд гадаадын төлөөлөгчид сууна. Хэлэлцээнд албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

-Хэлэлцээний аудио бичлэгийг хийнэ.

-Хэлэлцээний үеэр цай, кофе зэрэг халуун ундаагаар үйлчилнэ.

47.1.14. Баримт бичигт гарын үзэг зурах ёслол

-Гадаад улсын Парламентын даргын албан ёсны айлчлалын үеэр болох баримт бичигт гарын үсэг зурах ёслолыг Төрийн ёслол, хүндэтгэлийн Их танхимд зохион байгуулна. Баримт бичигт гарын үсэг зурах ёслолд Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын дарга нар оролцоно. Баримт бичигт гарын үсэг зурах ширээний баруун гар талд тухайн улсын, зүүн гар талд Монгол Улсын Төрийн далбаа, гарын үсэг зурах хос үзэг, бэх дарагч, баримт бичиг зэргийг тавьсан байна.

-Монгол Улсын Их Хурлын дарга гадаад улсын Парламентын даргыг баруун гар талдаа авч баримт бичигт гарын үсэг зурах ширээний суудлын ард зогсоно. Ёслолд оролцох монголын талын албаны хүмүүс танхимийн зүүн талд баруун гар талаасаа ёслолын ахлалаар танхимын гол руу харан зогсоно. Ёслолд оролцох зочин талын албаны хүмүүс танхимын баруун талд зүүн гар талаасаа ёслолын ахлалаар танхимын гол руу харан зогсоно.

-Баримт бичигт гарын үсэг зурахын өмнө баримт бичгийн болон түүнд гарын үсэг зурах хүний албан тушаал, овог нэрийг монгол хэлээр болон тухайн орны, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан ёсны аль нэг хэлээр зарлана. Баримт бичгийг Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан түшнэ. Баримт бичигт гарын үсэг зурсан хүмүүс баримт бичгээ харилцан солилцож, гар барина. Дараа нь Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын дарга нартай гар

барина. Ёслолд оролцогсод алга ташиж баяр хүргэнэ. Баримт бичигт гарын үсэг зурж дуусмагц, хундага өргөнө.

47.1.15. Хүндэтгэлийн зоог

-Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй гадаад улсын Парламентын дарга, түүний гэргий /нөхөр/-г хүндэтгэн Монгол Улсын Их Хурлын дарга, түүний гэргий зоог барина. Хүндэтгэлийн зоогийг албан ёсоор угтах ёслол, хэлэлцээ явагдсан өдөр зохион байгуулна.

-Зоог барих байрны үүдэнд Хүндэт харуул байрласан байна.

-Зоогт уригдсан хүмүүс албан ёсны, цэргийн ёслолын болон үндэсний хувцастай байна.

-Зоогт уригдсан хүмүүс зоог эхлэхээс 15 минутын өмнө ирсэн байна. Тэдэнд дарс, төрөл бүрийн ундаагаар аперитив барина.

-Гадаад улсын Парламентын дарга гэргий /нөхөр/-н хамт хүндэтгэлийн зоог барих байранд ирэхэд Монгол Улсын Их Хурлын дарга, гэргий нар угтан авна.

-Парламентын дарга, гэргий нар зоогийн эхэнд тусгай танхимд түр саатаж, аперитив барина. Цаг агаар тааламжтай үед зоогийн эхэнд гадаадын төлөөлөгчдөд монгол ахуйг харуулсан үзвэр үзүүлж, монгол гэрт зочлуулж болно.

-Ёслолын газрын захиралзоогт уригдсан зочин талын дараа нь монголын талын төлөөлөгчдийг Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын даргын гэргий, гадаад улсын Парламентын дарга, түүний гэргий /нөхөр/ нарт дуудаж танилцуулна. Зоогт уригдагсад Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын даргын гэргий, гадаад улсын Парламентын дарга, түүний гэргий /нөхөр/ нартай гар барьж мэндчилэн, зоогийн танхимд орж хуваарьт суудлын ард зогсож хүлээнэ.

-Мэндчилгээ өндөрлөж Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын дарга нар гэргий /нөхөр/-н хамт зоогийн танхимд орж үндсэн ширээнд хуваарьт суудлынхаа ард зогсоход Үлгэр жишээ, Үлээвэр найрал хөгжим эхлээд тухайн улсын, дараа нь Монгол Улсын Төрийн дуулалыг тус тус эгшиглүүлнэ. Зоогт уригдагсад зогсож хүндэтгэнэ.

-Төрийн дуулал эгшиглэж дууссаны дараа зоогт уригдагсад суудлаа эзэлнэ. Эхлээд Монгол Улсын Их Хурлын дарга үг хэлж, хундага өргөнө. Дараа нь гадаад улсын Парламентын дарга үг хэлж хундага өргөнө. Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын дарга нарын хэлэх үгийг орчуулан ширээн дээр тавьж урьдчилан тавьсан байна.

-Ширээн дээр кувертийн хуудас, зоогийн цэс, урлагийн тоглолтын хөтөлбөр байна. Зоогийн үеэр мэргэжлийн урлагийн хамтлаг үндэсний болон сонгодог дуу, хөгжмийн бүтээлээс тоглоно.

-Зоогийн төгсгөлийн цайны хэсгийг монгол гэрт өгч болно.

-Зоог өндөрлөхөд Монгол Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын дарга нар суудлаасаа эхэлж босно. Бусад хүмүүс дараа нь босно.

-Улсын Их Хурлын дарга, гадаад улсын Парламентын дарга нар бэлэг дурсгалын зүйлс өөрсдөө солилцохоор хоёр тал урьдчилан тохирсон бол энэ ёслолыг хүндэтгэлийн зоогийн төгсгөлд тусгай танхимд, эсхүл монгол гэрт хийнэ.

-Монгол Улсын Их Хурлын дарга гэргийн хамт гадаад улсын Парламентын дарга, түүний гэргий /нөхөр/-г зоог барьсан өргөөний үүдэнд үдэж өгнө.

-Зоог барих болон бусад ёслол хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулагдах газрын багтаамж, оролцох хүний тоо, зохион байгуулагдах хугацааг Цагдаагийн байгууллагад урьдчилан өгч хамтран ажиллана.

47.1.16. Орон нутагт зочлох

-Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад албан ёсны айлчлал хийхдээ орон нутагт зочилж болно.

-Гадаад улсын Парламентын дарга орон нутагт зочлоход Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Парламентын бүлгийн дарга дагалдан явна.

-Гадаад улсын Парламентын дарга орон нутагт очих, буцахад нь тухайн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар угтаж, үднэ.

-Гадаад улсын Парламентын дарга орон нутагт зочлох хөтөлбөрт малчин айлд зочлох, үйлдвэр, аж ахуйн газартай танилцах, эрдэм шинжилгээний байгууллагад зочлох, соёл, спортын арга хэмжээ сонирхох зэрэг арга хэмжээг тусгана.

47.1.17. Нисэх буудалд үдэх ёслол

-Гадаад улсын Парламентын дарга онцгой үүргийн болон хуваарьт нислэгээр буцаж байгаа бол үдэх ёслолыг нислэгийн талбайд үйлдэнэ. Шаардлагатай тохиолдолд олон улсын нисэх онгоцны буудлын байранд хийнэ.

-Нисэх онгоцны шат, машинаас онгоцны шат хүртэлх зам дагуу улаан хивс дэвсэнэ.

-Гадаад улсын Парламентын дарга албан ёсны айлчлал хийгээд буцахад Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурал дахь Парламентын бүлгийн дарга нар нисэх буудалд үднэ.

-Гадаад улсын Парламентын дарга албан ёсны айлчлал хийгээд буцахад нисэх буудалд үдэх ёслолд тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдыг урьж оролцуулна. Гадаад улсын Парламентын дарга гэргий /нөхөр/-н хамт айлчилсан бол Элчин сайдын гэргий /нөхөр/-г үдэх ёслолд урьж оролцуулна.

-Гадаад улсын Парламентын дарга байрласан өргөө, зочид буудлын удирдлага улаан хивс дэвсэж, амьд цэцгийн баглаа барьж үдэж өгнө.

-Монгол Улсын Их Хурлын дэд дарга гэргийн хамт гадаад улсын Парламентын дарга байрласан өргөө, зочид буудалд очиж, нисэх онгоцны буудал уруу хамт явна. Монгол Улсын Их Хурлын дэд дарга гадаад улсын Парламентын даргатай хамт нэг машинд, гэргий нар хамт нэг машинд сууж явна.

-Гадаад улсын Парламентын дарга, түүний гэргий нар албан ёсоор үдэж буй монголын талын төлөөлөгчидтэй гар барьж салах ёслол хийгээд, цааш алхаж өнгөрнө.

-Гадаад улсын Парламентын дарга, гэргий нарт монгол үндэсний хувцастай бүсгүй, залуу амьд цэцгийн баглаа барина

-Гадаад улсын Парламентын дарга, түүний гэргий /нөхөр/ нар албан ёсоор үдэж буй Монгол Улсын Их Хурлын дэд дарга, түүний гэргийтэй нисэх онгоцны шатны дэргэд гар барьж, салах ёс гүйцэтгэнэ.

47.2. Гадаад улсын Парламентын даргын ажлын айлчлал

47.2.1. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсын Их Хурлын даргын урилгын дагуу тус улсад ажлын айлчлал хийнэ.

47.2.2. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад хийх ажлын айлчлалыг ажлын 2 хоногт багтаан хэрэгжүүлнэ.

47.2.3. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад хийх ажлын айлчлалаа орон нутгаас эхлэн хэрэгжүүлж болно.

47.2.4. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад ажлын айлчлал хийхэд Улсын Их Хурал дахь Парламентын бүлгийн гишүүн байнга дагалдан явна.

47.2.5. Гадаад улсын Парламентын даргын ажлын айлчлалд нисэх буудалд угтах, үдэх, ажлын уулзалт, бараалхах уулзалт, ажлын зоог зэрэг үндсэн арга хэмжээг багтаана.

47.2.6. Гадаад улсын Парламентын дарга ажлын айлчлал хийхээр ирэх, буцахад Улсын Их Хурал дахь Парламентын бүлгийн дарга нисэх буудалд угтаж, үднэ.

47.2.7. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад ажлын айлчлал хийхэд нисэх буудал, хөлөглөх машин, байрлах байранд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа мандуулна.

47.2.8. Монгол Улсад ажлын айлчлал хийж буй гадаад улсын Парламентын даргад Монгол Улсын Их Хурлын дарга ажлын зоог барина. Зоогийн эхэнд төрийн дуулал эгшиглүүлэхгүй, үг хэлнэ.

47.3. Гадаад улсын Парламентын даргын хувийн айлчлал

47.3.1. Гадаад улсын Парламентын дарга, түүний гэргий /нөхөр/ Монгол Улсад хувийн айлчлалаар ирэх, буцахад тэднийг нисэх онгоцны буудалд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга угтаж, үднэ.

47.3.2. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсад хувийн айлчлал хийхэд хөлөглөх машин, байрлах байранд тухайн улсын Төрийн далбаа мандуулна.

47.3.3. Монгол Улсад хувийн айлчлал хийж буй гадаад улсын Парламентын даргатай Монгол Улсын Их Хурлын дарга уулзаж, зоог барьж, бэлэг, дурсгалын зүйл өгч болно.

47.4. Гадаад улсын Парламентын дарга дамжин өнгөрөх

47.4.1. Гадаад улсын Парламентын дарга Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тохиолдолд Монгол Улсын Их Хурлын дэд дарга нисэх онгоцны буудалд очиж хүндэтгэл үзүүлнэ.

48. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний айлчлал

48.1. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний албан ёсны айлчлал

48.1.1. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсын Ерөнхий сайдын урилгын дагуу тус улсад албан ёсны айлчлал хийнэ.

48.1.2 Гадаад улсын Засгийн газрын тэргүүний албан ёсны айлчлал нь дараах үндсэн арга хэмжээг багтаана. Үүнд:

- Нисэх буудалд угтах, үдэх ёслол;
- Чингисийн талбайд албан ёсоор угтах ёслол;
- Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслол;
- Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслол;
- Ганцаарчилсан уулзалт;
- Албан ёсны хэлэлцээ;
- Бараалхах уулзалт;

- Баримт бичигт гарын үсэг зурах ёслол;
- Хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийх;
- Хүндэтгэлийн зоог;
- Орон нутагт зочлох зэрэг.

48.1.3. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний албан ёсны айлчлал Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос эхэлнэ.

48.1.4. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад хийх албан ёсны айлчлалыг ажлын 2-3 хоногт багтаан хэрэгжүүлнэ.

48.1.5. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад албан ёсны айлчлал хийхэд Монгол Улсын Засгийн газрын гишүүн сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд байнга дагалдан явна. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/-г Элчин сайдын гэргий /нөхөр/ байнга дагалдан явна.

48.1.6. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад албан ёсны айлчлал хийхэд дараах газруудад Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбааг мандуулна:

- Чингисийн талбай;
- Сүхбаатарын гудамж;
- Энхтайваны гүүр;
- “Чингис хаан” нисэх буудал;
- Хүндэтгэлийн зоог барих байр;
- Байрлах өргөө, зочид буудал;
- Хөлөглөх машин;
- Төрийн ордны ёслол, хүндэтгэлийн Их танхим;
- Төрийн ордны “Баганат” танхим;
- Албан ёсны хэлэлцээний танхим;
- Бараалхах уулзалт хийх танхим;
- Хүндэтгэлийн зоог барих танхим;
- Албан ёсны хэлэлцээний ширээ;
- Баримт бичигт гарын үсэг зурах ширээ.

48.1.7. Нисэх буудалд угтах ёслол

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн онцгой үүргийн болон хуваарьт нислэгээр ирж байгаа бол угтах ёслолыг нислэгийн талбайд үйлдэнэ. Шаардлагатай тохиолдолд олон улсын нисэх буудлын байранд хийнэ.

-Онгоцны шат, онгоцноос машин хүртэлх зам дагуу улаан хивс дэвсэнэ.

-Хүндэт харуулын нэг салаа 25 цэрэг улаан хивсний хоёр талаар жагссан байна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсны айлчлал хийхээр ирэхэд Монгол Улсын Гадаад хэргийн сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд нар нисэх буудалд угтана. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн гэргий /нөхөр/-н хамт айлчилбал Гадаад хэргийн сайдын гэргий /нөхөр/, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд гэргий /нөхөр/-н хамт угтана. Гадаад хэргийн сайд эзгүй тохиолдолд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг айлчлалын хугацаанд дагалдах Засгийн газрын гишүүн-сайд угтана.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсны айлчлалаар ирэхэд нисэх буудалд хийх угтах ёслолд тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдыг урьж оролцуулна. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн гэргий /нөхөр/-н хамт айлчилбал Элчин сайдын гэргий /нөхөр/-г угтах ёслолд урьж оролцуулна.

-Онгоц зогсоолд ирж зогсон хаалгаа нээхэд Ёслолын газрын захирал, тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд нар онгоцонд орж Засгийн газрын тэргүүн, түүний гэргий /нөхөр/-г Монгол Улсад тавтай зочлохыг ерөөж, онгоцноос урьж буулгана.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий онгоцноос бууж ирэхэд монгол үндэсний хувцастай бүсгүй, залуу мөнгөн аягатай ааруул, хадаг өргөн барьж угтан мэндчилнэ.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий /нөхөр/ Монголын талаас албан ёсоор угтаж байгаа Гадаад хэргийн сайд, түүний гэргийтэй мэндчилнэ.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, Монгол Улсын Гадаад хэргийн сайд нар Хүндэт харуулын цэргүүдийн дундуур улаан хивсэн дээгүүр явж, монголын талаас албан ёсоор угтаж буй бусад төлөөлөгчид рүү очно. Гэргий нар болон гадаад орны засгийн газрын тэргүүн нарыг дагалдан яваа албаны төлөөлөгчид дагалдан явна.

-Монголын талын албаны хүмүүсийг Ёслолын газрын захирал гадаад улсын Засгийн газрын тэргүүнд танилцуулна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, Монгол Улсын Гадаад хэргийн сайд нар хамт нэг машинд сууж явна. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/, Монгол Улсын Гадаад хэргийн сайдын гэргий /нөхөр/ нар хамт нэг машинд сууж явна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн байрлах өргөө, зочид буудалд хүрэлцэн ирэхэд өргөөний болон зочид буудлын удирдлага улаан хивс дэвсэж, цэцгийн баглаа барьж угтана. Монгол Улсын Гадаад хэргийн сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг байрлах өргөөнд нь хүргэж өгөөд буцна. Ёслолын газрын захирал хүндэт зочныг өрөөнд нь оруулж өгнө.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргийн байрлах өргөөнд Монгол Улсын Ерөнхий сайд, түүний гэргий нараас дурсгасан цэцгийн баглаа тавьсан байна.

48.1.8. Чингисийн талбайд албан ёсоор угтах ёслол

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсны айлчлал хийхээр Монгол Улсад ирэхэд албан ёсоор угтах ёслолыг Чингисийн талбайд үйлдэнэ.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүний хөлөглөсөн машин зогсох, Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар анх уулзаж, мэндчилэх зэрэг газарт тус тус хивс дэвсэнэ. Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар хүндэт харуулын даргын айлтгалыг хүлээн авч, хоёр орны төрийн дууллыг хүндэтгэн сонсох газарт 3м х 2м хэмжээтэй хүндэтгэлийн тавцан байрлуулсан байна. Засгийн газрын тэргүүн нарын гэргий /нөхөр/ нарт зориулан хүндэтгэлийн тавцангийн баруун талд хивс дэвсэнэ. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний хөлөглөсөн машин зогсох газраас эхлэн Төрийн ордонд орох хүртэлх угтах ёслол үйлдэх бүх замын дагуу улаан хивс дэвсэнэ.

-Хүндэт харуулын 25 цэрэг бүхий хоёр салаа нийт 55 цэрэг Чингисийн талбайн төв хэсэгт Төрийн ордон руу харан хоёр эгнээгээр жагссан байна. Хүндэт харуулын жагсаалын тэргүүнд Төрийн ёслолын цэргийн цагаан тугийг залсан байна.

-Төрийн ордны өмнө Хүндэт харуулын 24 морьт цэрэг өмнө зүг харан жагссан байна.

-Үлгэр жишээ Үлээвэр найрал хөгжим Чингисийн талбайд Хүндэт харуулын баруун гар талд Төрийн ордон руу харан жагссан байна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүний хийж буй албан ёсны айлчлалын угтах ёслолд монголын талаас дараах албан тушаалтан оролцоно. Үүнд:

- Гадаад хэргийн сайд;
- Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд;
- Хэлэлцээнд оролцох Засгийн газрын гишүүд, сайд нар;

- Улаанбаатар хотын захирагч бөгөөд Нийслэлийн Засаг дарга;
- Ерөнхий сайдын гадаад бодлогын зөвлөх;
- Ерөнхий сайдын хэвлэл, мэдээллийн төлөөлөгч;
- Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал зэрэг болно.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн гэргий /нөхөр/-н хамт айлчилж байгаа бол Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий, гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/ нар албан ёсоор угтах ёслолд оролцоно.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүний хийж буй төрийн айлчлалын угтах ёслолд Монгол Улсад суугаа Дипломат корпусыг урьж оролцуулна.

-Албан ёсоор угтах ёслолд монголын талаас оролцох албан тушаалтнууд Чингисийн талбайд ёслол эхлэхээс 10 минутын өмнө ирсэн байх бөгөөд Хүндэт харуулын зүүн гар талд Соёлын төв өргөө рүү харан баруун гар талаасаа ёслолын ахлалаар нэг эгнээгээр зогсоно.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчид албан ёсоор угтах ёслол эхлэхээс 10 минутын өмнө Чингисийн талбайд урьдчилан ирсэн байх бөгөөд монголын талын албаны хүмүүсийн дараа баруун гар талаасаа ёслолын ахлалаар Соёлын төв өргөө рүү харан нэг эгнээгээр зогсоно.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчдийн дараа тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дипломат ажилтнууд баруун гар талаасаа ёслолын ахлалаар Соёлын төв өргөө рүү харан нэг эгнээгээр зогсоно.

-Монгол Улсын Ерөнхий сайд, түүний гэргий албан ёсоор угтах ёслол эхлэхээс 5 минутын өмнө Чингисийн талбайд ирнэ. Төрийн ёслолын албаны дарга тэднийг угтан мэндчилж, тусгайлан зассан хүндэтгэлийн тавцан руу залж ирүүлнэ. Монгол Улсын Ерөнхий сайд хүндэтгэлийн тавцан дээр хойд талаас нь гарч зогсоход хүндэт харуулын дарга жагсаалын алхаагаар угтан очиж “Монгол Улсын Ерөнхий сайд Танаа, Төрийн хүндэт харуул бэлэн болсныг айлтгая. Хүндэт харуулын дарга” гэж цэргийн цол, овог нэрээ хэлж айлтгал өргөнө. Монгол Улсын Ерөнхий сайд Хүндэт харуултай мэндэлсэн тохиолдолд “Хүндэт Ерөнхий сайдын амрыг эрье” хэмээн мэндэлнэ. Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий энэ үед хүндэтгэлийн тавцангийн баруун талд зассан хивсэн дээр зогсож байна. Айлтгал дууссаны дараа гэргий Ерөнхий сайдыг дагалдан гадаад улсын Засгийн

газрын тэргүүн, түүний гэргий /нөхөр/-г угтах хивснээс хэдэн алхмын наана улаан хивсэн дээр очиж зогсоно.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий нар нэг машинд хамт суух бөгөөд Засгийн газрын тэргүүн машины баруун хойд талын суудалд, түүний гэргий машины зүүн хойд талын суудалд тус тус сууна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүний хөлөглөсөн машин Чингисийн талбайд ирэхэд Үлээвэр найрал хөгжим “Угтах ая” эгшиглүүлж байна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүний хөлөглөсөн машин товлосон газарт зогсоход Төрийн ордны хамгаалалтын албаны хоёр ажилтан машины хоёр талын хойд хаалгыг зэрэг нээн өгч ёсолно.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нар машинаас бууж Монгол Улсын Ерөнхий сайд, түүний гэргийн зүг алхахад Монгол Улсын Ерөнхий сайд, түүний гэргий нар угтан алхаж, хивсний төвд уулзан гар барьж мэндчилнэ. Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий Ерөнхий сайдын баруун гар талд явна. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/ Засгийн газрын тэргүүний баруун гар талд явна. Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй мэндчилээд дараа нь түүний гэргий /нөхөр/-тэй мэндчилнэ. Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй мэндчилээд дараа нь түүний гэргий /нөхөр/-тэй мэндчилнэ.

-Харилцан мэндчилсний дараа монгол үндэсний хувцастай эрэгтэй, эмэгтэй хоёр хүүхэд гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргийд цэцгийн баглаа өргөн барина.

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар гэргий /нөхөр/ нарын хамт дурсгалын гэрэл зураг авахуулна. Баруун гар талаас Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий, гадаад улсын Засгийн газрын тэргүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/ гэсэн дарааллаар эгнэн зогсоно. Хүүхдүүд эхний эгнээнд зогсоно.

-Дурсгалын гэрэл зураг авахуулсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг баруун гар талдаа авч улаан хивсэн дээгүүр тавцангийн зүг явна. Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/-г баруун гар талдаа аван Ерөнхий сайд, Засгийн газрын тэргүүн нарын араас хоёр алхмын зайд араас нь даган явна.

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар хүндэтгэлийн тавцангийн хойд талаас гарч хүндэт харуулын зүг харан зогсоно. Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг баруун гар талдаа авч зогсоно.

-Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/-г баруун гар талдаа авч дагуулан явж, хүндэтгэлийн тавцангийн баруун талд зассан хивсэн дээр зогсоно. Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/-г зүүн гар талдаа авч зогсоно.

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар хүндэтгэлийн тавцан дээр хойд талаас нь гарч зогсоход хүндэт харуулын дарга жагсаалын алхаагаар алхан угтан очиж, “Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа/улсын нэр/ .. улсын/албан ёсны дуудлага/ Таныг хүндэтгэн Монгол Улсын Төрийн хүндэт харуул жагссан. Хүндэт харуулын дарга/цэргийн цол, нэр овог/” гэж айлтгал өргөөд байрандаа баруун гар тийш эргэж Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нарын зүг хараа шилжүүлэн зогсоход Үлээвэр найрал хөгжим эхлээд тухайн улсын, дараа нь Монгол Улсын Төрийн дуулалыг тус тус эгшиглүүлнэ.

-Төрийн дуулал эгшиглэж дуусахад Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар хүндэтгэлийн тавцангаас урагш бууж, Хүндэт харуулын жагсаалын тэргүүнд залсан Төрийн ёслолын цэргийн цагаан тугны зүг улаан хивсэн дээгүүр явна. Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг баруун гар талдаа авч явна. Хүндэт харуулын дарга гурван алхамын зайд жагсаалын алхаагаар дагалдан явна. Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар Төрийн ёслолын цэргийн цагаан тугны өмнө очиж түүнд толгой мэхийн хүндэтгэл илэрхийлнэ. Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг баруун гар талдаа авч зогсоно.

-Төрийн ёслолын цэргийн цагаан туганд хүндэтгэл илэрхийлсний дараа Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг зүүн гар талдаа авч яван хүндэт харуулын жагсаалын өмнүүр алхана. Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар Хүндэт харуулын жагсаалыг голлон хүндэт харуулын зүг харан зогсоно. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн хүндэт харуулын цэргүүдтэй “Цэргүүд ээ, сайн байцгаана уу” гэж төрөлх хэл дээрээ мэндэлнэ. Хүндэт харуулын цэргүүд “Хүндэт Ерөнхий сайдын амрыг эрье” хэмээн хариу мэндэлнэ. Энэ үед Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүний баруун хойд талд нэг алхам зайтай зогсож байна.

-Хүндэт харуулын цэргүүд хариу мэндэлсний дараа Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг зүүн гар талдаа авч Хүндэт харуулын жагсаалын төгсгөл хүртэл явна. Хүндэт харуулын дарга эргэж, жагсаалын алхаагаар алхан жагсаалыг голлон зогсоно.

-Ерөнхий сайд, Засгийн газрын тэргүүн нар албан ёсоор угтах ёслолд оролцож буй албаны хүмүүсийн зүг явна. Энэ үед Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий, гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/ тэдэнтэй нийлнэ.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсоор угтах ёслолд оролцож буй монголын талын албаны хүмүүстэй гар барьж мэндэлнэ. Монгол Улсын Ерөнхий сайд монголын талын албаны хүмүүсийг танилцуулна.

-Монгол Улсын Ерөнхий сайд албан ёсоор угтах ёслолд оролцож буй гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчидтэй гар барьж мэндэлнэ. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсны төлөөлөгчдөө танилцуулна.

-Тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дипломат ажилтнуудтай Монгол Улсын Ерөнхий сайд, төрийн тэргүүн нар гар барьж

мэндэлнэ. Тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд дипломат ажилтнуудаа танилцуулна.

48.1.9. Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслол

-Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэх ёслолыг Чингисийн талбайд хийсэн албан ёсоор угтах ёслолын дараа үйлдэнэ.

-Их эзэн Чингис хааны хөшөөний хоёр талд болон шатны дагуу Хүндэт харуулын 16 цэрэг жагссан байна.

-Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө том хивс, шатны дагуу улаан хивс дэвсэнэ.

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг баруун гар талдаа авч шатаар өгсөнө. Түүний араас 2 алхамын зайд Ерөнхий сайдын гэргий /нөхөр/ гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/-г баруун гар талдаа аван шатаар өгсөнө. Гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг дагалдан яваа албан ёсны төлөөлөгчид тав, таваараа нэг эгнээ болон шатаар өгсөнө.

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн, гэргий /нөхөр/ нар, албан ёсны төлөөлөгчид Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө дэвссэн хивсэн дээр очиж зогсоод, толгой бөхийн хүндэтгэл илэрхийлнэ.

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн, гэргий /нөхөр/ нар хүндэтгэл илэрхийлсний дараа хөшөөний баруун талын хаалгаар Төрийн ордонд, дагалдан яваа албан ёсны төлөөлөгчид хөшөөний зүүн талын хаалгаар орно.

48.1.10. Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслол

-Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлсний дараа Монгол Улсын Ерөнхий сайд, гэргий нар гадаад улсын Засгийн газрын тэргүүн, гэргий нарын хамт Төрийн ордны “Баганат” танхимд орж ирнэ.

-“Баганат” танхимд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа мандуулсан байна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслолын ширээ, сандлыг бэлтгэж, Хүндэт зочны дэвтэр, үзэг бэлтгэсэн байна. Ширээг амьд цэцгээр чимэглэсэн байна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурж байхад түүний гэргий, Монгол Улсын Ерөнхий сайд, түүний гэргий нар ширээний ард зогсож байна. Албан ёсны төлөөлөгчид уулзалт, хэлэлцээний танхим руу явж байна.

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад орны Засгийн газрын тэргүүн нар гэргий /нөхөр/ нарын хамт дурсгалын гэрэл зураг авахуулна. Баруун гар талаас Монгол Улсын Ерөнхий сайдын гэргий, гадаад улсын Засгийн газрын тэргүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүний гэргий /нөхөр/ гэсэн дарааллаар эгнэн зогсоно.

-Хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурах ёслол өндөрлөсний дараа гэргий нар тусдаа ёслолын уулзалт хийх, эсхүл тусгай хөтөлбөрийн дагуу явна.

48.1.11. Ганцаарчилсан уулзалт

-Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар ганцаарчилсан уулзалт хийнэ. Ганцаарчилсан уулзалтыг Төрийн ёслол хүндэтгэлийн уулзалтын “А” танхимд хийнэ.

-Уулзалтын танхимын хойморт Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг баруун гар талдаа аван сууна. Уулзалтад оролцох монголын талын албаны хүмүүс зүүн талын суудлуудад, гадаадын төлөөлөгчид баруун талын суудлуудад тус тус сууна.

-Ганцаарчилсан уулзалтад тал бүрээс албан ёсны 4 төлөөлөгч, албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөгч тус тус оролцоно. Ганцаарчилсан уулзалт 15 минут орчим үргэлжилнэ.

-Ганцаарчилсан уулзалтад оролцогсдыг цай, цагаан идээ, төрөл бүрийн ундаагаар дайлна.

48.1.12. Бараалхах уулзалт

-Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын даргад тус тус бараалхуулна. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг Төрийн ёслол хүндэтгэлийн гэр өргөөнд хүлээн авч уулзана. Төрийн ёслол хүндэтгэлийн гэр өргөөнд болон бараалхах уулзалт хийх танхимд Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан байна.

-Монгол Улсын Засгийн газрын гишүүн-сайд Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй гадаад улсын Засгийн газрын тэргүүнд бараалхаж болно. Бараалхах уулзалтыг гадаад улсын Засгийн газрын тэргүүн байрласан байранд очиж хийнэ. Гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй бараалхах уулзалт хийх танхимд тухайн улсын Төрийн далбааг мандуулсан байна.

-Бараалхах уулзалтад албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөх хүн байлцана.

48.1.13. Албан ёсны хэлэлцээ

-Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улс Засгийн газрын тэргүүнтэй албан ёсны хэлэлцээ хийнэ. Хэлэлцээг Төрийн ордны хэлэлцээний танхимд явуулна. Хэлэлцээний ширээнд Монгол Улсын болон тухай улсын Төрийн далбаа

мандуулж, хэлэлцээнд оролцогсдын нэрс, микрофон, бичгийн хэрэгсэл /дэвтэр, үзэг/, цэвэр ус, ундаа зэргийг тавина.

-Хэлэлцээнд танхимын цонхон талд монголын талын төлөөлөгчид, эсрэг талд нөгөө талын төлөөлөгчид сууна. Хоёр талын зөвлөх, мэргэжилтэн нар арын эгнээнд сууна. Хэлэлцээнд албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөх хүн байна.

-Хэлэлцээний аудио бичлэгийг хийнэ.

-Хэлэлцээний үеэр цай, кофе зэрэг халуун ундаагаар үйлчилнэ.

48.1.14. Баримт бичигт гарын үзэг зурах ёслол

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүний айлчлалын үеэр болох баримт бичигт гарын үсэг зурах ёслолыг Төрийн ёслол, хүндэтгэлийн Их танхимд зохион байгуулна. Баримт бичигт гарын үсэг зурах ёслолд Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар оролцоно. Баримт бичигт гарын үсэг зурах ширээнээ баруун гар талд тухайн улсын, зүүн гар талд Монгол Улсын Төрийн далбаа, гарын үсэг зурах хос үзэг, бэх дарагч, баримт бичиг зэргийг тавьсан байна.

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар баримт бичигт гарын үсэг зурах ширээний суудлын хойно зогсоно. Монгол Улсын Ерөнхий сайд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг баруун гар талдаа авч зогсоно. Ёслолд оролцох монголын талын албаны хүмүүс танхимын зүүн талд баруун гар талаасаа ёслолын ахлалаар танхимын гол руу харан зогсоно. Ёслолд оролцох нөгөө талын албаны хүмүүс танхимын баруун талд зүүн гар талаасаа ёслолын ахлалаар танхимын гол руу харан зогсоно.

-Баримт бичигт гарын үсэг зурахын өмнө баримт бичгийн болон түүнд гарын үсэг зурах хүний албан тушаал, нэр овгийг монгол хэлээр болон тухайн орны эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан ёсны аль нэг хэлээр зарлана. Баримт бичгийг Гадаад хэргийн яамны Олон улсын эрх зүйн газрын дипломат ажилтан түшнэ. Баримт бичигт гарын үсэг зурсан хүмүүс баримт бичгээ харилцан солилцож, гар барина. Дараа нь Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нартай гар барина. Ёслолд оролцогчид алга ташиж баяр хүргэнэ. Баримт бичигт гарын үсэг зурж дуусмагц, хундага өргөнө.

48.1.15. Хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийх

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар уулзалт, хэлэлцээний дүнгийн талаар хоёр талын болон олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийж болно. Энэ талаар хоёр тал дипломат шугамаар урьдчилан тохирсон байна.

-Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд хийх мэдээллийг Төрийн ёслол, хүндэтгэлийн Их танхимд зохион байгуулна.

-Хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийх танхимд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа мандуулсан байна.

-Эхлээд Монгол Улсын Ерөнхий сайд, дараа нь гадаад улсын Засгийн газрын тэргүүн мэдээлэл хийнэ. Хоёр тал урьдчилан тохиролцсоны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдийн асуултад хариулна.

-Гадаад хэргийн яамны хэвлэлийн төлөөлөгч арга хэмжээг хөтлөн явуулна. Мэдээллийг хоёр талын албан ёсны хэлмэрч орчуулна. Тэмдэглэл хөтөлж, аудио бичлэг хийнэ.

48.1.16. Хүндэтгэлийн зоог

-Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий /нөхөр/-г хүндэтгэн Монгол Улсын Ерөнхий сайд, түүний гэргий зоог барина. Хүндэтгэлийн зоогийг албан ёсоор угтах ёслол, хэлэлцээ явагдсан өдрийн орой зохион байгуулна.

-Зоог барих байрны үүдэнд Хүндэт харуул, байр уруу очих зам дагуу морьтой Хүндэт харуул байрласан байна.

-Зоогт уригдсан хүмүүс албан ёсны, цэргийн ёслол амралтын болон үндэсний хувцастай байна.

-Зоогт уригдсан хүмүүс зоог эхлэхээс 15 минутын өмнө ирсэн байна. Тэдэнд дарс, төрөл бүрийн ундаагаар аперитив барина.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн гэргийн хамт хүндэтгэлийн зоогт ирэхэд Монгол Улсын Ерөнхий сайд, гэргийн хамт угтан авна.

-Ерөнхий сайд, гэргий нар зоогийн эхэнд тусгай танхимд түр саатаж, аперитив барина. Цаг агаар тааламжтай үед зоогийн эхэнд гадаадын төлөөлөгчдөд монгол ахуйг харуулсан үзвэр үзүүлж, монгол гэрт зочлуулж болно.

-Ёслолын газрын захирал зоогт уригдсан зочин талын дараа нь монголын талын төлөөлөгчдийг Ерөнхий сайд, гэргий, гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нарт дуудаж танилцуулна. Зоогт уригдагсад Ерөнхий сайд, Ерөнхий сайдын гэргий, гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий /нөхөр/ нартай гар барьж мэндчилэн, зоогийн танхимд орж хуваарьт суудлын ард зогсож хүлээнэ.

-Мэндчилгээ өндөрлөж Ерөнхий сайд, Засгийн газрын тэргүүн нар гэргий /нөхөр/-н хамт зоогийн танхимд орж үндсэн ширээнд хуваарьт суудлынхаа ард зогсоход Үлээвэр найрал хөгжим эхлээд тухайн улсын, дараа нь Монгол Улсын Төрийн дуулалыг тус тус эгшиглүүлнэ. Зоогт уригдагсад зогсож хүндэтгэнэ.

-Төрийн дуулал эгшиглэж дууссаны дараа зоогт уригдагсад суудлаа эзэлнэ. Эхлээд Монгол Улсын Ерөнхий сайд үг хэлж, хундага өргөнө. Дараа нь гадаад улсын Засгийн газрын тэргүүн үг хэлж, хундага өргөнө. Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нарын хэлэх үгийг орчуулан ширээн дээр урьдчилан тавьсан байна.

-Ширээн дээр кувертийн хуудас, зоогийн цэс, урлагийн тоглолтын хөтөлбөр байна. Зоогийн үеэр мэргэжлийн урлагийн хамтлаг үндэсний болон сонгодог дуу, хөгжмийн бүтээлээс тоглоно.

-Зоогийн төгсгөл цайны хэсгийг монгол гэрт барихаар зохион байгуулж болно.

-Зоог өндөрлөхөд Монгол Улсын Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар суудлаасаа эхэлж босно. Бусад хүмүүс дараа нь босно.

-Ерөнхий сайд, гадаад улсын Засгийн газрын тэргүүн нар бэлэг дурсгалын зүйлс өөрсдөө солилцохоор хоёр тал урьдчилан тохирсон бол энэ ёслолыг хүндэтгэлийн зоогийн төгсгөлд тусгай танхимд, эсхүл монгол гэрт хийнэ.

-Монгол Улсын Ерөнхий сайд гэргийн хамт гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий /нөхөр/-г зоог барьсан өргөөний үүдэнд үдэж өгнө.

48.1.18. Орон нутагт зочлох

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсны айлчлал хийхдээ Монгол Улсын орон нутагт зочилж болно.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн орон нутагт зочлоход Засгийн газрын гишүүн-сайд дагалдан явна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн орон нутагт очих, буцахад нь тухайн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар угтаж, үднэ.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн орон нутагт зочлох хөтөлбөрт малчин айлд зочлох, үйлдвэр, аж ахуйн газартай танилцах, эрдэм шинжилгээний байгууллагад зочлох, соёл, спортын арга хэмжээ сонирхох зэрэг арга хэмжээг тусгана.

48.1.19. Нисэх буудалд үдэх ёслол

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн онцгой үүргийн болон хуваарьт нислэгээр буцаж байгаа бол үдэх ёслолыг нислэгийн талбайд үйлдэнэ. Шаардлагатай тохиолдолд олон улсын нисэх буудлын байранд хийнэ.

-Онгоцны шат, машинаас онгоцны шат хүртэлх зам дагуу улаан хивс дэвсэнэ.

-Хүндэт харуулын нэг салаа 25 цэрэг улаан хивсний хоёр талаар жагссан байна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсны айлчлал хийгээд буцахад Монгол Улсын Гадаад хэргийн сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд нар нисэх буудалд үднэ. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн гэргийн хамт айлчилсан бол Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайдын гэргий хамт үднэ. Гадаад хэргийн сайд эзгүй тохиолдолд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг айлчлалын хугацаанд дагалдах Засгийн газрын гишүүн-сайд үднэ.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсны айлчлал хийгээд буцахад нисэх буудалд үдэх ёслолд тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдыг урьж оролцуулна. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн гэргийн хамт айлчилсан бол Элчин сайдын гэргийг үдэх ёслолд урьж оролцуулна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүний байрласан өргөө, зочид буудлын удирдлага улаан хивс дэвсэж, амьд цэцгийн баглаа барьж үдэж өгнө.

-Монгол Улсын Гадаад хэргийн сайд гэргийн хамт гадаад улсын Засгийн газрын тэргүүний байрласан өргөө, зочид буудалд очиж, нисэх буудал руу хамт явна. Гадаад хэргийн сайд Засгийн газрын тэргүүнтэй хамт нэг машинд, гэргий нар хамт нэг машинд сууж явна.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий нар албан ёсоор үдэж буй монголын талын төлөөлөгчидтэй гар барьж салах ёслол хийгээд, цааш Хүндэт харуулын цэргүүдийн дундуур алхаж өнгөрнө.

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий нарт монгол үндэсний хувцастай бүсгүй, залуу амьд цэцгийн баглаа барина

-Гадаад улсын Засгийн газрын тэргүүн, түүний гэргий нар албан ёсоор үдэж буй Монгол Улсын Гадаад хэргийн сайд, түүний гэргийтэй онгоцны шатны дэргэд гар барьж, салах ёс гүйцэтгэнэ.

48.2. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний ажлын айлчлал

48.2.1. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсын Ерөнхий сайдын урилгын дагуу тус улсад ажлын айлчлал хийнэ.

48.2.2. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад хийх ажлын айлчлалыг ажлын 2 хоногт багтаан хэрэгжүүлнэ.

48.2.3. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад хийх ажлын айлчлалаа орон нутгаас эхлэн хэрэгжүүлж болно.

48.2.4. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад ажлын айлчлал хийхэд Гадаад хэргийн дэд сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд байнга дагалдан явна.

48.2.5. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний ажлын айлчлалд нисэх буудалд угтах, үдэх ёслол, ажлын уулзалт, баримт бичигт гарын үсэг зурах ёслол, хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийх, ажлын зоог зэрэг үндсэн арга хэмжээг багтаана.

48.2.6. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн ажлын айлчлалаар ирэх, буцахад Гадаад хэргийн дэд сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд нар нисэх буудалд угтаж, үднэ.

48.2.7. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад ажлын айлчлал хийхэд Чингисийн талбайд албан ёсоор угтах ёслол үйлдэхгүй.

48.2.8. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад ажлын айлчлал хийхэд нисэх буудал, хөлөглөх машин, байрлах байранд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа мандуулна.

48.2.9. Монгол Улсад ажлын айлчлал хийж буй гадаад улсын Засгийн газрын тэргүүнд Монгол Улсын Ерөнхий сайд ажлын зоог барина. Зоогийн эхэнд товч үг хэлнэ. Төрийн дуулал эгшиглүүлэхгүй.

48.2.10. Монгол Улсад ажлын айлчлал хийж буй гадаад улсын Засгийн газрын тэргүүнд Монгол Улсын Ерөнхий сайд бэлэг дурсгалын зүйл өгч болно.

48.3. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний хувийн айлчлал

48.3.1. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад хувийн айлчлалаар ирэх, буцахад Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нисэх буудалд угтаж, үднэ.

48.3.2. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсад хувийн айлчлал хийхэд хөлөглөх машин, байрлах байранд тухайн улсын Төрийн далбаа мандуулна.

48.3.3. Монгол Улсад хувийн айлчлал хийж буй гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй Монгол Улсын Ерөнхий сайд уулзаж, зоог барьж, бэлэг, дурсгалын зүйл өгч болно.

48.4. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн дамжин өнгөрөх

48.4.1. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын гишүүн-сайд нисэх буудалд очиж хүндэтгэл үзүүлнэ.

49. Гадаад улсын Дэд ерөнхийлөгчийн айлчлал

49.1. Гадаад улсын Дэд ерөнхийлөгчийн Монгол Улсад хийх айлчлалыг өндөр түвшний айлчлалд хамааруулна.

49.2. Гадаад улсын Дэд ерөнхийлөгчийг тухай улсын улс төрийн байгууламжийг харгалзан Монгол Улсын Улсын Их Хурлын даргын, эсхүл Монгол Улсын Ерөнхий сайдын урилгаар айлчлуулна.

49.3. Гадаад улсын Дэд ерөнхийлөгчийг Монгол Улсад хүлээн авч айлчлуулахдаа гадаад улсын парламентын даргад үзүүлэх ёслол, хүндэтгэлийг үзүүлнэ.

49.4. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын Дэд Ерөнхийлөгчийг Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнд хүлээн авч, ёслолын уулзалт хийнэ.

49.5. Гадаад улсын Дэд Ерөнхийлөгчтэй Монгол Улсын Их Хурлын дарга эсхүл Ерөнхий сайд уулзалт, хэлэлцээ хийж, хүндэтгэн зоог барина.

49.6. Монгол Улсын Засгийн газрын гишүүн гадаад улсын Дэд Ерөнхийлөгчид очиж бараалхаж болно.

49.7. Гадаад улсын Дэд ерөнхийлөгчийг нисэх буудалд Монгол Улсын Засгийн газрын гишүүн-сайд угтаж, үднэ.

49.7. Гадаад улсын Дэд Ерөнхийлөгч Монгол Улсад албан ёсны айлчлал хийхэд Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд байнга дагалдана.

50. Гадаад улсын Гадаад хэргийн сайдын айлчлал

50.1. Гадаад улсын Гадаад хэргийн сайдын Монгол Улсад хийх айлчлалыг өндөр түвшний айлчлалд хамааруулна.

50.2. Монгол Улсын Гадаад хэргийн сайдын урилгаар гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсад айлчилна.

50.3. Гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсад хийх айлчлалыг албан ёсны, ажлын, хувийн гэж ангилна.

50.4. Гадаад улсын Гадаад хэргийн сайдын албан ёсны айлчлал

50.4.1. Гадаад улсын Гадаад хэргийн сайдын албан ёсны айлчлалд нисэх буудалд угтах, үдэх ёслол, ганцаарчилсан уулзалт, бараалхах уулзалт, албан ёсны хэлэлцээ, баримт бичигт гарын үсэг зурах ёслол, хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийх, хүндэтгэлийн зоог зэрэг үндсэн арга хэмжээг багтаана.

50.4.2. Гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсад хийх албан ёсны айлчлалыг ажлын 2 хоногт багтаан хэрэгжүүлнэ.

50.4.3. Гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсад айлчлах хугацаанд Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд байнга дагалдана. Гадаад хэргийн сайд гэргий /нөхөр/-тэйгээ айлчилбал түүний гэргий /нөхөр/-г Элчин сайдын гэргий /нөхөр/ байнга дагалдан явна.

50.4.4. Нисэх буудалд угтах, үдэх ёслол

-Нисэх буудалд Монгол Улсын Төрийн далбааг тухайн улсын Төрийн далбааны зүүн талд мандуулна.

-Онгоцны шат, онгоцноос машин хүртэлх зам дагуу улаан хивс дэвсэнэ.

-Гадаад улсын Гадаад хэргийн сайд онцгой үүргийн болон хуваарьт нислэгээр ирээд, буцаж байгаа бол угтах, үдэх ёслолыг нислэгийн талбайд үйлдэнэ. Шаардлагатай тохиолдолд олон улсын нисэх буудлын байранд хийнэ.

-Гадаад улсын Гадаад хэргийн сайд албан ёсны айлчлалаар ирэх, буцахад Гадаад хэргийн дэд сайд, Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайд нар нисэх онгоцны буудалд угтаж, үднэ.

-Гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсад албан ёсны айлчлал хийхээр ирэх, буцахад нисэх буудалд угтах, үдэх ёслолд тухайн улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдыг урьж оролцуулна.

-Гадаад улсын Гадаад хэргийн сайд онгоцноос бууж ирэхэд түүнд монгол үндэсний хувцастай бүсгүй мөнгөн аягатай ааруул, хадаг өргөн барьж угтан мэндчилнэ.

-Гадаад хэргийн сайд байрлах өргөө, зочид буудлын удирдлага улаан хивс дэвсэж, амьд цэцгийн баглаа барьж угтаж, үднэ.

50.4.5. Гадаад хэргийн яаманд угтах

-Ёслолын газрын захирал гадаад улсын Гадаад хэргийн сайдыг байрласан өргөө, зочид буудлаас Гадаад хэргийн яаманд авч ирнэ.

-Гадаад хэргийн яамны ёслолын хаалганы баруун талын баганад Монгол Улсын, зүүн талын баганад тухайн улсын Төрийн далбааг мандуулсан байна.

-Монгол Улсын Гадаад хэргийн сайд гадаад улсын Гадаад хэргийн сайдтай мэндчилж, дурсгалын гэрэл зураг авахуулна.

50.4.6. Ганцаарчилсан уулзалт

-Монгол Улсын Гадаад хэргийн сайд гадаад улсын Гадаад хэргийн сайдтай ганцаарчилсан уулзалт хийж болно. Ганцаарчилсан уулзалтад хоёр талаас тус бүр 2 төлөөлөгч, хоёр талын хэлмэрч, тэмдэглэл хөтлөх ажилтан байлцана.

-Ганцаарчилсан уулзалт хийх танхимд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбааг мандуулна.

50.4.7. Албан ёсны хэлэлцээ

-Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсын Гадаад хэргийн сайдтай хэлэлцээ хийнэ.

-Хэлэлцээний ширээнд Монгол Улсын болон тухай улсын Төрийн далбааг мандуулж, хэлэлцээнд оролцогсдын нэрс, микрофон, бичгийн хэрэгсэл /дэвтэр, үзэг/, цэвэр ус, ундаа зэргийг тавина.

-Хэлэлцээний танхимын цонхон талд монголын талын төлөөлөгчид, эсрэг талд зочин талын төлөөлөгчид сууна. Хэлэлцээнд албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөгч нар байна.

-Хэлэлцээний үеэр цай, кофе зэрэг халуун ундаагаар үйлчилнэ.

50.4.8. Баримт бичигт гарын үсэг зурах ёслол

-Баримт бичигт гарын үсэг зурах ёслол үйлдэх танхимд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа байрлуулна.

-Баримт бичигт гарын үсэг зурах ширээний баруун гар талд тухайн улсын, зүүн гар талд Монгол Улсын төрийн далбаа тус тус мандуулж, гарын үсэг зурах хос үзэг, бэх дарагч, баримт бичиг зэргийг тавьсан байна.

-Баримт бичигт гарын үсэг зурахын өмнө баримт бичгийн болон түүнд гарын үсэг зурах хүний албан тушаал, овог нэрийг монгол хэлээр болон тухайн орны эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан ёсны аль нэг хэлээр зарлана. Баримт бичгийг Гадаад хэргийн яамны Олон улсын эрх зүйн газрын дипломат ажилтан түшнэ. Баримт бичигт гарын үсэг зурсан хүмүүс суудлаасаа босч, баримт бичгээ харилцан солилцож, гар барина. Баримт бичигт гарын үсэг зурж дуусмагц, хундага өргөнө.

50.4.9. Хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийх

-Монгол Улсын Гадаад хэргийн сайд, гадаад улсын Гадаад хэргийн сайд нар уулзалт, хэлэлцээний дүнгийн талаар хоёр талын болон олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийж болно. Энэ талаар хоёр тал урьдчилан тохирсон байна.

-Хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийх танхимд Монгол Улсын болон тухайн улсын Төрийн далбаа байрлуулна.

-Эхлээд Монгол Улсын Гадаад хэргийн сайд дараа нь гадаад улсын Гадаад хэргийн сайд мэдээлэл хийнэ. Хоёр тал урьдчилсан тохиролцсоны дагуу Монгол Улсын Гадаад хэргийн сайд, гадаад улсын Гадаад хэргийн сайд нар хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдийн асуултад хариулна.

-Гадаад хэргийн яамны хэвлэлийн төлөөлөгч арга хэмжээг хөтлөн явуулна. Мэдээллийг хоёр талын албан ёсны хэлмэрч орчуулна. Тэмдэглэл хөтөлж, аудио бичлэг хийнэ.

50.4.10. Бараалхах уулзалт

-Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй гадаад улсын Гадаад хэргийн сайдыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарт бараалхуулж болно.

-Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсын Засгийн газрын гишүүдтэй ажлын уулзалт хийж болно.

-Бараалхах уулзалтад албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөх ажилтан байлцана.

50.4.11. Хүндэтгэлийн зоог

-Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа гадаад улсын Гадаад хэргийн сайдыг хүндэтгэн Гадаад хэргийн сайд зоог барина.

-Хүндэтгэлийн зоогийн эхэнд Гадаад хэргийн сайд, гадаад улсын Гадаад хэргийн сайд нар харилцан үг хэлж, хундага өргөнө.

-Ширээн дээр кувертийн хуудас, зоогийн цэс, урлагийн тоглолтын хөтөлбөр байна. Зоогийн үеэр мэргэжлийн урлагийн хамтлаг үндэсний болон сонгодог дуу, хөгжмийн бүтээлээс тоглож болно.

50.5. Гадаад улсын Гадаад хэргийн сайдын ажлын айлчлал

50.5.1. Гадаад улсын Гадаад хэргийн сайд ажлын айлчлал хийхээр ирэх, буцахад Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нисэх буудалд угтаж, үднэ.

50.5.2. Гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсад ажлын айлчлал хийх хугацаанд Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал байнга дагалдана.

50.5.3. Монгол Улсад ажлын айлчлал хийж байгаа гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсын Гадаад хэргийн сайдтай хэлэлцээ, ажлын уулзалт хийнэ.

50.5.4. Гадаад хэргийн сайдыг Ерөнхий сайдад, шаардлагатай гэж үзвэл Ерөнхийлөгчид бараалхуулж болно.

50.5.5. Баримт бичигт гарын үсэг зурах ёслол үйлдэж болно.

50.5.6. Монгол Улсын Гадаад хэргийн сайд ажлын айлчлал хийж байгаа гадаад улсын Гадаад хэргийн сайдад ажлын зоог барина.

50.6. Гадаад улсын Гадаад хэргийн сайдын хувийн айлчлал

50.6.1. Гадаад улсын Гадаад хэргийн сайд, түүний гэргий /нөхөр/ Монгол Улсад хувийн айлчлал хийхээр ирэх, буцахад тэднийг нисэх буудалд Ёслолын газрын захирал угтаж, үднэ.

50.6.2. Монгол Улсын Гадаад хэргийн сайд хувийн айлчлал хийж буй гадаад улсын Гадаад хэргийн сайдтай уулзаж, зоог барина.

50.7. Гадаад Улсын Гадаад хэргийн сайд дамжин өнгөрөх

50.7.1. Гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тохиолдолд Монгол Улсын Гадаад хэргийн дэд сайд, эсхүл Төрийн нарийн бичгийн дарга нисэх буудалд очиж хүндэтгэл илэрхийлнэ.

51. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын айлчлал

51.1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Монгол Улсын Гадаад хэргийн сайдын урилгаар айлчилна.

51.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргыг гадаад улсын Гадаад хэргийн сайдын албан ёсны айлчлалын ёслолын журмын дагуу Монгол Улсад хүлээн авч айлчлуулна.

52. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн болон Засгийн газар хоорондын олон улсын бусад байгууллагын тэргүүний айлчлал

52.1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн болон Засгийн газар хоорондын олон улсын бусад байгууллагын тэргүүн тухайн асуудлыг эрхэлсэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн-сайдын урилгаар айлчилна.

52.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн болон Засгийн газар хоорондын олон улсын бусад байгууллагын тэргүүнийг гадаад улсын Гадаад хэргийн сайдын ажлын айлчлалтай адилтгах түвшинд хүлээн авч айлчлуулна.

52.3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн болон Засгийн газар хоорондын олон улсын бусад байгууллагын тэргүүний айлчлалыг төрийн захиргааны холбогдох төв байгууллага эрхлэн зохион байгуулна. Гэхдээ айлчлалтай холбоотой аливаа асуудлаар Гадаад хэргийн яамтай урьдчилан хэлэлцэн тохирно.

53. Гадаад улсын төрийн болон Засгийн газрын тэргүүний бие төлөөлөгчийн айлчлал

53.1. Гадаад улсын төрийн болон Засгийн газрын тэргүүний бие төлөөлөгч Монгол Улсад айлчлахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын зөвлөх угтаж, үднэ.

53.2. Гадаад улсын төрийн тэргүүний бие төлөөлөгчийг Монгол Улсын Ерөнхийлөгчид, Засгийн газрын тэргүүний бие төлөөлөгчийг Монгол Улсын Ерөнхий сайдад бараалхуулж болно.

53.3. Гадаад улсын төрийн тэргүүний бие төлөөлөгчийг Монгол Улсын Гадаад хэргийн сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нар тус тус хүлээн авч уулзаж болно.

53.4. Гадаад улсын төрийн тэргүүний бие төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга зоог барина.

53.5. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний бие төлөөлөгчийг Монгол Улсын Гадаад хэргийн сайд хүлээн авч уулзана. Шаардлагатай гэж үзвэл холбогдох сайд, бусад удирдах албан тушаалтантай уулзуулж болно.

53.6. Монгол Улсын Гадаад хэргийн сайд эсхүл Засгийн газрын холбогдох гишүүн гадаад улсын Засгийн газрын тэргүүний бие төлөөлөгчид зоог барина.

54. Гадаад улсын төр, парламент, Засгийн газрын тэргүүн асан хүний айлчлал

54.1. Гадаад улсын Төрийн тэргүүн, Парламентын дарга, Засгийн газрын тэргүүний алба хашиж байсан хүн /цаашид “тэргүүн асан” гэх/ Монгол Улсад албан ёсны урилгаар айлчлахад Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зөвлөх угтаж, үднэ.

54.2. Монгол Улсын Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга хүлээн авч уулзаж, хүндэтгэн зоог барина.

54.3. Тэргүүн асныг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын аль нэгэнд бараалхуулж болно.

54.4. Тэргүүн асанд зохих ёслол, хүндэтгэлийг үзүүлнэ. Тухайн улсын Төрийн далбааг аливаа газарт мандуулахгүй.

55. Гадаад улсын Төрийн тэргүүний угсаа залгамжлах ханхүү, гүнжийн айлчлал

55.1. Гадаад улсын Төрийн тэргүүний угсаа залгамжлах Ханхүү, Гүнжийн Монгол Улсад хийх айлчлалын түвшин, хөтөлбөрийг хоёр тал урьдчилан тохирно.

55.2. Гадаад улсын Төрийн тэргүүний угсаа залгамжлах Ханхүү, Гүнжийн Монгол Улсад айлчлахад нисэх буудалд Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга угтаж, үднэ.

55.3. Гадаад улсын Төрийн тэргүүний угсаа залгамжлах Ханхүү, Гүнжийн Монгол Улсад айлчлахад Гадаад хэргийн сайд хүлээн авч уулзан, зоог барина. Шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхуулж болно.

55.4. Гадаад улсын Төрийн тэргүүний угсаа залгамжлах Ханхүү, Гүнжийн Монгол Улсад айлчлахад Ерөнхийлөгчийн зөвлөх дагалдана.

55.5. Гадаад улсын Төрийн тэргүүний угсаа залгамжлах Ханхүү, Гүнжийн Монгол Улсад айлчлахад байрлах буудал, хөлөглөх машинд тухайн хүнд хамаарах далбааг мандуулж болно.

55.6. Хаант засаглалтай гадаад улсын Төрийн тэргүүн Хаан, Хатан хааны гэр бүлийн гишүүд Монгол Улсад айлчлахад зохих ёслол, хүндэтгэлийг үзүүлнэ.

56. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төр, Парламент, Засгийн газрын тэргүүний айлчлал

56.1. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төр, Парламент, Засгийн газрын тэргүүний Монгол Улсад хийх албан ёсны болон ажлын айлчлалыг гадаад улсын төрийн өндөр албан тушаалтны түвшний айлчлалд хамааруулна.

56.2. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төр, Парламент, Засгийн газрын тэргүүнийг нисэх буудалд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга нар тус тус угтана.

56.3. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төрийн тэргүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчид, Парламентын даргыг Улсын Их Хурлын даргад, Засгийн газрын тэргүүнийг Ерөнхий сайдад тус тус бараалхуулж болно.

56.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Бүгд найрамдах улсын төрийн тэргүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн сайд Бүгд найрамдах улсын Засгийн газрын тэргүүнд, Улсын Их Хурлын дэд дарга Бүгд Найрамдах Улсын парламентын даргад тус тус зоог барьж болно.

56.5. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төр, парламент, Засгийн газрын тэргүүний байрлах байр, хөлөглөх унаанд тухайн Бүгд найрамдах улсын далбааг мандуулж болно.

56.6. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төр, парламент, Засгийн газрын тэргүүн уулзалт, хэлэлцээ хийх, баримт бичигт гарын үсэг зурах ёслолд оролцох тохиолдолд Монгол Улсын болон тухайн Холбооны Улсын Төрийн далбаа, тухайн Бүгд Найрамдах Улсын далбааг мандуулж болно. Харин Монгол Улсын Төрийн далбааг тухайн Бүгд найрамдах улсын далбааны хамт мандуулж болохгүй.

56.7. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төр, парламент, Засгийн газрын тэргүүн Монгол Улсад айлчлахад Ерөнхийлөгчийн тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус тусын чиглэлээр, Ёслолын газрын дэд захирал дагалдана.

56.8. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төр, парламент, Засгийн газрын тэргүүн Монгол Улсад айлчлахад тусгай машинаар үйлчилнэ. Шаардлагатай тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын газар бие хамгаалагч гаргана. Цагдаагийн байгууллага хөтөч машин гаргаж үйлчилнэ.

57. Төрийн ёслолын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх

57.1. Дипломат ёслолын аливаа арга хэмжээг олон нийтэд мэдээлэх асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэвлэл мэдээллийн алба, Гадаад хэргийн яамны хэвлэл, мэдээллийн асуудал эрхэлсэн нэгж тус тус хариуцан зохион байгуулна.

57.2. Дээд, өндөр түвшний айлчлалыг хоёр тал тохиролцсон хугацаанд айлчлал эхлэхээс өмнө мэдээлэх бөгөөд айлчлалын явцыг тухай бүр мэдээлнэ. Гадаад хэргийн яамны удирдлага, гадаад бодлогын зөвлөх, хэвлэлийн төлөөлөгч, холбогдох газрын захирал нар айлчлалын дүнгээр хэвлэлийн бага хурал хийнэ.

57.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын гадаад улсад хийх айлчлалыг сурвалжлах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэсэг дагалдан явах бөгөөд Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэвлэл, мэдээллийн алба энэ ажлыг хариуцан зохион байгуулна. Хэвлэл, мэдээллийн бусад төлөөлөгчийн холбогдох зардлыг тухайн хэвлэл, мэдээллийн байгууллага хариуцна.

57.4. Монгол Улсад хүлээн авах дээд, өндөр түвшний айлчлалыг сурвалжлах ажлыг Гадаад хэргийн яамны хэвлэл, мэдээллийн асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулна. Айлчлалыг сурвалжлах зорилгоор ирсэн гадаад улсын болон

олон улсын хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчдийг хүлээн авч, зохион байгуулах ажлыг тус газар мөн хариуцна.

57.5. Монгол Улсын төрийн дээд албан тушаалтан, Гадаад хэргийн сайдаас гадаад улсын төр, парламент, засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайдад баяр хүргэсэн, эмгэнэл илэрхийлсэн, түүхт ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан цахилгаан утас солилцсон, тэдгээрийн олон улсын хурал бусад арга хэмжээнд оролцсон, үг хэлсэн тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

57.6. Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн Итгэмжлэх жуух бичиг, Итгэмжлэх захидлаа гардуулсан тухайг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

57.7. Төрийн дээд албан тушаалтанд Элчин сайд, Байнгын төлөөлөгч, гадаадын төлөөлөгчид бараалхсан уулзалтын тухай нийтэд мэдээлнэ.

57.8. Төрийн дипломат ёслолын үйл ажиллагааг гэрэл зураг, дүрс бичлэг болон бусад баримт бичгээр баримтжуулах, архивт хадгалуулах ажлыг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад хэргийн яам тус тус гүйцэтгэнэ.

58. Хувцаслалт

58.1. Төрийн ёслолын үйл ажиллагаанд оролцогсад албан ёсны, цэргийн ёслолын болон үндэсний хувцастай байх бөгөөд урилгад заасны дагуу хувцаслана. Дүрэмт хувцастай төрийн албан хаагч ёслолын дүрэмт хувцсаа өмсөж оролцоно.

58.2. Хувцаслалтыг тухайн үйл ажиллагааны урилгад тусгайлан заасан бол түүний дагуу хувцаслана.

58.3. Төрийн ёслолын үйл ажиллагаанд оролцохдоо Монгол Улсын болон гадаад орны одон, медалийг зүүж болно.

59. Бусад зүйл

59.1. Төрийн ёслолын үйл ажиллагаанд оролцох хүмүүс цагийг чанд баримтална. Төрийн ёслолын алба, Ёслолын газраас уг үйл ажиллагаанд оролцох талаар өгсөн зөвлөмжийг баримтлах үүрэгтэй.

59.2. Монгол Улсын иргэн, төрийн албан хаагч, төрийн болон төрийн бус байгууллага, Төрийн ёслолын журмаар хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлж, энэ талаар Төрийн ёслолын алба, Ёслолын газартай хамтран ажиллах үүрэгтэй.

59.3. Төрийн ёслолын алба, Ёслолын газар Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд төрийн ёслолын асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгнө.

59.4. Гадаад хэргийн яам энэ журамд заасан дипломат ёслолын үйл ажиллагааг тухайн цаг үеийн онцлог, гадаад улс, олон улсын байгууллагын ёслолын журам, олон улсын харилцааны тухайн үеийн дэгт нийцүүлж, уян хатан хэрэгжүүлж болно.

59.5. Энэ журмаар зохицуулагдаагүй бусад айлчлал, арга хэмжээг энэ журмын холбогдох заалтаар жишин зохицуулна.

oOo